- /484./ Бүдүүн гэдсэнд аль гажиг нь зонхилон тохиолддог вэ?
- A. Болезнь Гиршпрунга
 - B. Долихоколия
 - C. Долихосигма
 - D. Атрезия, стеноз
 - E. Колопатия
- /485./ Өтгөн хатах, гэдэс дүүрэх, хэвлий орчим өвдөх, бие сулрах зэрэг нь аль өвчний үед гарах магадлал өндөртэй вэ?
- A. Гиршпрунгийн өвчин
 - B. Бүдүүн гэдэсний өмөн үү
 - C. Бүдүүн гэдсэнд ур ургах
 - D. Кологен колостаз
 - E. Шулуун гэдэсний колостаз
- /486./ Хүндээр бие засах үед хошногт маш хүчтэй өвдөлт илрэх нь аль эмгэгийн байх вэ?
- A. Цочмог шамбарам

- B. Шамбарамын судасны бөглөрөл
- C. Шамбарамын зангилаа хавчигдах ба унжих
- D. Шулуун гэдэсний амсрын салст язрах
- E. Цочмог парапроктит

/487./ Парапроктитийн халдвар орохгүй зам нь аль вэ?

- A. Шулуун гэдэсний салстын бичил гэмтэл
- B. Хошногоны булчирхай
- C. Цусны замаар
- D. Гадны гэмтэл
- E. Шулуун гэдсээр

/488./ Цочмог парапроктитийн эмчилгээ аль нь вэ?

- A. Сульфаниламидын бэлдмэлүүдээр эмчлэх
- B. Хатгалт хийж эмчлэх
- C. Мэс заслын эмчилгээ
- D. Фистулэктоми
- E. Хордлого тайлах шинж тэмдгийн эмчилгээ

/489./ Хэвлийн шулуун булчингийн хальсны уутанд цус хурахад илрэх анхны онцлог шинж аль нь вэ?

- A. Хоолны дур муудаж, дотор эвгүй оргих
- B. Бөөлжих
- C. Хэвлийн урд хананд овгор зүйл тэмтрэгдэх
- D. Даралт буурч, тахикарди илрэх
- E. Хэвлийгээр гэнэт хүчтэй өвдөх

/490./ 60настай эмэгтэйн их сэмжинд 6 см орчим үүсгэвэртэйг оношложээ. Аль онош нь илүү оновчтой вэ?

- A. Гемангиома
- B. Леймиом
- C. Липом
- D. Карциномын метастаз
- E. Нейрофибром

/491./ Барийг 12 хуруу гэдэс рүү шууд хаймсуурын тусламжтай оруулахад хэвийн үед хэдэн цагийн дараа мухар гэдсэнд хүрэх вэ?

- A. 1.5 цаг хүртэл
- B. 2.5-2 цаг хүртэл
- C. 3-4 цаг
- D. 5-6 цаг
- E. 7-8 цаг

/492./ Хаалган венийн даралт ихсэх хам шинжийн зонхилох шалтгааныг заана уу.

- A. Бадда - Киорийн хам шинж
- B. . Киарийн өвчин
- C. Элгэн доторх цусны урсгалын сааталтай элэгний хатуурал
- D. Сентын гурвал эмгэг
- E. Элэгний өмнөх цусны урсгалын саатал

/493./ Элэг доторх хаалган венийн даралт ихэссэний улмаас улаан хоолойн хураагуурсудаснаас цус алдаж буй үед хийх зохистой мэс засал нь юу вэ?

- A. Улаан хоолойн хураагуур судсыг оёх
- B. Хаалган венийгдоод хөндий вени-тэй залгах
- C. Дэлүү авах
- D. Улаан хоолойн хураагуур судсанд хатууруулах эмчилгээ хийх
- E. Улаан хоолойд Блекморын гуурставих

/494./ Элэгний буглаа үүсэхэд халдвар аль замаар зонхилон дамжих вэ?

- A. Нойр булчирхайн замаар
- B. Хаалган венээр
- C. Тунгалгийн замаар
- D. Цөсний замаар
- E. Ходоод, тэдэсний замаар

/495./ Баруун талын сүврэгсэд дагуу доргиоход өвдөлт илрэх шинж:

- A. Боткины шинж
- B. Орднерын шинж
- C. Крюковын шинж
- D. Мерфийн шинж
- E. Барлоугийн феномен

/496./ Элэгний сегментийн /хэрчмийн/ тоог Cowpuad-ынхаар заана уу.

- A. 12 сегмент
- B. 10 сегмент
- C. 8 сегмент
- D. 7 сегмент
- E. 6 сегмент

/497./ . Элэгний паразитын бус гаралтай элбэг тохиолддог уйланхай нь аль вэ?

- A. Төрөлхийн жинхэнэ уйланхай
- B. Хуурамч уйланхай
- C. Өвөрмөц
- D. Төрөлжсөн гемангиома.
- E. Өвөрмөц бус

/498./ Элгэнд элбэг тохиолддог паразитын гаралтай голомтот эмгэгийг заана уу.

- A. Эхинококкоз
- B. Дифиллоботриоз
- C. Энтеробиоз
- D. Альвеококкоз
- E. Амебиоз

/499./ Элэгний уйланхай оношлох аргыг сонгоно уу.

- A. Каццонийн урвал
- B. Тоймлосон рентгений шинжилгээ
- C. . Хэт авианы шинжилгээ
- D. Трансумбиликалийн портогепатограф
- E. Изотопын хуулбарлал

/500./ Элэгний бэтэгтэй өвчтөний цусны шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?

- A. Лейкоцитоз
- B. Лейкопени
- C. Эозинофилез
- D. СОЭ өндөр
- E. Лимфопени

/501./ 50 настай эмэгтэй халуунтай, биеийн өнгө шар, баруун хавирганы нумаар базалжөвдөнө гэсэн зовиуртай хэвтсэн. Энэ ямар эмгэг байж болох вэ?

- A. Амёбный абсцесс
- B. Острый гепатит
- C. Острый панкреатит
- D. Холангит
- E. Острый гастроуденит

/502./ Элэгний хатингаршилт, улаан хоолойн өргөссөн судаснаас цус алдах үеийн үхлийншалтгаан нь аль вэ?

- A. Цус алдалтын шок
- B. Элэг-бөөрний дутагдал
- C. Цус алдалтын дараах цус багадалт
- D. Элэгний даамжирсан дутагдал
- E. Бөөрний дутагдал

/503./ Цөсний цочмог үрэвслийн хамгийн тод шинж тэмдгийг сонгоно уу.

- A. Ортнерын шинжтэмдэг
- B. Мерфийн шинжтэмдэг
- C. Цагаан эс өндөр түвшинд хүрэх
- D. Чугуевын шинж тэмдэг
- E. Шарлах

/504./ Механик шар үүсгэдэг шалтгаан нь аль вэ?

- A. Фатерев хөхлөгт чулуу тээглэх
- B. Нойр булчирхайн цочмог эвдрэлт үрэвсэл
- C. Цөсний хүүдий сунах
- D. Фатерев хөхлөгийн зогсонго
- E. Цөсний замын лямблиоз

/505./ 75 настай эрэгтэй механик шартай эмнэлэгтхэвтсэн, Механик шарын шалтгааныг олохын тулд аль шинжилгээний аргыг сонгох вэ?

- A. Дурангаар ретроград холангиопанкреатографи /ERCP/
- B. Элгэнд гаднаас нь хатгаж холангиографи хийх
- C. Хэт авиа
- D. Компьютер-томөграфи
- E. Тэмдэгт атомын шинжилгээ

/506./ Механик шарын ЭХО шинж ямар байх вэ?

- A. Элэгний эдийн ЭХО ойлт ихсэх
- B. Цөсний хүүдийн хана зузаарч том болно.
- C. Элгэн доторх Цөсний зам өргөснө.
- D. Цөсний ерөнхий цорго хэвийн байна.
- E. Цөсний хүүдийд чулуу харагдана.

/507./ Ямар шалтгааны улмаас үүссэн механик шард дурангаар мэс засал хийх

- A. Нойр булчирхайн толгойн хавдар
- B. Цөсний ерөнхий цоргын хавдар
- C. Фатеровын хөхлөгийн хавдар
- D. Цөсний элэгний цоргын чулуу
- E. Оддын хуниас сорвижин нарийсах

/508./ Гэнэт өвдөлтийн дараагаар шарласан, элэг бага зэрэг томорсон, цөсний хүүдий үл мэдрэгдэнэ, шээс хар хүрэн өнгөтэй, баас цайвар, билирубин бага нэмэгдсэн тохиолдолд ямар төрлийн шарлалтанд тохирох вэ?

- A. Цуллагын
- B. Бөглөрөлтийн
- C. Цусны
- D. Цус сэлбэсний
- E. Хавсарсан

/509./ Цөсний хурц үрэвслийн улмаас цөс нь хагарч, хэвлийн хөндий руу тарсан үед аль шинж нь илрэх вэ?

- A. Арьс салст шарлаж, элэг томорч өвчтөн сепсисийн байдалд шилжих
- B. Хэвлийн гялтангийн түгээмэл үрэвсэл
- C. Хэвлийн баруун сүврэгдэсийн булчин чангаран, халуун нэмэгдэхгүй цөсний хүүдий тэмтрэгдэнэ.

- D. Баруун хавирган доорх хэсгийн гялтангийн үрэвслийн шинж илэрнэ.
- E. Хоёрдогч холангит, панкреатит, механик шарлалт илрэх

/510./ Аль нь эвдрэлтэй цөсний цочмог үрэвслийн шинж вэ?

- A. Үе үе халуурах, шарлах, элэг томрох
- B. Хэвлийн гялтангийн түгээмэл үрэвслийн шинж илрэх
- C. Өвчтөний мэдүүлгээр хурц өвдөлтөөр эхэлсэн, баруун хавирган доор өвдөлт багатай цөсний хүүдийн хэмжээ томорсон нь тэмтрэгдэнэ. Биеийн халуун хэвийн.
- D. Хэсгийн гялтангийн үрэвслийн шинж илэрнэ. Гэдэсний саажилтын шинжтэй.
- E. Элэгний орчим хүчтэй өвдөж, арьс салст нь шарласан баруун сүврэгтэсэмзэглэлтэй тэр хэсэгт булчин нь чангарсан.

/511./ Цөсийг авсаны дараах хам шинж нь юунаас хамаарах вэ?

- A. Элэгний хавдар
- B. Гепатит
- C. Элэгний цирроз
- D. Элэгний том уйланхай
- E. Цөсний сувгийн урттайрдас

/512./ Цөсний замын сфинктерийн үйл ажиллагааг зохицуулах эмийг нэрлэ.

- A. Но-шпа
- B. Церукал
- C. Фүразолидон
- D. Фенол
- E. Холезин

/513./ Цөсний цочмог үрэвслийг голчлон үүсгэдэг шалтгаан нь:

- A. Цөсний хүүдийн цоргын бөглөрөл
- B. E. Coli халдвар
- C. Паразитын халдвар
- D. Цөсний хүүдийн олон жижиг чулуу
- E. Сальмонеллын халдвар

/514./ 2 см хүртэл хэмжээтэй цөсний ерөнхий сувганд байх цөөн тооны чулууг мэс ажилбараар хэрхэн авах вэ?

- A. 12 хуруу гэдэс дамжиж хөхлөгийг огтлох
- B. Цөсний ерөнхий суваг нээж + сувгаар гуурс тавих
- C. Дурангаар хөхлөгийг зүсэх
- D. Цөсний суваг нүхлэх+Цөсний ерөнхий сувгийг нарийн гэдэстэй холбох
- E. Цөсний ерөнхий сувгийг 12 хуруу гэдэстэй холбох

/515./ Цөсний ерөнхий сувагт чулуу тээглэн 2 см-ээс илүү хэмжээгээр тэлэгдсэн тохиолдолд аль мэс заслын арга нь зохимжтой вэ?

- A. 12 хуруу гэдэс дамнаж хөхлөгийг зүсэх
- B. Цөсний суваг нээж + сувагт гуурс тавих
- C. Дурангаар хөхлөгийг зүсэх
- D. Цөсний ерөнхий сувгийг нарийн гэдэстэй залгах
- E. Цөсний ерөнхий сувгийг 12 хуруу гэдэстэй залгах

/516./ Цөсний суваг төгсгөл хэсэгтээ нарийсч, цөсний ерөнхий сувагны голч 2 см-ээс өргөссөн үед хийх тохиромжтой мэс засал нь аль вэ?

- A. А 12 хуруу гэдэс дамнаж хөхлөгийг зүсэх
- B. Цөсний ерөнхий суваг нээж, сувгаар гуурс гадагшлуулах
- C. Дурангаар хөхлөгийг зүсэх
- D. Цөсний ерөнхий сувгийг нарийн гэдэстэй залгах
- E. Цөсний ерөнхий цоргыг 12 хуруу гэдэстэй залгах

/517./ Холедохын өргөний хэмжээ:

- A. 0.3-0.5 см
- B. 0.6-1 см
- C. 1.1-1.5 CM
- D. 1.6-2 CM
- E. 2-3 CM

/518./ Фатеров хөхлөг хаана байрладаг вэ?

- A. 12 хуруу нугалаа гэдэсний нугалаанаас 2см доор
- B. 12 хуруу нугалаа гэдэсний уруудах хэсгийн ар гадна гадаргууд
- C. 12 хуруу нугалаа гэдэсний нугалаанаас доош 8 см-т
- D. 12 хуруу нугалаа гэдэсний уруудах хэсгийн төгсгөлд
- E. 12 хуруу нугалаа гэдэсний нугалаанаас 4см-ийн доор

/519./ Орчин цагийн сонгомол төхөөрөмж ашиглаж хэтавиагаар шинжилгээнийхэд хэвийн ажиллагаатай цөсний хүүдийн давтамжийн илрүүлэлтийг заана уу.

- A. 97-99%
- B. 95-98%
- C. 92-96%
- D. 90-94%
- E. 93-95%

/520./ Амилуулах тусламжийн дараалалын товчлол аль нь вэ?

- A. ABCD
- B. ABC
- C. SABD
- D. CAB

E. CABD

/521./ Ухаангүй байдлыг яаж тодорхойлвол дээр вэ?

- A. Чихнээс чимхэх, өвтгөж үзэх
- B. Нүүр лүү нь алгадах, мөрнөөс нь сэгсрэх
- C. Дээрээс нь хүйтэн ус асгах
- D. Өвчтөнд энгийн тушаал өгөх, мөрнөөс нь сэгсрэх, өвтгөж үзэх
- E. Өвчтний даралтыг хэмжиж үзэх

/522./ Үхэдхийн унасан хүнд юуг шалгаж амилуулах тусламж үзүүлэхийг шийдэх вэ?

- A. Судасны лугшилт байгаа эсэх
- B. Ухаан санааны байдал, амьсгал буйг шалгах
- C. Судасны лугшилт, артерийн даралт үзэх
- D. Ухаан санааны байдал, хүүхэн харааны байдлыг шалгаж
- E. Артерийн даралт үзэх

/523./ Амилуулах суурь тусламжийг хэн үзүүлэх вэ?

- A. Эмч, сувилагч
- B. Эмнэлгийн бүх ажилчид
- C. Насанд хүрсэн бүх хүн
- D. Эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын албан хаагч
- E. Дэргэд нь байгаа хэн бололцоотой нь

/524./ Ухаангүй амьсгалтай өвчтөнг орхиж явахаар бол яах вэ?

- A. Орхиод явна
- B. Толгойг нь гэдийлгээд эрүүг нь өргөнө баруун хажуугаар хэвтүүлнэ
- C. Хажуу тийш нь харуулж хэвтүүлээд дээд гарыг нь дэрлүүлж дээд хөлөөр нь тулж толгойг гэдийлгэн хэвтүүлнэ
- D. Түрүүлгэнэ харуулан хэвтүүлж орхино
- E. Хажуу тийш нь харуулж хэвтүүлнэ

/525./ Амилуулах тусламж үзүүлэхэд цээжний шахалтын гүн насанд хүрэгчдэд хэдэн см вэ?

- A. 4 см дээш
- B. 3 см орчим
- C. Хамгийн багадаа 6 см
- D. Хамгийн багадаа 5 см
- E. 4 см

/526./ Амилуулах тусламжийн цээжний шахалт амьсгалын харьцаа хэд вэ

- A. 2:30
- B. 30:2
- C. 15:2
- D. 2:15
- E. 15:1

/527./ Амилуулах суурь тусламжийн үед Цээжний шахалтыг хамгийн багадаа хэдэн секунд завсарлах вэ?

- A. 10 сек
- B. 20 сек
- C. 30 сек
- D. 40сек
- E. 15 сек

/528./ Амилуулах суурь тусламжийн үед боломжтой бол аврагчийг хэдэн минут тутамд солих вэ?

- A. 1 мин
- B. 2 мин
- C. 3 мин
- D. 4 мин
- E. 5 мин

/529./ Насанд хүрэгчдийн амьсгалын замыг чөлөөлөх энгийн арга

- A. Эрүүг өргөх, толгойг өргөх
- B. Толгойг гэдийлгэн, хэлийг татах
- C. Толгойг гэдийлгэн эрүүг өргөх

D. Толгойг гэдийлгэн, амыг ангайлгах

E. Толгойг гэдийлгэх

/530./ Хохирогчийн амьсгал шалгах энгийн арга

A. Цээж хөдлөж буйг харах, амнаас агаар гарч байгааг сонсох, мэдрэх

B. Хамар, аманд утас ойртуулж харах, гараар цээжин дээр дарж мэдрэх

C. Хэвлий цээжний хөдөлгөөнийг сайтар харах, хамарт гараа ойртуулах

D. Өвчтний аманд лаа ойртуулж дөл нь хөдлөх эсэхийг харах

E. Өвчтөний хамарт гараа ойртуулах

/531./ Нярай хүүхдийн амьсгалын замыг чөлөөлөхөд та заавал

A. Толгойг гэдийлгэх, эрүүг өргөх, далан доор эвээс хийх

B. Амыг ангайлган, эрүүг өргөх

C. Үнэрлэх байрлалд оруулан, толгой доор эвээс хийх

D. D. Толгой хүзүү, цээжийг дундаж байрлалд оруулах

E. Толгойг гэдийлгэх

/532./ Хүзүүний гэмтэлтэй хүнд амьсгалын зам чөлөөлөх энгийн арга:

A. Толгойг гэдийлгэн эрүүний шонтонгоос өргөх

B. Толгойг хөдөлгөөнгүй бэхлэн эрүүг доош нь болгох

C. Хүзүүг хөдөлгөөнгүй бэхлэн эрүүний өнцгөөс өргөх

D. Толгойг хөдөлгөөнгүй бэхлэн барьж эрүүний өнцгөөс өргөн амыг ангайлгах

E. Толгойг бөхтийлгөх

/533./ Автомат тохируулгат дефибрилляторыг ховдлын жирвэлзлийн үед хэдэн минутын давталттай хэрэглэх вэ?

A. 1 мин

B. 2 мин

C. 3 мин

D. 4 мин

E. 5 мин

/534./ Мориноос тонгорч унасан ухаангүй хүнд таны нэн түрүүнд үзүүлэх тусламж юу вэ?

1. Өргөж байгаад сэгсэрнэ

2. Амьсгалын замыг чөлөөлж амьсгал өгнө

3. Цээжинд шахалт хийнэ

4. Хүзүүний бэхэлгээ хийж амьсгалын зам чөлөөлнө

5. Тусламж дуудна

/535./ Ухаангүй өвчтөнд хамгийн түрүүнд үзүүлэх тусламж аль нь вэ?

A. А. Аюулыг зайлуулах

B. В. Хариултыг шалгах

C. С. Тусламж дуудах

D. D. Цээжинд шахалт хийх

E. Е. Амьсгалын зам чөлөөлж амьсгал өгөх

/536./ Цээжний шахалтыг нэг минутанд хэдэн удаа хийх вэ?

A. Нярайд 120, Хүүхдэд 100, том хүнд 70

B. Нярайд 100, Хүүхдэд 90, том хүнд 80 удаа

C. Бүх насанд адилхан 100-120

D. Нярайд 120, Хүүхдэд 100, том хүнд 100

E. Нярайд 100, Хүүхдэд, том хүнд 90

/537./ Цусны эргэлтийг шалгах анхны тусламжинд сонгох арга

A. Цээжийг чагнах

B. Хялгасан судасны эргэн дүүрэлтийг шалгах

C. Гүрээний артер дээр тэмтрэх

D. Өвчтөн хяналтын монитор холбох

E. Дээрх бүгд зөв

/538./ Цээж шахалт хийхдээ

A. Хатуу гадаргуу дээр хэвтүүлж 2 удаа амьсгал өгнө

B. Өвчүүний доод $1/3$ дээр гараа байрлуулж тохойн үеэр шулуун байлгаж цээжний хүчээр дарах

C. Өвчүү хавирганы заагт гараа байрлуулж атган хийнэ

D. Өвчүүний голд гараа байрлуулж гаран дээрээ гараа давхарлан шахалтын гүн 8 см байхаар шахна

E. Өвчүүний голд гараа байрлуулж гаран дээрээ гараа давхарлан шахалтын гүн 6 см байхаар шахна

/539./ Хүчдэлт пневмотораксын үед зайлшгүй шаардлагатай нь:

A. Хүчилтөрөгч эмчилгээ

B. Зохиомол амьсгал

C. Цээжний гялтангийн хөндийд хатгалт хийх

D. Зүрхэнд нөлөөлөх бэлдмэл хийх

E. Судас нарийсгагч хэрэглэх

/540./ Амилуулах лавшруулсан тусламжинд хэрэглэх гол эм:

A. Лидокайн

B. Дигоксин

C. Атрофин

D. Адреналин

E. Кальци хлорид

/541./ Архины хордлоготой ухаангүй хүнд нэн түрүүнд юу хийх вэ?

A. Шингэн сэлбэх

B. Анальгин , димедрол

C. Глюкоз, B1

D. B6

E. Реополиглюкин

/542./ Ухаангүй хүнд сийвэнгийн чихэр үзэх боломжгүй бол глюкоз хэдэн граммыг тарьдаг вэ?

A. 25гр

B. 50гр

C. 60гр

D. 40гр

E. 10гр

/543./ Хоёр хөлийн шилбэний хугаралтай шокийн байдалтай өвчтөнг эмнэлэгт хүргэхийн тулд зайлшгүй авах арга хэмжээ нь:

1. Цус алдалтыг зогсоох

2. Хөлийг хөдөлгөөнгүй бэхлэх

3. Хөлийг өндөрлөх

4. Шингэн сэлбэх

5. Өвдөлт намдаах

/544./ Цус ихээр алдсан шокийн байдалтай үед авах нэн түрүүний эмчилгээ:

1. Коллоид уусмал сэлбэх

2. Ижил бүлгийн цус, сийвэн сэлбэх

3. Допамин дусалд хийж урсгах

4. Кристаллоид уусмал сэлбэх

5. Адреналин судсаар тарих

/545./ Тархи нугасны шингэнийг хэдийд шинжлэх вэ

1. Менингийн шинж илэрсэн үед

2. КТГ хийсний дараа

3. Цус харваснаас хойш 12 цагийн дараа

4. Онош тодруулах зорилгоор

5. Тархи, нугасны хөндийн даралтыг хэмжих зорилгоор

/546./ Цус харвалттай өвчтөнийг хурдан үнэлэх Цинциннати үнэлгээ дугуйл :

1. Хэл яриа

2. Гарын хүч

3. Царайны илрэл

4. Артерийн даралт

5. Ухаан санааны байдал муудах

/547./ Тархины хаван буулгах зорилгоор ямар арга хэмжээг хамгийн эхлэн авах вэ?

A. Орны толгойг өндөрлөх

- В. Фуросемид хийх
- С. Дексаметазон хийх
- Д. Маннитол хийх
- Е. Полиглюкин хийх

/548./ Тархины эдийн цус харвалттай өвчтний артерийн даралтыг барих түвшин

- А. Ирсэн түвшингөөс нь 30%-аар буулгах
- В. Хэвийн хэмжээнд хүртэл буулгах
- С. Агшилтын даралтыг 140-160 мм МУБ-ын хооронд барих
- Д. Артерийн даралтыг 40 мм МУБ-аар бууруулах
- Е. Артерийн даралтыг 20 мм МУБ-аар бууруулах

/549./ 60 настай эрэгтэй АД ихэсдэг.Сүүлийн үед даралт тогтвортой өндөр байгаа. Эхнэрийнхээ даралтын эмнээс уусан.Толгой эргэж дотор муухайрч огиулсан, амьсгал давчдана .Үзлэгээр тайван бус, хүйтэн хөлс нь гарсан, цонхийж цайсан, мөчид хүйтэн чийглэг, артерийн даралт буурсан, брадикардтай (40). Энэ ямар шокийн хэлбэр вэ ?

- А. Гиповолемийн шок
- В. Зүрхний шок
- С. Үжлийн шок
- Д. Анафилаксын шок
- Е. Бөглөрлийн шок

/550./ Ходоод гэдэсний замын цус алдалтын үед яаралтай эхний авах арга хэмжээ:

1. Судас агшаах эм хэрэглэх
2. Шингэн сэлбэх
3. Хүйтэн мөс залгиулах
4. Ходоод дурандах
5. Блекморын гуурс тавих

/551./ Анафилаксийн шокийн үеийн эмчилгээний эхний сонголт:

- А. Кальци хлорид
- В. Адерналин
- С. Димедрол
- Д. Дексаметазон
- Е. Анальгин

/552./ Судасны системийн ямар хэсэг нь судасны эсэргүүцлийг бүрдүүлэх вэ?

- А. Аорта
- В. Дунд калибрийн артери
- С. Вен
- Д. Капиляри
- Е. Артериол

/553./ Клиник үхэлтэй амилуулах тусламж хийгдэж байгаа өвчтөнд зүрхийг гаднаас нь шахах ажилбарын зэрэгцээ зүрхний үйл ажиллагааг сайжруулах эмийн бодисыг хийдэг. Эмийн бодисыг судсанд ямар замаар таривал хурдан үйлчлэх вэ?

- А. Захын венд
- В. Төвийн венд \эгмэн доор, гуяны, гүрээний венд\
- С. Артерид
- Д. Зүрхний хөндийд
- Е. Гарын бугалганд

/554./ Стенокардийн үед нитроглицериний үйлчлэх механизм юу вэ?

1. Өвдөлт намдаах
2. Венийн судас тэлж зүрхний өмнөх ачаалал буурна
3. Миокардын ажлын эрчим багасна
4. Титэм судлас өргөснө
5. Катехоламины хаялт эрчимтэй буурна

/555./ Уушигны хаванг буулгах зорилгоор шээс хөөх эм хэрэглэдэг. Доорх эмээс алийг нь хэрэглэх вэ?

- А. Маннитол
- В. Лазикс

- C. Верошпирон
- D. Тэхийн шээг
- E. Маннитол тарьж тэхийн шээг уулгана

/556./ Зүүн ховдлын дутагдлын эхэн үед ямар төрлийн гипокси үүсдэг вэ?

- A. Цус эргэлтийн
- B. Гемоглобины
- C. Хүчилтөрөгчгүйдлийн
- D. Эд хордлогын
- E. Эдийн

/557./ Аалзан бүрхэвчийн доорх цусан хураатай (САК-тай) өвчтөнгүүдэд түгээмэл тохиолддог эмнэлзүйн гол шинж аль нь вэ?

- 1. Уушиг хавагнах
- 2. Толгой гэнэт хүчтэй өвдөх
- 3. Нүд хялар болох
- 4. Тархины зөөлөн бүрхүүлийн цочролын шинж
- 5. Хурхирах

/558./ Зүрхний цохилтын тоо хэдээс дээш гарах үед зүрхний булчингийн цус хомсрол элбэг тохиолдох вэ?

- A. > 110 удаа/мин
- B. > 150 удаа/мин
- C. > 180 удаа/мин
- D. > 200 удаа/мин
- E. > 250 удаа/мин

/559./ Булчингийн их хэмжээний дарагдалтай өвчтөнд хамгийн олонтой тохиолддог хүндрэл юу вэ?

- A. Зүрхний дутагдал
- B. Бөөрний дутагдал
- C. Тархины хаваншил
- D. Элэгний дутагдал
- E. Бөөрний дээд булчирхайн дутагдал

/560./ Насанд хүрсэн өвчтний улаан хоолой өргөссөн венээс цус алдах үеийн яаралтай тусламжийн аргад хамаарахгүйг нь сонгоно уу?

- A. Кальцийн бэлдмэл тарих
- B. Улаан хоолойн өргөссөн венийг дурангаар боох
- C. Блек-Морын зонд тавих
- D. Дурангийн аргаар соривжуулах эмчилгээ хийх
- E. Шингэн сэлбэх

/561./ Сийвэнгийн К багасах шалтгаанд аль нь хамаарахгүй вэ?

- A. Их шээх
- B. Бөөлжих
- C. Хоол тэжээлээр орох К-ийн хэмжээ багасах
- D. Их хөлрөх
- E. Гүйлгэж суулгах

/562./ Бөөлжиж, чацга алдсан үед судсаар сэлбэх үндсэн шингэн болгон сонгон авах уусмал?

- A. Маннитол
- B. 8,4%-ийн содын уусмал
- C. Рингенийн уусмал
- D. 5% глюкоз
- E. Дескран

/563./ Чихрийн шижингийн комын эмчилгээний явцад гарч болох аюултай хүндрэлүүд юу вэ?

- A. Гипогликеми
- B. Гипокалиеми
- C. Тархины хаван
- D. Амьсгалын хямрал
- E. Бүх хариулт зөв

/564./ АсАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?

- A. Зүрхний шигдээс
- B. Баруун ховдлын дутагдал
- C. Цус задрал
- D. Вирусийн халдвар
- E. Бөөр болон тархины гэмтэл

/565./ АлАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?

- A. Зүрхний шигдээс
- B. Бөөр болон булчингийн гэмтэл
- C. Элэгний үрэвсэл
- D. Элэгний хатуурал
- E. Цус задрал

/566./ Радикулопатийн зонхилох шалтгаан юу вэ?

- A. Гэмтэл
- B. Хавдар
- C. Сүрьеэ
- D. Остеохондроз
- E. Дискийн ивэрхий

/567./ Нэрлэхийн хэлгүйдэл ямар бүтэц гэмтэхэд үүсэх вэ?

- A. Зүүн тал-бөмбөлөгийн духны доод атирааны арын хэсэг
- B. Зүүн тал-бөмбөлөгийн зулай-чамархай-дагзны уулзвар
- C. Зүүн тал-бөмбөлөгийн духны дунд атирааны арын хэсэг
- D. Зүүн тал-бөмбөлөгийн чамархайн дээд атирааны дунд, арын хэсэг
- E. Зүүн тал-бөмбөлөгийн чамархай-зулайн хэсэг

/568./ Үйлдэлгүйдэл ямар бүтэц гэмтэхэд үүсэх вэ?

- A. Зүүн тал-бөмбөлөгийн чамархайн дээд атирааны дунд, арын хэсэг
- B. Баруун тал-бөмбөлөгийн духны доод атирааны арын хэсэг
- C. Давамгайлагч тал-бөмбөлөгийн зулай-чамархай-дагзны хэсэг
- D. Зүүн тал-бөмбөлөгийн духны дунд атирааны арын хэсэг
- E. Зулайн зүүн доод дэлбэнцэрийн өнцгөн атираа

/569./ Вегетатив мэдрэлийн тогтолцооны сегментийн дээд хэсэгт аль нь орох вэ?

- A. Симпатик мэдрэл
- B. Парасимпатик мэдрэл
- C. Симпатик ба Парасимпатик мэдрэлийн тогтолцоо
- D. III, VII, IX ба X мэдрэлийн бөөмс
- E. Торлог байгууламж, гипоталамус, лимбийн тогтолцоо

/570./

Экстрапирамид системийн бүрэлдэхүүнд аль нь хамаарах вэ?

- A. Хуягт бөөм
- B. Нугасны хажуугийн эвэр
- C. Нугасны арын эвэр
- D. Таламус
- E. Арын төв атираа

/571./ Ерөнхий (тархалтат) эпилепсийн ангилалд аль хамаарах вэ?

- A. Духны эпилепси
- B. Чамархайн спайк долгионт хүүхэд насны хөнгөн эпилепси
- C. Чамархайн эпилепси
- D. Зулайн эпилепси
- E. Хүүхдийн абсанс эпилепси

/572./ Залуу насны хүмүүст тохиолдох инсультайн зонхилох шалтгаан юу вэ?

- A. Тархины судасны атеросклероз
- B. Тархины судасны аневризм
- C. Артерийн гипертензи
- D. Тархины судасны үрэвсэл
- E. Зүрхний эмгэг

/573./ Тархины эдийн цус харвалтын олон улсын өвчний код аль нь вэ

- A. I 60
- B. I 63
- C. I 61
- D. G 40
- E. G 43

/574./ Нойрны өөрчлөлтийн үед зайлшгүй хийх шинжилгээ юу вэ

- A. ЭЭГ
- B. Полисомнографи
- C. Допплеросонографи
- D. Дуудлагат потенциал
- E. MRI

/575./ Толгой өвдөлтийн зонхилох хэлбэр юу вэ?

- A. Толгойн кластер өвдөлт
- B. Хүчдэлийн толгой өвдөлт
- C. Дохиот мигрень
- D. Дохиот бус мигрень
- E. Шинж тэмдэгийн толгой өвдөлт

/576./ Өвчтөний 4 мөчинд төвийн саа үүсч, өнгөц гүний мэдрэхүй мөрний түвшингээс доош дамжих хэв шинжээр буурсан, аарцгийн эрхтэний үйл ажиллагаа хаагдсан бол гэмтлийн түвшин хаана вэ?

- A. Нугас хөндлөн T2-T4 түвшинд
- B. Тархины гүүрийн баруун хагас
- C. Нугас хөндлөн C5-T1 түвшинд
- D. Нугас хөндлөн C1-C4 түвшинд
- E. Нугасны урд эвэр C1-C4 түвшинд

/577./ Өвчтөний баруун талын хамар-уруулын нугалаас тэнэгэр, хэл баруун тийш хазгай, баруун гар хөлд төвийн саажилтай, өнгөц гүний мэдрэхүй баруун таллах хэвшинжээр буурсан бол голомт хаана вэ?

- A. Дунд тархины зүүн хагас
- B. Гүүрийн зүүн хагас
- C. Дотор капсул зүүн тал-бөмбөлөгт
- D. Нугасны баруун хагас C1-C4
- E. Уртавтар тархины зүүн хагас

/578./ Өвчтөний нүүрний баруун тал захын саатай, зүүн гар хөлд төвийн саатай бол голомт хаана вэ?

- A. Тархины урд төв атираа баруун талд
- B. Гүүрийн баруун хагас
- C. Уртавтар тархины баруун хагас
- D. Дотор капсул баруун бөмбөлөгт
- E. Зүүн чамархайн дэлбэн

/579./ Өвчтөний баруун нүдний зовхи буусан, гадагш хялар, баруун талын хүүхэн хараа өргөн, гэрлийн урвал өгөхгүй. Голомт хаана вэ?

- A. Уртавтар тархины баруун хажуу
- B. Гүүрийн баруун хагасын VII мэдрэлийн бөөм
- C. Дунд тархины баруун хагасын III мэдрэлийн бөөм
- D. Нугас уртавтар тархины уулзварын зүүн хагас
- E. Гүүр, бага тархины булан зүүн талд

/580./ Өвчтөний хэл яриа огцом сунжруу, нүдэнд хөндлөн нистагм илэрнэ, Ромбергийн зогсолтод тэнцвэр алдана. Голомт хаана вэ?

- A. Бага тархины баруун бөмбөлөг
- B. Бага тархины зүүн бөмбөлөг
- C. Тэнцвэрийн бөөмс
- D. Бага тархины өтөнцөр
- E. Нугасны арын багана

/581./ Тархины эдийн гаралтай хавдар аль нь вэ?

- A. Ангиоретикулом
- B. Аденом
- C. Астроцитом
- D. Менингиом
- E. Шваннома

/582./ Гавлын дотоод даралт хэвтээ байрлалд ямар хэмжээнд байх вэ?

- A. 10-15 мм.рт.ст
- B. 20-25 мм.рт.ст
- C. 5-10 мм.рт.ст
- D. 25-30 мм.рт.ст
- E. 18-22 мм.рт.ст

/583./ Гавал тархины доргилтын үеийн ухаан алдалт ямар хугацаанд үргэлжлэх вэ?

- A. 1 цаг хүртэл
- B. 1 цагаас их
- C. 0-15 минут
- D. 20-30 минут
- E. 30-40 минут

/584./ Менингиттэй өвчтөний хөлийг өвдөгний үеэр тэнийлгэх агшинд нөгөө хөл нь өвдөг, түнхний үеэр нугарна. Энэ аль шинжид хамаарах вэ?

- A. Брудзинскийн дээд шинж
- B. Брудзинскийн дунд шинж
- C. Брудзинскийн доод шинж
- D. Кернигийн шинж
- E. Лесажийн шинж

/585./ Энцефалитийн эмгэг жамын эмчилгээнд аль эм хамаарах вэ?

- A. Ацикловир
- B. Интерферон
- C. Карбамазепин
- D. Седуксин
- E. Дексаметазон

/586./ Беллийн саа аль нь вэ?

- A. Нүүрний мэдрэлийн төвийн саа
- B. Нүүрний мэдрэлийн захын саа
- C. Уртавтар тархины саажилт
- D. Уртавтар тархины хуурамч саажилт
- E. Хэлний булчингийн захын саажил

/587./ Тархи дээгүүр шаантаглах хамшинжийн үед илрэх эмнэлзүйн зарим шинж юу вэ?

1. Ухаан аажим дарангуйлагдана
2. Голомттой талд харц дээш саажих, нүд гадагш хялар
3. Голомтын эсрэг талын гар, хөлд төвийн саа үүснэ
4. Голомтын эсрэг талд нүдний зовхи бууна
5. Хүүхэн хараа нарийсна

/588./ Өвчтөний зүүн гарт захын саа, зүүн хөлд төвийн саатай. Байршлын онош?

1. Нугасны баруун хажуу багана C5-T1
2. Нугасны зүүн хажуу багана C5-T1
3. Нугасны баруун урд эвэр C5-T1
4. Нугасны зүүн урд эвэр C5-T1
5. Нугасны зүүн тал C2-C4

/589./ Паллидумын эмгэгийн хамшинжид аль шинж орох вэ?

1. Хөдөлгөөн хомсдох-хүчдэл ихсэх хамшинж
2. Булчингийн хүчдэл хэт ихсэх
3. Тайваны салганалт
4. Атетоз
5. Гемибаллизм

/590./ Уушигны угийн өргөн хэдэн см вэ?

- A. 1,2-1,8 см

- B. 2-3,5 см
- C. 0,5-1,0 см
- D. 1,5-2,5 см
- E. 2.5-5.0 см

/591./ Рентгенд 2 талын өрц ямар сүүдрээр илэрч харагдах вэ?

- A. Жигд биш төвгөр сүүдрээр
- B. Жигд төвгөр сүүдрээр
- C. Гурвалжин сүүдрээр
- D. Шулуун шугаман сүүдрээр
- E. Долгионтсон сүүдрээр

/592./ Зүүн ховдлын нум хаана байрладаг вэ?

- A. Linea medioclavicularis sinistra -аас дотогш 1,5-2,0 см зайд
- B. Linea medioclavicularis dexter-аас дотогш 1,5-2,0 см зайд
- C. Linea medioclavicularis-аас гадагш 2,0-2,5 см зайд
- D. Linea parasternalis sinistra-аас дотогш 1,5-2,0 см зайд
- E. Linea mammarialis sinistra -аас дотогш 2,0-2.5 см зайд

/593./ Амьсгалын эрхтэн системийн шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү

- A. Ирригоскопи
- B. Фистулографи
- C. Пневмоартрографи
- D. Рентгенографи, рентгеноскопи
- E. Колоноскопи

/594./ Ателектаз ба уушгины циррозийн үед голтын эрхтний шилжилт ажиглагдах уу

- A. Голтын эрхтэн шилжихгүй
- B. Голтын эрхтэн эмгэг өөрчлөлттэй талын эсрэг тал руу шилжинэ
- C. Голтын эрхтэн эмгэг өөрчлөлттэй тал руу татагдана
- D. Эрүүл тал нь голтын эрхтэнээ татна
- E. Голтын эрхтэний сүүдэр тодорхойлогдохгүй

/595./ Бүтэц нэг төрлийн бус сүүдэржилтээр илэрдэг эмгэгүүдийг нэрлэнэ үү

- A. Нэвчдэст сүүдэр
- B. Ателектаз
- C. Эмфизема
- D. Пневмоторакс
- E. Фиброторакс

/596./ Уушигны талбайд татсан босоо шугамаар уушигны талбайг хэрхэн ангилах вэ?

- A. Дээд, дунд, доод
- B. Дээд, гадна, дотно
- C. Дотно, дунд, гадна
- D. Гадна, дунд, доод
- E. Дээд хэсэг, төв хэсэг, доод хэсэг

/597./ 1-р ташуу байрлалын зүрх судасны сүүдрийн хойд талын 2-р нумыг нэрлэ

- A. Зүүн ховдол
- B. Уушгины артери
- C. Зүүн тосгуур
- D. Баруун тосгуур
- E. Гол судасны уруудах хэсэг

/598./ Хоол боловсруулах замын рентген шинжилгээний аргуудыг нэрлэ

- 1. Флюорографи
- 2. Цистографи
- 3. Ангиографи
- 4. Ирригоскопи
- 5. Гистеросальпингографи

/599./ Яс үений системийн шинжилгээний аргуудыг нэрлэ

- 1. Рентгенографи
- 2. Фистулографи
- 3. КТ

4. Пневмоартрографи

5. MRI

/600./ Аяганцар, тэвшинцэрийн эмгэг өөрчлөлтүүдийг оношлох шинжилгээний аргуудыг нэрлэ

1. Цистографи

2. Ялгаруулах урографи

3. Пневмоартрографи

4. Хэт авиа

5. Пневморетроперитонеум

/601./ Бүдүүн гэдэсний эмгэгийг ямар шинжилгээний аргуудаар оношлох вэ?

1. Цистографи

2. Хэт авиа

3. Урографи

4. Ирригоскопи

5. Сцинтиграфи

/602./ Ирригоскопийн шинжилгээнд ашигладаг үндсэн тодосгогч бодисыг нэрлэ

1. Урогафин

2. Хий

3. Верогафин

4. Барисульфатын усан зуурмаг

5. Иодлипол

/603./ Шээлэйн эмгэг өөрчлөлтийг оношлох шинжилгээний аргыг нэрлэ

1. Цистографи

2. Урографи

3. Пневморетроперитонеум

4. Өгсөх пиелографи

5. Гистеросальпингографи

/604./ Бөөрний унжилтыг ямар шинжилгээний аргуудаар оношлох вэ?

1. Бөөрний ангиографи

2. Урографи

3. Хэт авиа

4. Фистулографи

5. Гистеросальпингографи

/605./ Бөөр шээс дамжуулах замын шинжилгээнд ямар төрлийн тодосгогч бодис хэрэглэх вэ?

1. Барийн усан уусмал

2. Иодын усан уусмал

3. Иодын тосон уусмал

4. Ионы бус тодосгогч

5. Хийн тодосгогч

/606./ Рентгеноскопийн шинжилгээний давуу талуудыг нэрлэнэ үү

1. Бодит баримт үлдэж, цаашид өвчний явцыг харьцуулан судлах боломжтой

2. Шинжлүүлэгчийг дурын байрлалаар шинжилж болно

3. Шинжлүүлэгчид туяаны ачаалал багатай

4. Бүтэц, үйл ажиллагааны хавсарсан өөрчлөлтүүдийг шинжлэх боломжтой

5. 1-2 мм хэмжээтэй жижиг сүүдэр тод харагдана

/607./ КТ-ийн шинжилгээний давуу талуудыг нэрлэнэ үү

1. Шинжилгээ хурдан, зовиургүй

2. Зүслэгийн хавтгай дах бүх мэдээллийг нэгэн зэрэг авч харьцуулан үнэлэх боломжтой

3. Яс болон зөөлөн эдийн бүх өөрчлөлтийг илрүүлж болно

4. Эдэд гарсан нягтын зөрүүг маш өндөр мэдэрнэ

5. Тодосгогч бодис хэрэглэнэ

/608./ КТ-ийн шинжилгээнд ямар туяа ашиглах вэ?

1. Гамма туяа

2. Бетта туяа

3. Альфа туяа

4. Икс туяа

5. Соронзон туяа

/609./ Рентген цацрагийн онцгой чанаруудыг дурьдана уу

1. Гэрэлтэт буюу флюороресценци үүсгэх чанар
2. Цэнэгжүүлэх үйлчилгээ
3. Биологийн үйлчилгээ
4. Фотохимийн үйлчилгээ
5. Хүний биеийн бүхий л эд эрхтэнг нэвтрэн гарах чадвартай

/610./ Тодосгогч бодист тавигдах гол шаардлага юу вэ?

1. Хүний биед гаж нөлөөгүй
2. Тодрох чанар өндөртэй
3. Биеээс хурдан гадагшилдаг
4. Цусны химийн бүтцэд нөлөөлдөггүй
5. Хоол боловсруулах шүүсэнд уусдаггүй

/611./ Ямар эмгэгүүдийн үед голтын эрхтэн эмгэг өөрчлөлттэй талын эсрэг тал руу түлхэгдэх вэ?

1. Нэвчдэст сүүдэр
2. Пневмоторакс
3. Фиброторакс
4. Гялтангийн хөндийд их хэмжээний шингэн хурах
5. Хатгаа

/612./ Ателектазийн үед илрэх рентген шинжүүдийг нэрлэнэ үү

1. Бүтэц нэг төрлийн бус сүүдэржилт
2. Гэмтээсэн дэлбэн, сегментийнхээ хэлбэр, хэмжээг давтсан сүүдэр
3. Голтын эрхтэн эмгэгтэй талын эсрэг тал руу түлхэгдэнэ
4. Голтын эрхтэн эмгэгтэй тал руу шилжинэ.
5. Сүүдрийн зах ирмэг нь тод бус, жигд биш

/613./ КТ-ийн шинжилгээний онцлог, давуу талуудыг нэрлэнэ үү

1. Олон байрлалд эргүүлэн цээж гэрэлд харах
2. Бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтүүдийг үнэлнэ
3. Стандарт 4 байрлалд зураг авна
4. Зүслэгийн хавтгай дах эмгэг өөрчлөлтийг нэгэн зэрэг харж харьцуулан үнэлэх боломжтой
5. Өвчтөнд туяаны ачаалал багатай

/614./ Рентгеноскопийн арга нь рентгенографийн аргаас ямар давуу талуудтай вэ?

1. Эдэд гарсан нягтын зөрүүг мэдэрнэ
2. Бүтэц үйл ажиллагааны хавсарсан өөрчлөлтүүдийг илрүүлнэ
3. Өвчтөнд туяаны ачаалал багатай
4. Эрхтний физиологийн хөдөлгөөн, үйл ажиллагааг үнэлнэ
5. Шинжилгээ хурдан, зовиургүй

/615./ Уушгины бүтэц нэг төрлийн бус сүүдэржилтээр илэрдэг эмгэгүүдийг нэрлэнэ үү

1. Хатгаа
2. Гялтангийн хөндийд шингэн хурах
3. Гялтангийн хөндийд хий хурах
4. Цирроз
5. Ателектаз

/616./ Уушгины хавдарыг илрүүлэхэд ашигладаг дүрс оношлогооны багажийн шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. Цээжний рентген шинжилгээ
2. Компьютерт томографи
3. Соронзон резонанст томографи
4. Дуран
5. Биопси

/617./ Дүрс оношлогооны шинжилгээгээр илрэх шинжээр нь гуурсан хоолойн карцинома хавдрыг хэрхэн ангилж болох вэ?

1. Захын байрлалтай хавдар
2. Төвийн байрлалтай хавдар

3. Цээжний хөндийд тархаж байрласан хавдар
 4. Нэвчсэн хавдар
 5. Үсэрхийлсэн хавдар
- /618./ Уушгины хавдрыг үнэлэх дүрс оношлогооны шинжүүдийг нэрлэнэ үү?
1. Хавдрын хэлбэр
 2. Хавдрын зах ирмэг
 3. Хөндийтэй эсэх
 4. Шохойжсон голомттой эсэх
 5. Уг өргөссөн эсэх
- /619./ Ямар эмгэг нь хорт хавдарт шилждэг вэ?
1. Дисплази
 2. Факультативный предрак
 3. Хоргүй хавдар
 4. Облигатный предрак
 5. Байран өмөн /in situ/
- /620./ Орчин үед хавдрыг юу гэж тайлбарлаж байгаа вэ?
1. Халдварт өвчин
 2. Генетикийн өвчин
 3. Үрэвсэлт өвчин
 4. Нийгмийн өвчин
 5. Дээрх бүгд
- /621./ Хавдрын эсрэг дархлаа, эсийн морф-генетикийн хариу урвал эсийн ялгарал, апоптоз, эсийн хуваагдлын өөрчлөлт, мутаци болон бусад генетикийн өөрчлөлтийг үүсгэдэг хүчин зүйлийг юу гэж нэрлэдэг вэ?
1. Факультативный предрак
 2. Облигатный предрак
 3. Дисплази
 4. Канцергенез
 5. Хэвийн бус /атипия/
- /622./ Хавдрын эс үүсэхэд юу нөлөөлдөг вэ?
1. АПОПТОЗ алдагдах
 2. Эсийн хэт үржил
 3. Эсийн генетикийн бүтцийн өөрчлөлт
 4. Өөрчлөлт
 5. Эсийн бичил өөрчлөлт
- /623./ Хавдрын эсрэг эмийн эмчилгээг юу гэдэг вэ?
1. Хими эмчилгээ
 2. Дааврын эмчилгээ
 3. Бай эмчилгээ
 4. Туяа эмчилгээ
 5. Хавсарсан эмчилгээ
- /624./ Хавдрын нууц үеийн дундаж хугацаа хэд вэ?
1. 3-6 сар
 2. 1-2 жил
 3. 6-10 жил
 4. 3-5 жил
 5. 10-аас дээш жил
- /625./ Ямар өмөн эрт үедээ үсэрхийлдэг вэ?
1. Элэг
 2. Уушиг
 3. Хэсэг газрын тунгалагийн зангилаа
 4. Яс
 5. Тархи
- /626./ Дааврын шалтгаант паранеопласт синдром яагаад үүсдэг вэ?
1. Бамбай булчирхайн хавдрын үед
 2. Метастаз бөөрний дээд булчирхайд өгсөн үед

3. Ходоодны хавдар нойр булчирайд үсэрхийлээн үед
 4. Хавдрын эсээс ялгарах дааврын улмаас
 5. Өнчинтархины үйл ажиллагаа дарангуйлагдсан үед
- /627./ TNM ангиллын N ямар шинжийг илэрхийлдэг вэ?
1. Анхдагч хавдрын хэмжээг
 2. Алсын үсэрхийллийг
 3. Хорт хавдрын онцлог шинж
 4. Хэсэг газрын тунгалагийн булчирхайн байдал
 5. Хавдрын гистологи бүтэц
- /628./ Хөхний хавдрыг эрт илрүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?
1. Маммографи
 2. Хөхөө өөрөө шалгах
 3. Хөхний эхо
 4. КТГ
 5. Мэс заслын эмчид үзүүлэх
- /629./ Умайн хүзүүний өмөнг эрт илүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?
1. Эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэх
 2. Кольпоцитодиагностик
 3. PAP сорил
 4. Үтрээний эхо
 5. Хусаж шинжлэх
- /630./ Ясны хавдар ихэвчлэн хаана байрладаг вэ?
1. Дундчөмөг
 2. Бугалга
 3. Шилбэ
 4. Хавирга
 5. Сүүж
- /631./ Юингын хавдар дунд чөмөгний хаана байрладаг вэ?
1. Метафиз
 2. Эпифиз
 3. Метаэпифиз
 4. Диафиз
 5. Сэртэнд
- /632./ Ясны хорт хавдар голчлон ямар эрхтэнүүд рүү үсэрхийлдэг вэ?
1. Элэг
 2. Уушиг
 3. Зөөлөн эд рүү
 4. Дэлүү
 5. Тунгалагын зангилаа руу
- /633./ Ямар хавдрууд илүү эрт үсэрхийлдэг вэ?
1. Хондросаркома
 2. Ясны анхдагч ретикулосаркома
 3. Ясны өмөн
 4. фибродисплази
 5. Фиброзын гаралтай хавдар
- /634./ Хими ЭМЧИЛГЭЭНД ямар хавдар илүү мэдрэг вэ?
1. Хондросаркома
 2. Ясны том эсийн хавдар
 3. Ясны саркома
 4. Юингийн хавдар
 5. Фиброзын гаралтай хавдар
- /635./ Ясны хавдрыг оношлох гол арга нь:
1. КТГ
 2. Биопси
 3. ЭХО
 4. Рентген зураг

5. Маркер

/636./ Ясны хоргүй хавдрын үед илэрдэг эмнэл зүйн гол шинжүүд юу вэ?

1. Электролит солилцооны алдагдал /Ca, Na, K/
2. Хавдар байрласан хэсэгт хааяа өвдөх
3. Хавдар тэмтрэгдэх
4. Доголох
5. СОЭ ихсэх

/637./ Биопси нь оношлогооны өндөр ач холбогдолтой арга. Ямар төрлийн хавдрыг оношлоход биопси илүү ач холбогдолтой вэ?

1. Яс
2. Хөх
3. Арьсны меланома
4. Зөөлөн эдийн хавдар
5. Ясны анхдагч ретикулосаркома

/638./ Зөөлөн эдийн хавдрын талаар ямар шинжилгээ нь илүү мэдээлэл өгдөг вэ?

1. Радиоизотопын арга
2. Соронзон резонанс томографи
3. КТГ
4. Биопси
5. Маркер

/639./ Бүтэц зүйгээр нь зөөлөн эдийн хавдрыг юу гэж ангилдаг вэ?

1. Синовиаль
2. Карциноид
3. Мезотелиол
4. Полип
5. Нейроген

/640./ Уушигны өмөн ямар эдээс үүсдэг вэ?

1. Мэдрэл
2. Хучуур
3. Мөгөөрс
4. Булчирхай
5. Яс

/641./ Эрэгтэйчүүд ямар хавдраар илүү өвчлөмтгий байдаг вэ?

1. Улаан хоолой
2. Ходоод
3. Нойр булчирхай
4. Элэг
5. Уушиг

/642./ Төвийн байрлалтай уушигны хавдрыг эрт илрүүлэх гол аргууд нь юу вэ?

1. Унтуулгатай бронкоскопи
2. Фибробронхоскопи
3. Трансторакаль биопси
4. Цэрний шинжилгээ
5. Медиастиноскопи

/643./ ХЭТ Яагаан туяа нь ямар ямар хавдраар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг вэ ?

1. Уушиг
2. Арьсны меланома
3. Хэлний хавдар
4. Уруулны хавдар
5. Ходоодны хавдар

/644./ Хавдар нь ямар гол хүчин зүйлүүдээс үүсдэг вэ?

1. Хооллолт
2. Тамхи
3. Вирус
4. Удамшил
5. Архи

/645./ Улаан хоолойн өмөнгийн тархвар судлал ямар онцлоготой вэ ?

1. Эмэгтэйчүүд илүү өвчлөмтгий
2. 50-с дээш эрэгтэйчүүдэд илүү тохиолддог
3. Хойд зүгийн уугуул иргэдэд илүү тохиолддог
4. Баруун аймгийн иргэдэд илүү тохиолддог
5. 50-с дээш эмэгтэйчүүдэд илүү тохиолддог

/646./ Эмнэлзүйн ямар шинж дээр үндэслэн улаан хоолойн хавдар гэж сэжиглэх вэ?

1. Хоол горойх
2. Шүлс их гоожих
3. Хоол залгихад хөндүүрлэх
4. Акрокератоз
5. Халуурах

/647./ Улаан хоолойн хожуу үеийн хавдрын доод ба дээд хэсгийн булчирхайлаг эсийн өмөнгийн үед ямар аргаар эмчлэх вэ?

1. Туяа эмчилгээ
2. Полихими эмчилгээ
3. Еюностомы
4. Гарлокийн мэс засал
5. Стенд тавих

/648./ Улаан хоолойн хавдрын мэс заслын дараа оедол задрах хүндрэл яагаад эрт эрт үүсдэг вэ?

1. Салст бүрхэвч нимгэн учраас
2. Судасжилт багатай
3. Салстын доод давхраа үгүй учраас
4. Серозон давхарга байхгүй тул
5. Серозон бүрхүүлтэй

/649./ Улаан хоолойн өмөнг ямар аргаар эрт илрүүлэх вэ?

1. Өтгөн баритай рентгенд харах
2. Улаан хоолойг рентгенд харах
3. Бронхоскопи
4. Дурандаж биопси авах
5. Хромотографийн аргаар шинжлэх

/650./ Урт хугацаагаар илрэх сэтгэл хөдлөлийг дурьдана уу?

- A. Мэдрэх сэтгэл Эмоци
- B. Дотоод сэтгэлийн мэдрэмж /чувство/
- C. Хүсэл шунал /страсть/
- D. Сэтгэл цочирдол /аффект/
- E. Зан сэтгэл /настроение/

/651./ Хуурамч дурсамжийг өөрөөр юу гэж нэрэлдэг вэ?

- A. Андуурах дурсамж
- B. Ойгүйдэл
- C. Ойн гажуу тусгал
- D. Зохиомол дурсамж
- E. Ойн эндүүрэл

/652./ Психосоматик өвчнүүдийг нэрлэнэ үү?

1. Ходоод гэдэсний шархлаа
2. Артерийн даралт ихсэх өвчин
3. Гуурсан хоолойн багтраа
4. Чихрийн шижин
5. Таргалалт

/653./ Сэтгэцийн өвчин үүсэхэд нөлөөлөх сэтгэлзүйн хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Бие хүний дотоод будлиан
2. Тайлаагүй далд бухимдал
3. Сэтгэлийн цохилт
4. Гэр бүл салалт
5. Ядуурал

/654./ Сэтгэцийн өвчин үүсэхэд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Ажилгүйдэл
2. Бүлэг хүмүүсийн хоорондын будлиан
3. Архидалт ба мансуурал
4. Муу нэрийн шошго зүүх
5. Өөртөө итгэлгүй байх

/655./ Айж сандрах эмгэгтэй гэсэн оноштой үед ямар тусламж үзүүлэх вэ?

1. Сэтгэц нөлөөт эм хэрэглэх
2. Хямралтай хүнтэй ярилцаж сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
3. Тухайн хүний гэр бүлтэй ярилцаж сэтгэл санааны дэмжлэг үзүүлэхийн чухлыг хэлж өгөх
4. Өөр эмнэлэг рүү илгээх
5. Амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлэх

/656./ Психосоматик анагаах ухаан юуг судалдаг вэ?

1. Сэтгэцийн дотоод будлиан
2. Сөрөг сэтгэл хөдлөл
3. Бие хүн
4. Хамгаалах механизм
5. Үгүйсгэл

/657./ Хүнийг итгүүлэн үнэмшүүлэх ямар аргууд байдаг вэ?

1. Ятгах арга
2. Шууд итгүүлэн үнэмшүүлэх арга
3. Захирах арга
4. Дам аргаар итгүүлэн үнэмшүүлэх арга
5. Ярилцах арга

/658./ Аман ярианы хий үзэгдлийг нэрлэнэ үү?

1. Зэмлэн буруушаах хий үзэгдэл
2. Доромжлох хий үзэгдэл
3. Захиран тушаах хий үзэгдэл
4. Тайлбарлах хий үзэгдэл
5. Сайшаах хий үзэгдэл

/659./ Эмнэлзүйн харилцааны ямар ямар загварууд байдаг вэ?

1. Шугаман загвар
2. Эцгийн эрхт ёсны харилцаа
3. Эргэлтийн загвар, түншлэлийн загвар
4. Харилцан нөхөрлөлийн загвар
5. Үйлчлүүлэгч төвтэй харилцаа

/660./ Өвчний шинж тэмдэгүүдийг мэдээлдэг, дамжуулдаг, илэрхийлдэг ямар ямар харилцааны хэрэгсэлүүд байдаг вэ?

1. Үйлдэл хөдөлгөөний хэл
2. Биеийн хэл
3. Тэмдгийн хэл
4. Объектийн хэл
5. Үгсийн хэл

/661./ Тэнэгрэл үүсгэх эмгэгүүдийг нэрлэнэ үү?

1. Чихрийн шижин
2. Эпилепси
3. Ходоодны шархлаа
4. Паркинсон
5. Шизофрени

/662./ Сэтгэл хөөрөх хам шинжийн бүрэлдэхүүнийг нэрлэнэ үү?

1. Сэтгэл хөөрөх шинж
2. Сэтгэхүй түргэсэх шинж
3. Үйлдэл хөдөлгөөн түргэснэ
4. Сэтгэлийн хөдөлгөөний тохироо алдагдах
5. Бухимдах

/663./ Сэтгэл гутрах хам шинжийн бүрэлдэхүүнийг нэрлэнэ үү?

1. Сэтгэл гутрах
2. Сэтгэцийн үйл ажиллагааны идэвхи буурах
3. Хөдөлгөөний идэвхи буурах
4. Сэтгэлгүйдэх
5. Сэтгэлийн хөдөлгөөний хоёрдмол хандлага илрэх

/664./ Импульсив үйлдлийн ангилалыг нэрлэнэ үү?

1. Хулгайн дон
2. Шатаахын дон
3. Тэнэхийн дон
4. Архидахын дон
5. Худалдан авах дон

/665./ Эмийн тусламжтай ярилцах эмгэгүүдийг нэрлэнэ үү?

1. Истерийн дуугүй болох шинж
2. Кататоник хөшил
3. Дуугүй болох шинж бүхий баашлалт
4. Сэтгэл гутрал
5. Шизофрени

/666./ Түр зуурын тикийн онцлог юу вэ?

1. Хөдөлгөөний ганц нэг тик, хөдөлгөөний олон тооны тик, дуу авианы тик гурвын аль нэг нь
2. Тик өдөр бүр, өдөрт олон удаа, 2 долоо хоногоос дээш боловч 12 сараас доош хугацаанд ажиглагдана
3. Анамнезд Туреттийн хамшинж буюу архаг тик үгүй байна
4. Тик 21 наснаас өмнө эхэлнэ
5. Мансууруулах бодисын хордлого буюу уураг тархины органик өвчний үед тик бий болохгүй

/667./ Мэдрэлийн гаралтай хоолноос татгалзах эмгэгийн үед ямар шинжүүд илрэх вэ?

1. Биений жин нэмэгдэхээс маш их айна
2. Биений юмны алдагдал
3. Туранхай байх хүсэлд автана
4. Гэнэт маш их иднэ
5. Биений жин огцом нэмэгдэх

/668./ Өтлөлтийн товрууны төв цөм юунаас бүрэлдэн тогтдог вэ?

1. Нейрофибрилийн сүлжээ
2. Тэжээлийн доройтолтой нейронууд
3. Тэжээлийн доройтолтой дендритүүд
4. Бета амилоид – уураг
5. Үхжсэн эсүүд

/669./ Хэвшинжит бус солиорлын эсрэг эмүүдийг нэрлэнэ үү?

1. Рисперидон (Risperdal R)
2. Зипразидон (ZeldoxR)
3. Клозапин (ClopineR, Clozaril R)
4. Триоксазин
5. Левомепромазин

/670./ Солиорлын эсрэг эмүүдийг нэрлэнэ үү?

1. Галоперидол
2. Хлорпромазин
3. Левомепромазин
4. Ламотрежин
5. Залеплон

/671./ Реабилитаци буюу сэтгэцийн нөхөн сэргээлт гэж юу вэ?

1. Хууль зүйд цагаатгалын буюу эрхийг сэргээх
2. Ёс зүйд сайн нэрийг буюу хуучин нэр алдрыг дахин олж авах
3. Анагаах ухаанд тахир дутуу хүмүүсийн хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх
4. Сэтгэцийн өвчний улмаас алдаж гээсэн амьдрах ухааны ур чадваруудыг нөхөн сэргээх
5. Сэтгэц оюуны бусад чадваруудыг нөхөн сэргээх буюу шинээр эзэмшүүлэх

/672./ Анагаахын сэтгэл судлалд эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцааны сэтгэлзүйн үндэс юу вэ?

1. “Эмпати” гэдгийг ур чадвартай гэж ойлгох
2. Раппорт” гэдэг нь сэтгэлзүйн холбоо тогтоож харилцах
3. Үйлчлүүлэгчийн үнэт зүйлийг хүндэтгэж харилцах
4. Ярилцлага өгөгчийн сэтгэл хөдлөлийг мэдэрч харилцах
5. Хүнийг анхаарлын төвд тавьж тусламж үйлчилгээ үзүүлэх

/673./ Өсвөр насны хүүхдэд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгүүдийг нэрлэнэ үү?

1. Гебойд хам шинж
2. Хүүхдэрхэх хам шинж
3. Бие эрхтэн гажихаас айх хам шинж
4. Хэт хөдөлгөөнтөх эмгэг
5. Орондоо шээх эмгэг

/674./ Өсвөр насны охид хөвгүүдэд нийгэм сэтгэлзүйн ямар хувирал, өөрчлөлтүүд илрэх вэ?

1. Насанд хүрсэн хүний “Эго” бүрэлдэн тогтоно
2. Сэтгэц бэлгийн чиг баримжаа бүрэлдэн тогтоно
3. “Супер эго” бүрэлдэн тогтоно
4. Ёс зүйн мэдрэмжүүд бүрэлдэн тогтоно
5. Өөрийн үнэлгээ бүрэлдэн тогтоно

/675./ Оюуны хомсдолын үед хийх зайлшгүй шаардлагатай эмчилгээг нэрэлнэ үү?

1. Оюун ухааныг сайжруулах эмийн эмчилгээ
2. Хавсран тохиолдож байгаа эмгэгийг эмчлэх эмийн эмчилгээ
3. Тархины цусан хангамжийг сайжруулах эмийн эмчилгээ
4. Амьдарх ур чадварт сургах
5. Эмийн эмчилгээ шаардлагагүй

/676./ Цус задрах өвчний улмаас үүсэх оюуны хомсдолын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Хорей маягийн хэт хөдөлгөөнтөх хамшинж илрэх
2. Сонсголын эрхтэний согог ажиглагдах
3. Хөл гараараа даллах хөдөлгөөн хийх
4. Сэтгэцийн органик хамшинж бүхий оюуны хомсдол ажиглагдах
5. Судалт биед бүтцийн буюу органик өрчлөлт илрэх

/677./ Ухаан бүрийтэн балартахад хүргэдэг эмгэгүүдийг нэрлэнэ үү?

1. Эпилепси
2. Тархины гэмтэл
3. Чамархайн байрлалтай эмгэг голомт
4. Тархинд цус харвах
5. Чихрийн шижин

/678./ Архичдын нөхөрлөл дээр тулгуурлан үүссэн эмчилгээний бүлгүүдийг нэрлэнэ үү?

1. Нэр хаяггүй идэмхий хүмүүсийн нөхөрлөл
2. Нэр хаяггүй истерикүүдийн нөхөрлөл
3. Нэр хаяггүй наркомануудын нөхөрлөл
4. Нэр хаяггүй мөрийтэй тогмоомонд донтох хүмүүсийн нөхөрлөл
5. Нэр хаяггүй архичдын эхнэрүүдийн нөхөрлөл

/679./ Сэтгэлийг ариусах аргуудыг нэрлэнэ үү?

1. Атнасовын хорлогдсон үзэгний арга
2. Бичиж сэтгэлээ ариусгахуй
3. Франкийн арга
4. Нүглээ наминчлах
5. Гипнозоор сэтгэлийн дарамтаас чөлөөлөх

/680./ Парафрений хамшинжийн үед илэрдэг шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Агуу ихийн дэмийрлүүд
2. Сэтгэцийн автоматизм
3. Фантаз хий үзэгдэл
4. Фантаз зохиомол дурсамж
5. Эйфория

/681./ Хуурамч хий үзэгдлийг илтгэх шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Хүртэх боломжгүй орон зайд үүснэ
2. Өвчтөн тухайн хий үзэгдлээсээ айж сандрахгүй хайхрамжгүй хандана
3. Өдрийн аль ч цагт үүсэж болдог
4. Бодит зүйлээс өөр байна
5. Орчны юмыг аймшигтай араатан амьтан болгож харна

/682./ Корсаковын хамшинжийн бүрэлдэхүүнд ордог шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Тогтоох ойгүйдлийн шинж
2. Ойн эндүүрэл
3. Хойших ба өмнөх ойгүйдлийн шинж
4. Ойгүйдлийн баримжаа алдалт
5. Сэтгэл хий хоосон хөөрөн баясах шинж

/683./ Ой тогтоолтын чанарын өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?

1. Хуурамч дурсамж
2. Зохиомол дурсамж
3. Андуурах дурсамж
4. Даамжрах ойгүйдэл
5. Марталт

/684./ Мансууруулах бодис хэрэглэсэн үед илрэх эмнэлзүйн шинжийг дурьдана уу?

1. Их хэмжээгээр байнга хэрэглэх
2. Мансууруулах бодис хэрэглэснээс шалтгаалсан бие организмын болон сэтгэлзүйн хямрал илрэх
3. Хэрэглээнд хяналт тавихад хүндрэлтэй болох
4. Даах чадвар ихсэх
5. Шарталт илрэх

/685./ Цочмог тулайн артритын эмнэлзүйн шинж тэмдэгт хамаарахгүйг заана уу

- A. Үе өвдөх, хавдах
- B. Тэнийлгэгч шөрмөсөнд тофус үүсэх
- C. Арьсны халуун бага зэрэг нэмэгдэх, улайх
- D. Бушарын зангилаа үүсэх
- E. Хөлийн эрхий хуруу гэмтэх

/686./ Хэрх төст үений үрэвслийн (Rheumatoid arthritis) үед RF хэдэн хувьд эерэг байх вэ

- A. Нийт өвчний 80 хувьд эерэг байна.
- B. 20-40 хувьд эерэг байна
- C. Сөрөг байна.
- D. Улаан эсийн тунах хурд ихэссэн үед эерэг байна.
- E. Нийт өвчний 60 хувьд эерэг байна

/687./ Нуруу нугаламын барьцилдаат спондилитээр ямар хамааралтай хүмүүс өвчлөх магадлалтай вэ.

- A. HLA-B37
- B. HLA-DR13
- C. HLA-D27
- D. HLA-B27
- E. HLA-B25

/688./ Архаг явцтай хэрх төст үений үрэвслийн үед хуруунуудын тэнийлгэгч шөрмөснүүд сунаж, богтос талруу гулсахад хуруунууд чигчий хуруу тийш хазайдаг шинжийг юу гэж нэрлэх вэ.

- A. Богтосруу гулгах
- B. Хунгийн хүзүү
- C. Богтосруу ханарах
- D. Товчны дэгээ
- E. Тендинит

/689./ Талхчны уйланхайг хаана илрүүлэх вэ.

- A. Ахиллын шөрмөсний уутанд
- B. Маяагийн хонхорт
- C. Шагайны хонхорт

D. Шаант тахилзуурын холбоосонд

E. Тахимны хонхорт

/690./ Тулайн цочмог артрит ямар үенээс ихэвчлэн эхэлдэг вэ.

A. Бугуйн үе

B. Шагайн үе

C. Гарын дунд хуруу

D. Хөлийн эрхий хуруу

E. Хөлийн чигчий хуруу

/691./ Хэрх төст үений үрэвсэлтэй өвчтөний ихэнх хувьд арьсан доорх зангилаа илрэх ба ихэвчлэн зөөлөн бүтэцтэй байдаг учир тэмтрэхэд өвдөлт эмзэглэл байхгүй

/692./ Хэрхийн үений үрэвслийн эмнэлзүйн шинжид тохирохыг заана уу

1. Халдварын шалтгаантай

2. Том үеийг хамрах

3. Үений үрэвсэл 2 талд тэгш бус

4. Жижиг үеийг хамрах

5. Үений үрэвсэл 2 талд жигд

/693./ Хэрх төст үений үрэвслийн эмгэг жам хэт мэдрэгших хэддүгээр урвалаар нөхцөлдөн явагдах вэ.

A. Хэт мэдрэгших 1

B. Хэт мэдрэгших 2

C. Хэт мэдрэгших 3

D. Хэт мэдрэгших 4

E. Аль нь ч биш

/694./ Хэрэх өвчний үед лабораторид ямар өөрчлөлтүүд гарах вэ.

1. Цагаан эс ихсэх

2. Гамма глобулин ихсэх

3. С урвалж уураг ихсэх

4. АСЛО буурах

5. Анти ССР эерэг байх

/695./ Үений хөдөлгөөн хязгаарлалтын Бенклэрийн ангилалын 3-аар үеийг заана уу

A. Өдөр тутмын үйл ажиллагаа саадгүй, өөртөө үйлчлэх чавдар саадгүй.

B. Мэргэжил болон өөртөө үйлчлэх чадвар хэвийн боловч чөлөөтцагаар хичээллэх нь хязгаарлагдах

C. Үений хөдөлгөөн хязгаарлагдсан эсвэл хөдөлгөөнгүй болох, өөртөө үйлчлэх чавдар маш муу.

D. Мэргэжил болон чөлөөт цагаар хичээллэх нь хязгаарлагдах ба өөртөө үйлчлэх чавдар алдагдана

E. Бүх үйл ажиллагаа алдагдана.

/696./ Нуруу нугаламын барьцалдаат спондилитийн шалтгааныгнэрлэнэ үү.

A. Удамшил

B. А бүлгийн цус задлагч стрептококк

C. Зарим эмийн бодисууд

D. Ажил мэрэгжлийн онцлог

E. Архи хорт зуршил

/697./ Цочмог тулайн үед үений шингэнд гарах өөрчлөлтийг заана уу

1. Үений шингэн тунгалаг

2. Цагаан эс 1000-100000

3. Нян илэрнэ

4. Үений шингэн булингартай

5. Цагаан эс 2000 аас бага

/698./ Тохойн үеийг тэмтрэх зөв аргыг заана уу

A. Тохойг 90 хэмийн өнцгөөр нугалж барина

B. Тохойг сул чөлөөтэй 110 хэмийн өнцгөөр нугалж тэмтрэнэ

C. Тохойг сул чөлөөтэй 90 хэмийн өнцгөөр эмч 2 гараараа дэмжин барина.

D. Эмч нэг гараар тохойг дурын өнцгөөр тэмтрэнэ.

E. Тохойг эргүүлж тэмтрэнэ

/699./ Тулай үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү:

1. Аспирин
2. Хаван хөөх эм
3. Пурин агуулсан хоол хүнс
4. Архи
5. Шар айраг

/700./ Ревматоид артритын оношлогоонд аль шинжүүд багтах вэ:

1. Олон үеэр өвдөх
2. Хоёр талдаа ижил үенүүд хавдах
3. Өглөөний хөшингө 20-30 минут байх
4. Өглөөний хашингө 1 цагаас илүү байх
5. Шөрмөсний үрэвсэл байх

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛД ХҮНИЙ ИХ ЭМЧ МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН ЖИШИГ СОРИЛ - III

Сорилын зөв хариулт

1-C, 2-A, 3-A, 4-C, 5-B, 6-A, 7-D, 8-B, 9-B, 10-B, 11-A, 12-B, 13-E, 14-D, 15-E, 16-A,
17-C, 18-C, 19-C, 20-A, 21-B, 22-C, 23-A, 24-C, 25-A, 26-C, 27-C, 28-A, 29-A, 30-E, 31-
C, 32-A, 33-E, 34-C, 35-A, 36-D, 37-C, 38-E, 39-C, 40-C, 41-C, 42-C, 43-E, 44-E, 45-C,
46-E, 47-C, 48-A, 49-D, 50-C, 51-D, 52-A, 53-A, 54-C, 55-D, 56-D, 57-A, 58-C, 59-B, 60-
C, 61-E, 62-C, 63-A, 64-A, 65-C, 66-C, 67-D, 68-A, 69-C, 70-A, 71-E, 72-D, 73-E, 74-A,
75-A, 76-C, 77-A, 78-A, 79-A, 80-C, 81-C, 82-C, 83-A, 84-A, 85-C, 86-C, 87-E, 88-C, 89-
E, 90-A, 91-E, 92-C, 93-C, 94-A, 95-A, 96-A, 97-A, 98-C, 99-C, 100-E, 101-B, 102-B,
103-B, 104-A, 105-A, 106-C, 107-B, 108-B, 109-A, 110-C, 111-E, 112-D, 113-A, 114-A,
115-A, 116-A, 117-B, 118-A, 119-A, 120-C, 121-B, 122-B, 123-B, 124-A, 125-A, 126-C,
127-E, 128-D, 129-E, 130-C, 131-E, 132-D, 133-B, 134-C, 135-D, 136-C, 137-D, 138-E,
139-C, 140-E, 141-C, 142-C, 143-E, 144-B, 145-E, 146-E, 147-C, 148-B, 149-D, 150-E,
151-A, 152-B, 153-B, 154-A, 155-C, 156-C, 157-B, 158-B, 159-C, 160-E, 161-B, 162-A,
163-A, 164-D, 165-A, 166-B, 167-B, 168-B, 169-C, 170-A, 171-A, 172-A, 173-B, 174-A,
175-A, 176-B, 177-B, 178-D, 179-A, 180-C, 181-C, 182-A, 183-D, 184-D, 185-B, 186-A,
187-C, 188-A, 189-B, 190-A, 191-B, 192-B, 193-B, 194-C, 195-C, 196-A, 197-C, 198-A,
199-C, 200-D, 201-B, 202-B, 203-B, 204-B, 205-A, 206-B, 207-A, 208-C, 209-B, 210-C,
211-A, 212-A, 213-B, 214-A, 215-D, 216-E, 217-B, 218-C, 219-B, 220-C, 221-A, 222-C,
223-D, 224-D, 225-A, 226-B, 227-B, 228-B, 229-A, 230-B, 231-B, 232-A, 233-A, 234-A,
235-E, 236-A, 237-E, 238-A, 239-E, 240-A, 241-D, 242-A, 243-B, 244-A, 245-C, 246-A,
/183./ Сүрьеэгийн халдварыг тарааж буйг ямар шинжилгээгээр тодорхойлох вэ?

A. Уушгины гэрлийн шинжилгээ

B. Туберкулины сорил

C. Цусны ерөнхий шинжилгээ

D. Цэрний түрхэцийн шинжилгээ

E. Гуурсан хоолой дурандах шинжилгээ

/184./ Хүүхдэд Мантугийн сорилын урвалыг дүгнэхэд эерэг гэсэн хариу урвал үүссэн бол ямар арга хэмжээ авах вэ?

- A. БЦЖ вакцин хийнэ
- B. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ
- C. Сүрьеэгийн эмчилгээ хийнэ.
- D. Бусад гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж сүрьеэгээр өвчилсөн эсэхийг тодруулна
- E. Дээрхи бүгд

/185./ Хүнд сүрьеэ өвчин голдуу үүсгэдэг сүрьеэгийн савханцарын төрлийг нэрлэнэ үү?

- A. Үхрийн төрлийн сүрьеэгийн савханцар
- B. Сүрьеэгийн савханцар
- C. Африкийн сүрьеэгийн савханцар
- D. Бусад төрлийн сүрьеэгийн савханцар
- E. Дээрхи бүгд

/186./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?

- A. Уушигны цэр эерэг сүрьеэтэй өвчтөн
- B. Уушигны цэр сөрөг сүрьеэтэй өвчтөн
- C. Уушигны бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн
- D. Уушигны сүрьеэ бусад эрхтэний сүрьеэтэй хавсарсан тохиолдол
- E. Дээрхи бүгд

/187./ Сүрьеэгийн идэвхигүй илрүүлэлтийн арга гэж юу вэ?

A. Бүх хүн амын дунд зориудын урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх

B. Сүрьеэгээр өвчлөх эгзэг өндөртэй хүмүүсийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэтэй тохиолдлыг илрүүлэх

C. Эмчид хандсан үйлчлүүлэгчдээс сүрьеэгийн сэжигтэй шинж илэрсэн тохиолдлыг сонгож, үзлэг шинжилгээ хийж илрүүлэх

D. Сүрьеэтэй өвчтөний хавьтал хүүхдүүдийн дунд урьдчидан сэргийлэх үзлэг хийж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх

E. Дээрхи бүгд

/188./ Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэлтийн арга гэж юу вэ?

A. Бүх хүн амын дунд зориудаар урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх

B. Сүрьеэгээр өвчлөх эгзэг өндөртэй хүмүүсийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэтэй тохиолдлыг илрүүлэх

C. Эмчид хандсан үйлчлүүлэгчдээс сүрьеэгийн сэжигтэй шинж илэрсэн тохиолдлыг сонгож, үзлэг шинжилгээ хийж илрүүлэх

D. Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх

E. Дээрхи бүгд

/189./ Сүрьеэгийн идэвхигүй илрүүлэлтийг сайн явуулахын тулд юу хийх ёстой вэ?

A. Урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулах

B. Хүн амын дунд эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулж үйлчлүүлэгч эмчид тасралтгүй хандаж байх тогтолцоог бүрдүүлэх

C. Сүрьеэгээр өвчлөх эгзэгтэй хүмүүсийг хянах

D. Үйлчилгээний байгууллагын ажилтангуудыг тогтмол урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

E. Дээрхи бүгд

/190./ Сүрьеэгийн идэвхигүй илрүүлэлтэнд ашигладаг оношлогооны гол аргыг нэрлэнэ үү?

A. Цэрний түрхэцийн шинжилгээ

B. Цээжний гэрлийн шинжилгээ

C. Туберкулины сорил

D. Цусны ерөнхий шинжилгээ

E. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/191./ Сүрьеэгийн илрүүлэлтийн аргуудаас хямд бөгөөд илрүүлэх магадлал өндөртэй аргыг нэрлэнэ үү?

A. Идэвхитэй илрүүлэлт

- B. Идэвхигүй илрүүлэлт
- C. Хагас идэвхитэй илрүүлэлт
- D. Урьдчилан сэргийлэх үзлэг
- E. Дээрхи бүгд

/192./ Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг бүртгэх маягтыг нэрлэнэ үү?

- A. ТВ 05
- B. ТВ 15
- C. ТВ 01
- D. ТВ 03
- E. ТВ 06

/193./ Сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх идэвхитэй илрүүлэлтэнд хэрэглэдэг гол шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Цэрний түрхэцийн шинжилгээ
- B. Цээжний гэрлийн шинжилгээ
- C. Туберкулины сорил
- D. Цусны шинжилгээ
- E. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/194./ Өрхийн эмч сүрьеэтэй өвчтөний хавьталуудын дунд урьдчилан үзлэг хийж хүүхдийн сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг ашигласан бэ?

- A. Идэвхитэй
- B. Идэвхигүй
- C. Хагас идэвхитэй
- D. Идэвхитэй болон хагас идэвхитэй аргуудыг хослуулсан
- E. Дээрхи бүгд

/195./ Уушгины сүрьеэтэй цэрний түрхэц “эерэг” өвчтөн жилд дунджаар хэдэн хүнийг сүрьеэгийн нянгаар халдварлуулах эгзэгтэй вэ ?

- A. 1- 10 хүн
- B. 5-10 хүн
- C. 15-20 хүн
- D. 30 хүн
- E. 100 хүн

/196./ 100000 хүн амд сүрьеэгийн хэдэн тохиолдол бүртгэгдсэн бол өвчлөл өндөр гэж үзэх вэ?

- A. 100 тохиолдол 100 000 хүн амд
- B. 30-50 тохиолдол 100 000 хүн амд
- C. 20 тохиолдол 100 000 хүн амд
- D. 10 тохиолдол 100000 хүн амд
- E. Дээрхи бүгд

/197./ Сүрьеэгийн өвчлөлийг хэрхэн тодорхойлох вэ?

- A. Сүрьеэтэй тохиолдолын тоог 1000 хүн амд харьцуулж гаргана.
- B. Тухайн жилдээ илэрсэн нийт сүрьеэтэй тохиолдлын тоогоор гаргана
- C. Шинээр илэрсэн тохиолдлын тоог 100 000 хүн амд харьцуулж гаргана.
- D. Бүх сүрьеэтэй тохиолдлын тоог 10000 хүн амд харьцуулж гаргана.
- E. Дээрхи бүгд

/198./ Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан тохиолдлын хэдэн хувь нь өвчлөх магадлалтай вэ?

- A. 0.1
- B. 0.2
- C. 0.05
- D. 1
- E. 0.01

/199./ Сүрьеэгийн нянгаар зөвхөн халдварлагдсаныг тодорхойлох шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Цэрний түрхэцийн шинжилгээ
- B. Гэрлийн шинжилгээ
- C. Туберкулины сорил

D. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

E. Дээрхи бүгд

/200./ Сүрьеэгийн өвчлөл болон тархалтыг бууруулахад нөлөөлдөг гол урьдчилан сэргийлэх аргыг сонгоно уу?

A. Сүрьеэтэй өвчтөнийг тусгаарлах

B. БЦЖ вакцинжуулалт

C. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ

D. Сүрьеэгийн халдварын эх уурхайг эрт илрүүлж, бүрэн төгс эмчлэх

E. Урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийх

/201./ Сүрьеэгийн нянгийн эсрэг БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлал тогтвортой юу?

A. Тогтвортой, насан туршид хадгалагдана

B. Тогтворгүй, дундажаар 6-7 жил хадгалагдана

C. Тогтворгүй ч 15 жил хадгалагдана.

D. Хувь хүнээс шалтгаалж тогтвортой байж болно

E. Дээрхи бүгд

/202./ Анхдагч халдварын үед сүрьеэгийн савханцар уушгины цулцанд нэвтэрч орсон тохиолдолд өвөрмөц бус хамгаалах урвал хэрхэн явагдах вэ?

A. Фагоцитоз төгс явагдаж, сүрьеэгийн нянг устгана

B. Фагоцитоз төгс бус явагдаж, сүрьеэгийн нян нь залгиур эсийн дотор үржиж, эсийг үхэж устгах үед чөлөөлөгдөнө

C. Эсийн түвшинд дархлалын урвал өрнөнө

D. Шингэний түвшинд дархлалын урвал өрнөнө

E. Дээрхи бүгд

/203./ Сүрьеэгийн нянгийн эсрэг үүсэх дархлалын урвалд гол үүрэг гүйцэтгэх дархлалын эсийг нэрлэнэ үү?

A. В лимфоцит

B. Т лимфоцит

C. Нейтрофилүүд

D. Аварга эс

E. Залгиур эс

/204./ БЦЖ вакцин гэж юу вэ ?

A. Сүрьеэгийн үхсэн савханцар

B. Хоруу чанаргүй сүрьеэгийн амьд савханцар

C. Сүрьеэгийн савханцарын хор

D. Сүрьеэгийн савханцарын эд эсийн хэсэг

E. Бүрэн бус антиген

/205./ БЦЖ вакциныг хаана тарих вэ ?

A. Арьсан дотор

B. Арьсан дор

C. Судсанд

D. Арьсан дээр

E. Булчинд

/206./ БЦЖ вакцины сорви ямар хэмжээтэй байвал үр дүнтэй дархлал тогтсон гэж үзэх вэ?

A. 2 мм

B. 4-6 мм

C. 16 мм

D. 1 мм

E. Дээрхи бүгд

/207./ БЦЖ вакциныг зөв хийсэн тохиолдолд сорви үүсэх магадлал хэдэн хувь байдаг вэ?

A. 90-95%

B. 70-80%

C. 0.6

D. 0.5

E. Дээрхи бүгд

/208./ БЦЖ вакциныг найруулаад хэдэн цагийн дотор тарьж хэрэглэх ёстой вэ?

A. 30 мин

- B. 1 цаг
- C. 2 цаг
- D. 5 цаг
- E. 24 цаг

/209./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээг ямар зорилгоор хийдэг вэ?

- A. Сүрьеэгийн халдвараас сэргийлэх
- B. Сүрьеэгээр өвчлөхөөс сэргийлэх
- C. Сүрьеэ даамжирхаас сэргийлэх
- D. Сүрьеэгийн хүндэрлээс сэргийлэх
- E. Дээрхи бүгд

/210./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү?

- A. Стрептомицин
- B. Рифампицин
- C. Изониазид
- D. Этамбутол
- E. Дээрхи бүгд

/211./ Туберкулин гэж юу вэ?

- A. Сүрьеэгийн нянгийн эндотоксин
- B. Сүрьеэгийн амьд нян
- C. Сүрьеэгийн үхсэн нян
- D. Сүрьеэгийн нянгийн омгуудын холимог
- E. Бод малын төрлийн сүрьеэгийн савханцар

/212./ Туберкулины сорилыг хаана хийх вэ?

- A. Арьсан дотор
- B. Арьсан дор
- C. Булчинд
- D. Судсанд
- E. Дээрхи бүгд

/213./ Туберкулины сорилын эерэг хариу урвал юуг илтгэх вэ?

- A. Сүрьеэгээр өвчилсөн байгааг батална
- B. Сүрьеэгийн нянгаар халдварлагдсаныг илтгэнэ
- C. Сүрьеэгийн нянгаар халдварлагдаагүй болохыг илтгэнэ.
- D. Анхдагч халдварыг тодорхойлно
- E. Дээрхи бүгд

/214./ Манай оронд туберкулины сорилыг Мантугийн аргаар хийхэд хэрэглэх туберкулины нэгж тунг сонгоно уу?

- A. 2 ТН
- B. 5 ТН
- C. 1 ТН
- D. 20 ТН
- E. 10 ТН

/215./ Мантугийн сорилын хариу урвалд цэврүү, үхжил үүссэн байвал урвалыг хэрхэн дүгнэх вэ?

- A. Дахин шалгах
- B. Дүгнэх боломжгүй
- C. Эргэлзээтэй
- D. Эерэг
- E. Сөрөг

/216./ Мантугийн сорилын хариу урвалд гүвдрүүгүй мөртлөө, улайлт үүссэн бол урвалыг хэрхэн дүгнэх вэ?

- A. Дахин шалгах
- B. Дүгнэх боломжгүй
- C. Эргэлзээтэй
- D. Эерэг
- E. Сөрөг

- /217./ Улаан эсэргэнэ өвчин нь нь стрептококкоор үүсгэгддэг бөгөөд өвчин агаар дуслын замаар дамжин халдварладаг тул амьсгалын замын үрэвслийн шинжүүдээр өвчин эхэлдэг.
- /218./ Урвах тахал өвчний үед илрэх шингэн алдалтын 3-р зэргийн үед биеийн жингийн хэдэн хувийг алддаг вэ?
- A. 4-6%
 - B. 6-8%
 - C. 7-9%
 - D. 8-10%
 - E. 10%-иас дээш
- /219./ Улаан эсэргэнэ өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?
- A. Рабдовирус
 - B. Стрептококк
 - C. Стафилококк
 - D. Плазмид
 - E. Миксовирус
- /220./ Улаан эсэргэнэ өвчний халдварын эх уурхай юу вэ?
- A. Вирус тээгч
 - B. Нян тээгч
 - C. Өвчтэй хүн, нян тээгч
 - D. Өвчтэй мал амьтад
 - E. Өвчтэй хүн ба мал амьтад
- /221./ Улаан эсэргэнэ өвчний халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?
- A. Агаар дуслаар
 - B. Ахуйн хавьтал
 - C. Хоол хүнс
 - D. Бэлгийн зам
 - E. Парентераль зам
- /222./ Улаан эсэргэний үед өвчтөний царай ямар байх вэ?
- A. Цонхигор
 - B. Улаан
 - C. Улаан, хамар уруулын гурвалжин цагаан
 - D. Нүд улайсан байна
 - E. . Хэвийн
- /223./ Улаан эсэргэнэ өвчний үед тууралт дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?
- A. эхний өдөр
 - B. эхний өдрийн сүүлч 3 дахь өдрийн эхэн үе
 - C. 3 -5 хоног
 - D. 3-7 хоног
 - E. 7-10 хоног
- /224./ Балнад өвчин нь стафилококкоор үүсгэгддэг бөгөөд үүсгэгч нь нарийн гэдэсний тунгалагийн зангилааг сонгомолор гэмтээдэг тул хэвлийг тэмтрэхэд хүчтэй өвдөлт илэрдэг.
- /225./ Цусан суулга өвчин нь бүдүүн гэдэсний төгсгөлийн хэсгийг гэмтээдэг бөгөөд үүсгэгчийн дотор хорын нөлөөгөөр гэдэсний хөдөлгөөн мэдрэл гэмтэж, гүрвэлзэх хөдөлгөөн ихэсдэг тул гэдэс хүчтэй базалж өвдөн, цус залхагтай баадаг.
- /226./ Цусан суулгын үүсгэгч Григорьев Шига нь гадар хорыг ялгаруулдаг ба энэ нь эс хордуулах, гэдэс хордуулах, мэдрэл хордуулах үйлчилгээтэй тул өвчтөн усгүйжилтэнд амархан ордог.
- /227./ Бруцеллез нь өвчтэй мал амьтдаас хүнд халдварладаг ба үүсгэгч нь тулгуур хөдөлгөөн, мэдрэл, шээс, бэлгийн, мөн цус төлжүүлэх тогтолцоог зонхилон гэмтээдэг тул халдвар харшлын шинж үүсэхгүй.
- /228./ Менингококкийн халдварын үед бөөрний дээд булчирхайн цочмог дутал элбэг тохиолддог бөгөөд үүний улмаас адреналин, норадреналины шүүрэл алдагддаг тул цус алдах шинж илэрнэ.
- /229./ Улаан бурхан өвчний үед үүсэх хожуу үеийн хүндрэл гэдэг нь нөсөөжилтын үед үүсэх ба түүний гол шалтгаан нь нян бөгөөд уушигны хатгаа, дунд чихний үрэвсэл, бүдүүн гэдэсний үрэвсэл зэргээр хүндэрч болно.

/230./ Урвах тахал гэдэг нь вибрионоор үүсгэгддэг өвчин бөгөөд энэ үед бөөлжилт, суулгалтаар бие махбод эрдэс давс, усаа их хэмжээгээр гадагш алддаг тул аюул багатай өвчин юм.

/231./ Гахайн хавдарын үүсгэгч нь РНХ агуулсан вирус бөгөөд шүлсний булчирхайг голчлон гэмтээдэг тул амьсгал бачуурлыг үүсгэдэг.

/232./ Сүрьеэгийн халдвар дамжих гол замыг нэрлэнэ үү?

- A. Амьсгалын зам
- B. Хоол тэжээл
- C. Ихэс
- D. Гэмтсэн арьс, салст
- E. Дээрхи бүгд

/233./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?

- A. Уушигны цэр эерэг сүрьеэтэй өвчтөн
- B. Уушигны цэр сөрөг сүрьеэтэй өвчтөн
- C. Уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн
- D. Уушигны сүрьеэ бусад эрхтэний сүрьеэтэй хавсарсан тохиолдол
- E. Дээрхи бүгд

/234./ Хиамдал өвчин үүсэх нөхцөл бол.....

- 1. Нөөшилсөн мөөг идэх
- 2. Нөөшилсөн өргөст хэмх идэх
- 3. Утсан махан бүтээгдэхүүн идэх
- 4. Жимсний чанамал идэх
- 5. Жимсний шүүс уух

/235./ Галзуу өвчний эхэн үед ямар шинжүүд илрэх вэ?

- 1. Айж сандрах
- 2. Нойронд муу
- 3. Шархны орчим өвдөх, хорсох ирвэгнэ
- 4. Халуурах
- 5. Гар хөл ирвэгнэж мэдээ алдах

/236./ Боомын үүсгэгч ямар хор ялгаруулах вэ?

- 1. Бүрхүүлийн
- 2. Үхүүлэх хор
- 3. Хавагнуулах
- 4. Энтеротоксин
- 5. Некротоксин

/237./ Сүрьеэгийн эрчимт шатны эмчилгээний гол зорилгыг нэрлэнэ үү?

- A. Идэвхитэй үржиж буй нянг устгах
- B. Үрэвслийн процессыг дарангуйлах
- C. Эмийн дасал үүсэхээс сэргийлэх
- D. Сүрьеэгийн эмчилгээний үр дүнг дээшлүүлэх
- E. Дээрхи бүгд

/238./ Гахайн хавдрын үед төмсөг хавдсан үед ямар эмчилгээ хийх вэ?

- 1. Хүйтэн жин тавих
- 2. КС гормон
- 3. Сойж боох
- 4. УВЧ
- 5. Бүлээн жин

/239./ В гепатитаас сэргийлэх тарилгыг тарих насыг зөв сонго.

- 1. Төрсний дараа 24 цагийн дотор
- 2. 2 сартайд
- 3. 3 сартайд
- 4. 4 сартайд
- 5. Бүгд зөв

/240./ Элэгний эсийн дутлыг илтгэх биохимийн үзүүлэлтүүдийг сонго.

- 1. Альбумин буурах
- 2. Протромбины индекс буурах

3. Билирубин ихсэх
 4. Бета – липопротейд буурах
 5. Сульма ихсэх
- /241./ Балнад өвчний тууралт зонхилон хаана гардаг вэ?
1. Нүүрэн дээр
 2. Алга,улан дээр
 3. Гарын сарвуу, нуруун дээр
 4. Цээж хэвлий орчим
 5. Толгойн хэсгээр
- /242./ Балнад өвчний халууралтын онцлог шинжүүдийг сонгоно уу?
1. Өдөр ирэх тутам даамжирна
 2. Хөлрөхгүй
 3. Арьс хуурай
 4. Халуунтай тохирсон тахикарди илэрнэ
 5. Чичирнэ, хөлөрнө
- /243./ Боомын арьсны хэлбэр ямар байдлаар илрэх вэ?
1. Ёлом төст
 2. Хавдарт
 3. Цэврүүт
 4. Хатиг төст
 5. Шархлаат
- /244./ Урвах тахал өвчний баасны сонгодог шинж чанарыг тэмдэглэ.
1. Усархаг, цайвар
 2. Хэмжээ их
 3. Үнэргүй
 4. Цусны судалтай
 5. Хоолны үлдэцтэй
- /245./ Томуугийн үүсгэгчийн шинжүүдийг түүж бич.
1. Ретровирус
 2. Ортомиксовирус
 3. ДНХ агуулсан
 4. Хатаах буцалгахад амархан үхнэ
 5. Гадаад орчинд тэсвэртэй
- /246./ Аденовирус халдвар эмнэл зүйн ямар хэлбэрүүдээр явагдах вэ?
1. Конъюнктивит
 2. Фарингит
 3. Кератит
 4. Колит
 5. Менингит
- /247./ Элэгний цочмог энцефалопатийг эмчлэхэд зайлшгүй чухал эмчилгээний аргуудыг сонго.
1. Тархины хаванг бууруулах
 2. Ходоод гэдсийг цэвэршүүлэх
 3. Уургийн задралыг саатуулагч ферментүүдийг тарих
 4. Хүчилтөрөгч амьсгалуулах
 5. Хордлого тайлах
- /248./ Архаг В гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмчилгээний аргыг сонгоно уу?
1. Эссенциале форте 2 калсул өдөрт 3 удаа 2 сар уух
 2. Интерферон схемээр тарих
 3. Легалон 90 мг өдөрт 3 удаа уух
 4. Ламивудин 100 мг өдөрт 1 удаа уух
 5. Витамин .С. 5% - 2.0 + Глюкозын хамт тарих
- /249./ Архаг В гепатитын үед Интерферон эмчилгээ хийх үзүүлэлтүүдийг сонго.
1. Алат фермент хэвийн байх
 2. HBe Ag / + /
 3. Тимол өндөр байх

4. АлАт ферментийн идэвх 2-5 дахин их байх

5. Альбумины хэмжээ буурах

/250./ Балнад өвчний үед тохиолдох онцлог шинжүүдийг сонгоно уу?

1. Өнгөртэй зузаан хэл

2. Падалкийн шинж

3. Филлипповичийн шинж

4. Стефанскийн шинж.

5. Гиппократын царай

/251./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго

1. Ангина тод илрэх

2. Ангина илрэхгүй

3. Тууралт нүүрнээс эхэлнэ

4. Арьс салст гэмтсэн байх

5. Хоолойн булчирхай үрэвсэх

/252./ Хөөмийн сахуугийн хордлогот хэлбэрийн үед ямар хүндрэлүүд илэрч болох вэ?

1. Хордлогот миокардит

2. Тагнай , залгиурын саа

3. Нефроз

4. Менингит

5. Уушгины хатгаа.

/253./ Балнад өвчний өвөрмөц бус хүндрэлийг тэмдэглэнэ үү?

1. Гломерулонефрит

2. Дисбактериоз

3. Усгүйжилт

4. Нарийн гэдэснээс цус алдах

5. Гэдэс цоорох

/254./ Балнад өвчний үед ямар халууралт байх вэ?

1. Вундерлихийн

2. Килдюшевскийн

3. Боткины

4. Гектический

5. Халуунгүй

/255./ Томуу өвчний эхлэл үеийн шинжүүдийг нэрлэ.

1. 38.5-40 хэм хүрч халуурна

2. Толгой өвдөнө

3. Үе мөч, булчингаар шархирч өвдөнө

4. Ханиалгана

5. Хамар битүүрнэ

/256./ Парагриппийн халдварын үеийн эмнэлзүйн шинжүүдийг тэмдэглэ.

1. Бүх булчингаар өвдөх

2. Хуцуулж ханиах

3. Нүдний алим өвдөх

4. Хоолой сөөх

5. Шингэн нус их гоожих

/257./ Цусан суулга өвчин нэг хүртлэх насны хүүхдэд ямар онцлогтой илэрдэг вэ?

1. Өтгөн ус ихтэй, усгүйжилтэнд амархан орно

2. Өтгөн салс ихтэй

3. Бүдүүн гэдэсний үрэвслийн шинж бүдэг илэрсэн

4. Дисбактериоз болох нь амархан

5. Бөгсний амсар онгойно

/258./ Сахуугийн савханцар ямар хор фермент ялгаруулдаг вэ?

1. Гиалуранидаза

2. Нейраминадаза

3. Гадар хор

4. Дотор хор

5. Цистиназа

/259./ Бруцеллийн эмгэг төрүүлэгч чанарыг тэмдэглэнэ үү?

1. Гадар хор ялгаруулдаг
2. Эд, эсэд нэвтрэх инвазив чанар сайн
3. эсийн үхжил үүсдэг
4. Эсийн дотор шимэгчлэн орших
5. Тэжээлт орчинд хурдан ургана

/260./ Бруцеллезтэй өвчтөнг хэдийд халуун шавар, рашаан, сувилалд явуулж болох вэ?

1. Цочмог хэлбэр
2. Үлдэц хууч
3. Архаг үрэвсэл сэдэрсэн
4. Архаг үрэвсэл намдсан
5. Аль ч үед болно

/261./ Бруцеллез өвчний үед антибиотик эмчилгээ хийх заалтуудыг сонго.

1. Анхдагч далд хэлбэр
2. Цочмог хэлбэр
3. Үлдэц хууч
4. Үхжил - үсэрхийлсэн
5. Архаг үрэвсэл намдсан

/262./ Халдвартын больницын тасаг ямар зохион байгуулалттай вэ?

1. Ердийн палат
2. Боксын
3. Боксын бус
4. Хагас боксын
5. Төлбөртэй

/263./ Хүний биеийн өвөрмөц бус хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?

1. Арьс салстын хамгаалах урвал,
2. Лизоцим ба ходоодны хүчил
3. Амьсгалын замын намираа хучуур эд
4. Т- лимфоцит
5. Эсрэг бие

/264./ Хүний биеийн өвөрмөц хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?

1. В - лимфоцит ба дархлааны ой дурсамж
2. түргэн зуурын хэт мэдрэг чанар
3. эсрэг бие үүсэх
4. Макрофаг
5. Шүлс,

/265./ Халдвартын бүтэн боксонд ямар өвчтөнг хэвтүүлэх вэ?

1. Онош тодорхойгүй өвчтөн
2. Агаар дуслын халдварт өвчтэй хүн
3. Гоц халдварт өвчтэй
4. Гэдэсний халдварт
5. Бэлгийн замын халдварт өвчтэй

/266./ В гепатитын үүсгэгчийн эсрэг төрөгчдийг тэмдэглэнэ үү?

1. HBsAg
2. HBcAg
3. HBe Ag
4. HA-Ag
5. HDcAg

/267./ Гепатитын В вирусийн халдварыг дамжуулж болох хүчин зүйлийг тэмдэглэ.

1. Цус
2. Зүү тариур
3. Үрийн шингэн
4. Бохир гар
5. Ахуйн хавьтал

/268./ Архаг гепатит, элэгний цирроз улмаар хавдар үүсгэдэг вирусүүдийг тэмдэглэ

1. Гепатитын D вирус

2. Гепатитын В вирус
3. Гепатитын С вирус
4. Гепатитын А вирус
5. Гепатитын Е вирус

/269./ Архаг гепатит, элэгний цирроз, хавдарын шалтгаан болдоггүй вирусүүдийг тэмдэглэ.

1. Гепатитын С вирус
2. Гепатитын А вирус
3. Эпштейн Баррын вирус
4. Гепатитын Е вирус
5. Гепатитын D вирус

/270./ Гепатитын С болон D вирусийн халдвар дамжиж болох замуудыг сонго.

1. Агаар дусал
2. Бэлгийн зам
3. Хоол боловсруулах
4. Арьс салстын шархаар
5. Шавьж ба дамжуулагч

/271./ Гахай хавдрын үед шүлсний булчирхайн хавдрын онцлог ямар байх вэ?

1. Хавдар хатуу
2. Хавдарын өнгө нь өөрчлөгдөөгүй
3. Хавдсан хэсэг халуун, эмзэглэлтэй
4. Хавдарын орчимд ямар ч өөрчлөлтгүй
5. Хавдсан хэсгийн арьс улайсан

/272./ Гахай хавдар өвчний ид үед эмнэл зүйн ямар шинжүүд илрэх вэ?

1. Ам ангайж болохгүй өвдөнө
2. Хоёр талын шүлсний булчирхай хавдсан
3. Бага зэрэг халуурна
4. Толгой таллаж хүчтэй өвдөнө.
5. Маш их хэмжээгээр бөөлжинө

/273./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн эмчилгээг тэмдэглэ

1. УВЧ-ээр шарах
2. Бүлээн ба спиртен бигнүүр
3. Шүлс бага ялгаруулах шингэвтэр хоол
4. Хацарт хүйтэн жин
5. Цус тогтоох эмчилгээ зайлшгүй хийнэ

/274./ Цочмог цусан суулгын колитын хэлбэрийн үед ямар шинжүүд илрэх вэ?

1. Өвчний эхлэл хурц
2. Хий дүлнэ
3. Хэвлийн доод хэсгээр базалж өвдөнө
4. Ус ихтэй суулгана
5. Маш их хөстэй

/275./ Цочмог цусан суулгын үед эмгэг анатомын ямар өөрчлөлт гарч болох вэ?

1. Салст бүрхүүл улайж үрэвссэн
2. Фибринт өнгөр
3. Шархлаа үүссэн
4. Салст бүрхүүл үхэжсэн, цоорсон
5. Цус алдсан байна

/276./ Цусан суулгыг оношлоход оношлогооны ямар аргуудыг голлон ашигладаг вэ?

1. Нян судлал
2. Копрологи
3. Серологи
4. Фермент холбоот эсрэг биеийн урвал
5. Вирус судлал

/277./ Төвөнхийн сахуугийн эмнэл зүйн шинжүүд юу вэ?

1. 38 хэм хүртэл халуурна
2. Хоолой сөөж ханиана
3. Төвөнхийн салстад зузаан өнгөр тогтдог

4. Гүйлсэн булчирхай, хүүхэн хэл зузаан саарал өнгөртэй
 5. Гүйлсэн булчирай эмзэглэлтэй
- /278./ Бруцеллезийн халдвар дамжих замуудыг сонго
1. Гэмтсэн арьс салстаар
 2. Агаар тоос
 3. Хоол боловсруулах
 4. Шавьж, мэрэгчид
 5. Цусаар
- /279./ Бруцеллез өвчний эмгэг жамын үе шатууд
1. Тунгалагаар зөөгдөх
 2. Цусны урсгалаар зөөгдөх
 3. Олон голомтот халдвар үүсгэх
 4. Голомтоос нян дахин цусанд эргэх
 5. Метаморфоз буюу үлдэц, төгсгөл, эдгэрэх үе
- /280./ Сальмонеллезын ходоод гэдэсний хэлбэрт орохгүй хувилбарыг сонго.
1. Гастрит
 2. Балнад төст
 3. Гастроэнтерит
 4. Идээт үжил
 5. Гастро-энтероколит
- /281./ Менингококкийн халдварын үед дараахь хүндрэлүүд эрт үед тохиолддог
1. Халдвар хордлогын шок
 2. Тархины цочмог хаван
 3. Бөөрний цочмог дутал, бөөрний дээд булчирхайн цочмог дутал,
 4. Ларингит
 5. Цус алдалт
- /282./ Тархины цочмог хаван үүссэх үндсэн шалтгаан нь:
1. Тархины цусан хангамжийн хямрал
 2. Нугасны усны хөдөлгөөн алдагдах
 3. Тархины эдийн хүчилтөрөгчийн дутал
 4. Тархины хордлого
 5. Тархины бодисын солилцооны хямрал
- /283./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг нэрлэ
1. Толгой хүчтэй өвдөх
 2. Цусархаг тууралт гарах
 3. Олон удаа бөөлжих
 4. Гэнэт өндөр халуурах
 5. Ухаан алдах
- /284./ Тархины цочмог хавангийн зэргийг дараахь шинжүүд илэрхийлнэ
1. Ухаан санааны байдал
 2. Хүүхэн харааны урвал
 3. Мэнэнгийн шинжийн илрэх эрчим болон рефлекс
 4. Тууралтын байдал
 5. Халууралт
- /285./ Менингококкийн халдварын үеийн хожуу тохиолдох хүндрэлд дараах хүндрэлүүд орно.
1. Халдвар хордлогын шок
 2. Эпилепсийн уналт
 3. Тархины цочмог хаван
 4. Тархины дотоод даралт ихсэх хамшинж
 5. Бөөрний дээд булчирхайн цочмог дутал
- /286./ Герпес вирус дараахь дэд бүлгүүдэд хуваагдана
1. Альфа
 2. Гамма
 3. Бетта
 4. Сигма
 5. Эпсилон

/287./ Герпес вирус нь:

1. РНХ агуулсан
2. ДНХ агуулсан
3. Эсийн гадна өсөж үрждэг
4. Липид уургийн бүрхүүлтэй,
5. Зөвхөн амьсгалын замаар халдварладаг

/288./ Герпес вирусийн халдварыг дараахь байдлаар ангилдаг:

1. Анхдагч
2. Дахилтат
3. Түгмэл хэлбэр
4. Байршмал хэлбэр
5. Хавсарсан герпес

/289./ Герпес вирусийн оношлогоонд лабораторийн дараахь аргуудыг хэрэглэнэ

1. Ийлдэс судлалын
2. Вирус судлалын
3. Эс судлалын
4. Нян судлалын
5. Биохимийн

/290./ Герпес вирусын халдварын үед дараахь эмийн бэлдмэлүүдийг хэрэглэнэ

1. Ацикловир
2. Рибавирин
3. Ганцикловир
4. Видарабин
5. Вальцикловир

/291./ Хөхүүл ханиалгын үеийн эмнэлзүйн өвөрмөц шинжүүдийг нэрлэ.

1. Угсруулсан ханиалга
2. Салсархаг зүйлээр бөөлжих
3. Аура буюу зөн совин болон реприз
4. Хоолой сөөх
5. Халуурах

/292./ Халдвар хордлогын шокийн эмнэл зүйн зэргийн шалгуурт орох үзүүлэлтүүдийг тэмдэглэ.

1. Цусархаг тууралтын байдал
2. Артерийн даралтын түвшин болон Гведалийн шинж
3. Шээсний хэмжээ
4. Суулгалтын тоо
5. Гэдэс базлалтын тоо

/293./ Менингококцемийн хүндрэл халдвар хордлогын шокийн үед арьсан дээрх тууралт ямар байх вэ

1. Цөөн тооны гүвдрүүт
2. Олон тооны жижиг үхжилттэй цусархаг
3. Цөөн тооны цусархаг
4. Том том цөөн тооны үхжилттэй цусархаг
5. Олон тооны цэврүүт

/294./ Татрангийн эхлэл үеийн шинжүүдийг тэмдэглэ

1. Хараа муудах, зовхи буух
2. Тризм, сардоник инээмсэглэл
3. Амьсгаадалт, амьсгал бачуурах
4. Юм залгиж чадахгүй
5. Бөөлжих, халуурах, толгой өвдөх

/295./ Татрангийн таталтын онцлогийг тэмдэглэ

1. Өвдөлттэй
2. Их хүчтэй
3. Татах үедээ ухаан алдахгүй
4. Богино хугацааны
5. Сул

/296./ Татрангийн өвөрмөц эмчилгээнд дараах бэлдмэлүүд орно:

1. Тайвшруулах, таталтын эсрэг бэлдмэлүүд
2. Татрангийн хорын эсрэг ийлдэс
3. Антибиотик
4. Татрангийн иммуноглобулин
5. Сульфаниламид

/297./ Халдварт мононуклеозын үед илрэх гол шинж тэмдгүүд:

1. Халуурах
2. Лимфаденит
3. Ангина
4. Тууралт
5. Суулгалт

/298./ Ёлом өвчний эмнэл зүйн ангилалд хамаатай асуудлыг доорхи хариултаас тохируулан сонго.

1. Эритематоз хэлбэр
2. Эритематоз – буллез
3. Буллез – цусархаг
4. Шархлаат
5. Фибринт өнгөрт

/299./ Хиамдал өвчний үүсгэгчийн хорыг..... илрүүлнэ

1. Ходоод угаасан усанд
2. Хоолны үлдцэнд
3. Бөөлжисөнд
4. Өтгөнд
5. Цусанд

/300./ Улаан бурхан өвчний халдвартай үеийг тэмдэглэ.

1. Нууц үеийн төгсгөл
2. Улайралтын үе
3. Тууралтын үе
4. Нөсөөжилтийн үе
5. Өвчний бүх үе шатанд

/301./ Улаан бурхны хөнгөрүүлсэн /митигированная/ хэлбэрийн онцлог

1. Хөнгөн явцтай
2. Нууц хагацаа урт
3. Улайралтын шинж тэмдгүүд бүдэг
4. Хүнд явцтай
5. Тууралт дэс дараатай

/302./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ

1. Усархаг
2. Хэмжээ их
3. Үнэргүй
4. Цусны судалтай
5. Хоолны үлдэцтэй

/303./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.

1. Өндөр настай хүмүүст
2. Хуурай хэлбэр
3. Жирэмсэн эмэгтэйд
4. Цахилгаан хэлбэр
5. Бага насны хүүхдэд

/304./ Менингоккийн мэнэнгийн үед нугасны усанд зонхилон илрэх өөрчлөлтүүдийг тэмдэглэ.

1. Даралт ихсэх
2. Булингартай болох
3. Уураг нэмэгдэх
4. Эсийн тоо цөөрөх
5. Тунгалаг эс зонхилон нэмэгдэх

/305./ Varicella Zoster вирүсийн халдварын гаж хэлбэрүүдийг тэмдэглэ.

1. Том цэврүүт хэлбэр
2. Үхжилт хэлбэр
3. Цусархаг хэлбэр
4. Хөнгөн хэлбэр
5. Хүнд хэлбэр

/306./ Influenza A вирусийн бүрхүүлийн эсрэг төрөгчдийг тэмдэглэ.

1. Т-уураг
2. Нейраминадаза
3. М-уураг
4. Гемагглютинин
5. И-ацетилглюкозамин

/307./ Иерсиниозын халдварыг тараах эх уурхай юу вэ?

1. Хулганы төрлийн мэрэгчид
2. Гэршсэн мэрэгчид
3. Шувууд
4. Гэрийн тэжээмэл амьтад
5. Хүмүүс

/308./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг тэмдэглэнэ үү?

1. Толгой хүчтэй өвдөх
2. Цусархаг тууралт гарах
3. Олон удаа бөөлжих
4. Гэнэт өндөр халуурах
5. Ухаан алдах

/309./ Тархины цочмог хавангийн зэргийг дараах шинжүүд илэрхийлнэ.

1. Ухаан санааны байдал
2. Хүүхэн харааны урвал
3. Менингитийн шинжийг илрэх эрчим
4. Рефлекс
5. Хөхрөлт

/310./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.

1. Нууц хугацаа 2-7 хоног
2. Ангина илрэхгүй
3. Тууралт нүүрнээс эхэлнэ
4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
5. Эрүүн дорхи лимфаденит болно

/311./ Улаан эсэргэнэ өвчтөний царай ямар байх вэ?

1. Цонхигор
2. Хацар нь улайсан
3. Хамар уруулын гурвалжин хөх
4. Хамар уруулын гурвалжин цагаан
5. Зовхи хавдсан

/312./ Улаан эсэргэнэ өвчний үед арьсан дээр ямар өөрчлөлт илрэх вэ?

1. Цэгчилсэн толбо-гүвдрүү гарна.
2. Гуужилт
3. Арьсны зураглал цагаан
4. Арьс чийглэг
5. Мөчдийн үзүүр хүйтэн

/313./ Улаан эсэргэний тууралтын үндсэн шинжийг сонго.

1. Том толбот гүвдрүүн тууралт
2. Жижиг цэгэн улаан тууралт
3. Цэврүүт тууралт
4. Загатнана
5. Арьсны өнгө хэвийн

/314./ IgM –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?

1. Хожуу үед үүснэ
2. Эрт үед үүснэ

3. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
 4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
 5. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй
- /315./ IgG –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?
1. Хожуу үед үүснэ
 2. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
 3. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй
 4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
 5. Эрт үед үүснэ.
- /316./ Халдварт өвчний санаа авахуулах шинжид ямар шинжүүд хамаарах вэ?
1. Халуурах
 2. Дотор муухайрах
 3. Бие сулрах
 4. Туурах
 5. Баасны шинж өөрчлөгдөх
- /317./ Бичил биетнийг эмгэг төрүүлэгч чадвараар нь хэдэн бүлэгт хуваадаг вэ?
1. Эмгэг төрүүлэгч,
 2. Эмгэг бус төрүүлэгч,
 3. Болзолт эмгэг төрүүлэгч
 4. Нян
 5. Вирус
- /318./ Халдвар хордлогын шокийн 2-р зэргийн үед артерийн даралтын хэмжээ дараахь байдлаар багасна.
- A. Насны хэвийн хэмжээний 50 % хүртэл бууррах
 - B. Насны хэвийн хэмжээний 50 % -ас дээш багасах
 - C. Зөвхөн артерийн дээд даралт багасах
 - D. Зөвхөн артерийн доод даралт багасах
 - E. Артерийн даралт хэвийн байна.
- /319./ Менингококцемийн хүндийн зэргийг илэрхийлэх гол үзүүлэлт аль нь вэ?
- A. Гэнэт өндөр халуурах
 - B. Менингитийн шинж улам тод илрэх
 - C. Богино хугацаанд цусархаг тууралт гарах
 - D. Толгой өвдөх
 - E. Бөөлжих
- /320./ Халдвар хордлогын шокийн үед үүсгэгчийн дотор хор аль тогтолцоонд сонгомлоор үйлчилдэггүй вэ?
- A. Зүрх судасны тогтолцоо
 - B. Төв мэдрэлийн тогтолцоо
 - C. Комплементийн тогтолцоо
 - D. Хоол боловсруулах тогтолцоо
 - E. Цус бүлэгнүүлэх тогтолцоо
- /321./ Халдвар хордлогын шокийн хүндийн шалгуурт чухал биш шинж тэмдэг аль нь вэ?
- A. Бөөлжилтийн тоо
 - B. Шээсний хэмжээ
 - C. Тууралтын байдал
 - D. Артерийн даралтын түвшин
 - E. Пульсийн тоо
- /322./ Халдвар хордлогын шок элбэг тохиолдох өвчнийг сонгоно уу?
- A. Улаан бурхан
 - B. Галзуу
 - C. Татран
 - D. Менингококкт халдвар
 - E. Вируст гепатит
- /323./ Халдвар хордлогын шокийн эмчилгээ хамгийн түрүүнд-д чиглэгдэнэ.
- A. Таталтын эсрэг
 - B. Гормон эмчилгээ

- C. Шингэн нөхөх
- D. Гемодинамикийн өөрчлөлтөөс гаргах
- E. Хордлого тайлах

/324./ Менингококкийн менингитийн үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. N. Gonorrhoe
- B. N. Meningitides
- C. N. Mucosa
- D. N. Flava
- E. N. Sicca

/325./ Менингококкийн менингитийн халдварын эх уурхай юу вэ?

- A. Вирус тээгч
- B. Нян тээгч
- C. Өвчтэй хүн болон нян тээгч
- D. Өвчтэй мал амьтад
- E. Өвчтэй хүн

/326./ Менингококкийн менингитийн халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?

- A. Агаар дуслаар
- B. Ахуйн хавьтал
- C. Хоол хүнс
- D. Бэлгийн зам
- E. Парентераль зам

/327./ Менингококкийн менингитийн нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?

- A. 1-3 хоног
- B. 1-7 хоног
- C. 2-7 хоног
- D. 11-23 хоног
- E. 18 хоног

/328./ Менингококкийн менингитийн үед нэг өвчтөний эргэн тойронд хэдий тооны нян агуулагч бий болдог вэ?

- A. 500-1000
- B. 1000-10000
- C. 2000-20000
- D. 3000-10000
- E. 4000-15000

/329./ Галзуугийн вирус ямар төрөлд орох вэ?

- A. Парамиксовирус
- B. Ортомиксовирус
- C. Пикарновирүс
- D. Рабдовирүс
- E. Реовирус

/330./ Галзуу өвчин ямар замаар дамжин халдварлах вэ?

- A. Өтгөн мөр-амаар
- B. Агаар дуслаар
- C. Цусаар
- D. Ихэсээр
- E. Шархаар

/331./ Галзуу өвчнөөс сэргийлэх вакциныг хаана тарих вэ?

- A. Булчинд
- B. Арьсан дор
- C. Даланд
- D. Судсанд
- E. Хүйс орчим

/332./ Галзуу өвчний үед ямар эмчилгээ хийх вэ?

- A. Галзуугийн эсрэг вакцин
- B. Галзуугийн эсрэг иммуноглобулин
- C. Антибиотик

D. Сульфаниламид

E. Нейролептик

/333./ Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сонго.

A. Антирабик вакцин тарих

B. СТИ вакцин тарих

C. АКДС вакцин тарих

D. Себины вакцин тарих

E. Хүний иммуноглобулин тарих

/334./ Галзуугийн вирус хүний биед хаана их хэмжээгээр хуримтлагдах вэ?

A. Уураг тархинд

B. Нугасанд

C. Шүлсэнд

D. Гэдсэнд

E. Цусанд

/335./ Галзуу өвчний нууц хугацаа дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?

A. 7-10 хоног

B. 10-14 хоног

C. 12-90 хоног

D. 14-28 хоног

E. 28-80 хоног

/336./ Боом өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

A. Спирохет

B. Ортомиксовирус

C. Рабдовирус

D. Бацилла антрацис

E. Реовирус

/337./ Боом өвчин хүний бие махбодид ямар замаар тархах вэ?

A. Цусаар

B. Лимфээр

C. Периневраль шингэнээр

D. Гэмтсэн арьс салстаар

E. Холимог замаар

/338./ Боом өвчний халдварыг гол тараагч эх уурхай юу вэ?

A. Өвчтэй хүн

B. Шувуу

C. Бод мал, хонь

D. Мэрэгч амьтад

E. Нохой

/339./ Боом өвчний уушигны хэлбэрийн үед ямар цэр гарах вэ?

A. Бүлэгнэсэн цэр

B. Идээтэй

C. Цустай

D. Цайвар

E. Хөөстэй

/340./ Боом өвчний нууц хугацаа дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?

A. 1-2 хоног

B. 1- 4 хоног

C. 2-3 хоног

D. 5-10 хоног

E. 14-30 хоног

/341./ Боомын ямар хэлбэрийн үед үжил болж хүндрэх вэ?

A. Гэдэсний хэлбэр

B. Арьсны хэлбэр

C. Уушигны хэлбэр

D. Бүх хэлбэрийн үед

E. . Үжил үүсэхгүй

/342./ Боом өвчнөөс сэргийлэх вакциныг хаана тарих вэ?

- A. Булчинд
- B. Арьсан дор
- C. Даланд
- D. Арьсан дээр зурж хэрэглэнэ
- E. Хүйс орчим

/343./ Боом өвчний арьсны хэлбэрийн үед үндсэн эмчилгээг Пенициллин G-г ямар тунгаар эхэлж хаана хийх вэ?

A. Пенициллин G 12-с доош насны хүүхдэд кг/ жинд нь 1000000-2000000 нэгжээр 4 цагийн зайтай булчинд буюу судсаар тарина.

B. Пенициллин G 12-с дээш насанд 2 саяаас-4 сая хүртэл нэгжээр 4- 6 цагийн зайтай булчин буюу судсаар тарина.

C. Пенициллин G-г нас харгалзахгүй 500000-2000000 нэгжээр 6 цагийн зайтай булчинд буюу судсаар тарина.

D. Пенициллин G-г 12-с доош насны хүүхдэд кг/ жинд нь 1000000-2000000 нэгжээр 4 цагийн зайтай , 12-с дээш насанд 2 саяаас-4 сая хүртэл нэгжээр 4- 6 цагийн зайтай булчин буюу судсаар тарина.

E. Пенициллин G-г 12-с доош насны хүүхдэд кг/ жинд нь 50000-100000 нэгжээр 6 цагийн зайтай , 12-с дээш насанд 2 саяаас-4 сая хүртэл нэгжээр 4- 6 цагийн зайтай булчин буюу судсаар тарина.

/344./ Боом өвчин савханцар хэдэн төрлийн ямар хор ялгаруулдаг вэ?

- A. Үхүүлэх, хавагнашуулах, бүрхүүлийн
- B. Үхүүлэх болон бүрхүүлийн
- C. Хавагнашуулах болон үхүүлэх
- D. Хавагнашуулах болон бүрхүүлийн
- E. Үхүүлэх

/345./ Тарваган тахал өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Спирохет
- B. Иерсина пестис
- C. Рабдовирус
- D. Бацилла антрацис
- E. Реовирус

/346./ Тарваган тахал өвчин хүний бие махбодид ямар замаар тархах вэ?

- A. Шууд хавьтал
- B. Дам халдвар
- C. Агаар дуслаар
- D. Хоол хүнсээр
- E. Дээрхи хариултууд бүгд зөв

/347./ Тарваган тахал өвчний халдварыг гол тараагч эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн, мэрэгч амьтад
- B. Нохой, шувуу
- C. Өвчтэй хүн, өвчлөөд нас барсан хүний цогцос, мэрэгч туулай, түүний сэг зэм
- D. Мэрэгч амьтад
- E. Өвчтэй хүн, нас барсан хүний цогцос

/348./ Тарваган тахал өвчний эмнэлзүйн хэлбэрүүдийг сонгоно уу?

- A. Арьсны болон уушгины хэлбэр
- B. Уушгины болон гэдэсний хэлбэр
- C. Арьсны, булчирхайн, уушгины, үжил, гэдэсний болон залгиур хоолойн хэлбэр
- D. Арьсны, уушгины болон гэдэсний
- E. Арьсны, уушгины, гэдэсний болон үжилт хэлбэр

/349./ Тарваган тахал өвчний нууц хугацаа дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?

- A. 1-2 хоног
- B. 1- 4 хоног
- C. 2-3 хоног
- D. 5-10 хоног
- E. 14-30 хоног

/350./ Тарваган тахал өвчний арьсны хэлбэрийг ямар өвчнөөс ялган оншлох вэ вэ?

- A. Хачигт энцефалит
- B. Боом өвчний арьсны хэлбэр
- C. Галзуу өвчний арьсны хэлбэр
- D. Татран өвчний арьсны хэлбэр
- E. Шүлхий

/351./ Тарваган тахал өвчний үед дам халдварын зам гэдэгт юуг ойлгох вэ?

- A. Тарваган тахал өвчний уушгины хэлбэрээр өвчилсөн хүнээс халдварлахыг хэлнэ.
- B. Амьтдын бөөс, бүүрэг, цус сорогч, үе хөлтөнд хазуулах тохиолдолд халдвар авахыг хэлнэ
- C. Тарвага агнах, өвчих, нядлах үед тухайн хүний арьсны бүрэн бүтэн байдал алдагдсан үед халдварлахыг хэлнэ.

D. Тарваган тахал өвчтэй хүнийг асрах, сувилах, халдвартай эд зүйлстэй хамгаалах өмсгөл гүй харьцсанаас халдварлахыг хэлнэ

- E. Тахлаар өвчилсөн тарваганы түүхий эд хэрэглэснээс халдварлахыг хэлнэ

/352./ Тарваган тахал өвчний үед шууд хавьтлын зам гэдэгт юуг ойлгох вэ?

- A. Тарваган тахал өвчний уушгины хэлбэрээр өвчилсөн хүнээс халдварлахыг хэлнэ.
- B. Амьтдын бөөс, бүүрэг, цус сорогч, үе хөлтөнд хазуулах тохиолдолд халдвар авахыг хэлнэ.

C. Өвчтэй тарвага агнах, арьс өвчих, мах эвдэх зэрэг үйл ажиллагааны явцад арьс салстын бүтэн байдал алдагдсан үед болон өвчтөнийг асрах, сувилах, халдвартай эд зүйлстэй хамгаалах өмсгөлгүй харьцсанаас халдварлахыг хэлнэ

D. Тарваган тахал өвчтэй хүнийг асрах, сувилах, халдвартай эд зүйлстэй хамгаалах өмсгөл гүй харьцсанаас халдварлахыг хэлнэ.

- E. Тахлаар өвчилсөн тарваганы түүхий эд хэрэглэснээс халдварлахыг хэлнэ.

/353./ Тарваган тахал өвчний үед арьс булчирхайн хэлбэрийн үед ямар ямар сорьц цуглуулж авах вэ?

- A. Арьсан дээрхи цэврүү, хатиг ба шархны шүүдэс үхжсэн хэсэг
- B. Булчирхайн шүүдэс, цус
- C. Өтгөн, залгиурын арчдас
- D. Нугасны шингэн, цус, өтгөн, булчирхайн шүүдэс
- E. Арьсан дээрхи цэврүү, хатиг ба шархны шүүдэс үхжсэн хэсэг, цус болон булчирхайн шүүдэс

/354./ Тарваган тахал өвчний уушгины хэлбэрийн үед ямар ямар сорьц цуглуулж авах вэ?

- A. Арьсан дээрхи цэврүү, хатиг ба шархны шүүдэс үхжсэн хэсэг
- B. Булчирхайн шүүдэс, цус, цэр
- C. Цус, залгиурын арчдас, цэр
- D. Нугасны шингэн, цус, цэр, булчирхайн шүүдэс
- E. Цус болон булчирхайн шүүдэс

/355./ Ёлом өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Парамиксовирус
- B. Стрептококк
- C. Алтлаг стафилококк
- D. Стафилококк эпидермис
- E. Хламид

/356./ Ёлом өвчний үед арьсанд гарах өөрчлөлтийг тэмдэглэнэ үү?

- A. Цэврүү
- B. Улайлт
- C. Хаван
- D. Загатнах
- E. Дээрх бүх өөрчлөлт илэрнэ

/357./ Ёлом өвчний эмчилгээнд хэрэглэдэггүй бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Интерферон тарих буюу түрхэх
- B. Пенициллин тарих
- C. Хэт туяагаар шарах
- D. Харшлын эсрэг эм уулгах

Е. Антисептик уусмалаар шавших

/358./ Хиамдал өвчний үед илрэх анхны шинж тэмдэг аль нь вэ?

- А. Бөөлжих
- В. Амьсгаадах
- С. Нүдний талаас өөрчлөлт гарах
- Д. Таталт
- Е. Хамраас цус гарах

/359./ Хиамдал өвчний нас барах үндсэн шалтгаан аль нь вэ?

- А. Элэгний дутагдал
- В. Бөөрний дутагдал
- С. Гиповолемийн шок
- Д. Уушгины хатгалгаа
- Е. Таталтууд

/360./ Хиамдал өвчний үүсгэгчийн вегетатив хэлбэрийг юугаар устгах вэ?

- А. Гормон
- В. Ийлдэс
- С. Дуслын тариа
- Д. Антибиотик
- Е. Зүрхний гликозидууд

/361./ Хуурамч сүрьеэ өвчний үед илрэхгүй шинжийг тэмдэглэ.

- А. “Юүдэн”-гийн шинж
- В. “Бээлий”-н шинж
- С. “Оймсны” шинж
- Д. “Пастиа-гийн шинж
- Е. Филипповичийн шинж

/362./ Татрангийн үед илрэх анхны шинж тэмдэг

- А. Өндөр халуурах
- В. Толгой хүчтэй өвдөх
- С. Амьсгал бачуурах
- Д. Бөөлжих
- Е. Зажлуур булчингийн чангарал

/363./ Татрангийн үүсгэгчийг тэмдэгэлэнэ үү?

- А. Clostridium botulinum
- В. Clostridium.tetani
- С. Clostridium perfringens
- Д. Clostridium novyi
- Е. Clostridium cereus

/364./ Татрангийн үүсгэгч ямар хор ялгаруулдаг вэ?

- А. Гадар хор
- В. Дотор хор
- С. Энтеротоксин
- Д. Цитотоксин
- Е. дМакрофаг

/365./ Татрангийн үед илрэхгүй шинж аль нь вэ?

- А. Зажлуур булчингийн чангарал
- В. Мимик булчингийн чангарал
- С. Опистотонус
- Д. Суулгалт
- Е. Халууралт

/366./ Халдварт мононуклеоз өвчний эх уурхай юу вэ?

- А. Өвчтэй мал
- В. Өвчтэй хүн ба вирус тээгч
- С. Өвчтэй хүн ба мал
- Д. Эрүүл вирус тээгч
- Е. Ялаа, шумуул

/367./ Эпстайн-Баррын вирус ямар эсийг сонгомлоор гэмтээх вэ?

- A. Макрофаги
- B. Т-лимфоцит
- C. В -лимфоцит
- D. Эритроцит
- E. Лейкоцит

/368./ Халдварт моноклеозын үүсгэгч ямар бүлэгт хамаарах вэ?

- A. Picornaviridae
- B. Herpesviridae
- C. Hepadnaviridae
- D. Retroviridae
- E. Reoviridae

/369./ Улаан эсэргэнэ өвчинд ямар хүмүүс илүү өртөмтгий вэ?

- A. 1 хүртэл насныхан
- B. 1-3 насныхан
- C. 3-10 насныхан
- D. 10-18 насныхан
- E. Насанд хүрэгчид

/370./ Улаан эсэргэнээр өвчилсний дараа ямар дархлаа тогтох вэ?

- A. Хорын эсрэг тогтвортой
- B. Хорын эсрэг тогтворгүй
- C. Нянгийн эсрэг тогтвортой
- D. Нянгийн эсрэг тогтворгүй
- E. Дархлаа тогтохгүй

/371./ Улаан бурхан өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Picornaviridae
- B. Herpesviridae
- C. Hepadnaviridae
- D. Retroviridae
- E. Paramixoviridae

/372./ Улаан бурхан өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Вирүс тээгч
- B. Нян тээгч
- C. Өвчтэй хүн
- D. Өвчтэй мал амьтад
- E. Өвчтэй хүн ба мал амьтад

/373./ Улаан бурхан өвчний халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?

- A. Агаар дуслаар
- B. Ахуйн хавьтал
- C. Хоол хүнс
- D. Бэлгийн зам
- E. Парентераль зам

/374./ Улаан бурхан өвчний нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?

- A. 3-5 хоног
- B. 5-7 хоног
- C. 9-11 хоног
- D. 11-23 хоног
- E. 18 хоног

/375./ Улаан бурхан өвчний үед үүсэх тууралтын элементийг тэмдэглэнэ үү?

- A. Цусархаг
- B. Цэврүүт
- C. Гүвдрүүт
- D. Розеол
- E. Полиморф тууралт

/376./ Улаан бурхан өвчин ямар замаар дамжин халдварлах вэ?

- A. агаар-дуслаар
- B. Цусаар

- C. Ахуйн хавьтлаар
- D. Мэрэгч амьтдаар
- E. Ихэсээр

/377./ Улаан бурхан өвчний үед илрэхгүй шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?

- A. Өндөр халуурах
- B. Ангина
- C. Тууралт
- D. Нүд улайх
- E. Нусгайтах

/378./ Улаан бурхан өвчний үед тууралт анх хаагуур гарах вэ?

- A. Доод мөчдөөр
- B. Их биеэр
- C. Дээд мөчдөөр
- D. Хүзүүгээр
- E. Чихний араар

/379./ Улаан бурхны үүсгэгч ямар эсийг гэмтээх вэ?

- A. Эпители эс
- B. Элэгний эс
- C. Энтероцит эс
- D. Улаан эс
- E. Цагаан эс

/380./ Улаан бурхны үед гарах өвөрмөц шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?

- A. Пастиагийн шинж
- B. Бельский- Филатов- Копликийн шинж
- C. Ашнерийн шинж
- D. Филлиповичийн шинж
- E. Падалкийн шинж

/381./ Улаанууд өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Picornaviridae
- B. Herpesviridae
- C. Hepadnaviridae
- D. Rubiviridae
- E. Paramixoviridae

/382./ Улаанууд өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Вирүс тээгч
- B. Нян тээгч
- C. Өвчтэй хүн
- D. Өвчтэй мал амьтад
- E. Өвчтэй хүн ба вирүс тээгч

/383./ Улаанууд өвчний халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?

- A. Агаар дуслаар болон ихсээр
- B. Цус
- C. Хоол хүнс
- D. Бэлгийн зам
- E. Парентераль зам

/384./ Улаанууд өвчний нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?

- A. 3-5 хоног
- B. 5-7 хоног
- C. 9-11 хоног
- D. 11-23 хоног
- E. 18 хоног

/385./ Улаанууд өвчний үед үүсэх тууралтын элементийг тэмдэглэнэ үү?

- A. Цусархаг
- B. Цэврүүт
- C. Толбот- гүвдрүүт
- D. Розеол

Е. Полиморф тууралт

/386./ Улаанууд өвчний өвөрмөц шинж болох тунгалагийн булчирхайн томролт өвчний ид үед ямархуу байдалтай тэмтрэгддэг вэ?

А. Эмзэглэлтэй, хатуувтар тэмтрэгдэнэ

В. Зөөлөн тэмтрэгдэнэ

С. Хатуу тэмтрэгдэнэ

Д. Эмзэглэлтэй, зөөлөн тэмтрэгдэнэ

Е. Эмзэглэлтэй, зөөлөн, хөдөлгөнтэй тэмтрэгдэнэ

/387./ Улаанууд өвчний өвөрмөц шинж болох тунгалагийн булчирхайн томролт арьсны тууралт гарахаас хэдэн цагийн өмнө ихэвчлэн ажиглагдах вэ?

А. 3-7 цаг

В. 5-10 цаг

С. 10-14 цаг

Д. 24 цагийн дотор

Е. 24-48 цаг

/388./ Төрлөхийн улаанууд өвчний үед гарах үндсэн шинж тэмдэгийг сонгоно уу?

А. Дүлийрэл, сэтгэцийн өөрчлөлт

В. Зүрхний гажиг, нүдний катаракт

С. Дүлийрэл болон нүдний катаракт, зүрхний гажиг

Д. Зүрхний гажиг болон дүлийрэл

Е. Зүрхний гажиг, сэтгэцийн өөрчлөлт, дүлийрэл

/389./ Салхин цэцэг өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

А. Picornaviridae

В. Herpesviridae

С. Hepadnaviridae

Д. Varicella-Zoster virus

Е. Paramixoviridae

/390./ Салхин цэцэг өвчний халдварын эх уурхай юу вэ?

А. Вирүс тээгч

В. Нян тээгч

С. Өвчтэй хүн

Д. Өвчтэй мал амьтад

Е. Өвчтэй хүн ба вирүс тээгч

/391./ Салхин цэцэг өвчний халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?

А. Агаар дуслаар

В. Цус

С. Хоол хүнс

Д. Бэлгийн зам

Е. Парентераль зам

/392./ Салхин цэцэг өвчний нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?

А. 3-5 хоног

В. 9-11 хоног

С. 11-21 хоног

Д. 11-23 хоног

Е. 18 хоног

/393./ Салхин цэцэг өвчний үед үүсэх тууралтын онцлогийг тэмдэглэнэ үү?

А. Цусархаг

В. Цэврүүт

С. Гүвдрүүт

Д. Розеол

Е. Полиморф тууралт

/394./ Салхин цэцгийн болон бүсэлхий ярын вирүс нь аль бүлэгт хамаарагддаг вэ?

А. Герпес вирүсийн альфа дэд бүлэгт хамаарагдана

В. Герпес вирүсийн бетта дэд бүлэгт хамаарагдана

С. Герпес вирүсийн гамма дэд бүлэгт хамаарагдана

Д. Герпес вирүсийн альфа болон гамма бүлгүүдэд хамаарагдана

- Е. Герпес вирусийн альфа болон бетта бүлгүүдэд хамаарагдана
- /395./ Энгийн герпес вирус 1 нь:
- А. Мэдрэлийн зангилаанд далд байдалд оршдог
 - В. Зөвхөн тунгалагийн эсийн дотор өсөж үржинэ
 - С. Шүлсний булчирхайн хучуур эдэд өсөж үржинэ
 - Д. Тухайн эсийн хэмжээг томруулдаг
 - Е. Макрофаг дотор үржинэ.
- /396./ Энгийн герпес вирус 2 нь ямар замаар дамжин халварлах вэ?.
- А. Амьсгалын замаар
 - В. Бэлгийн болон ихэсийн замаар
 - С. Хоол боловсруулах замаар
 - Д. Цусаар
 - Е. Парентераль замаар
- /397./ Салхин цэцэг ба бүсэлхий ярын халдвар нь:
- А. Нэгэн төрлийн вирусаар үүсгэгддэг
 - В. Арьсан дээр цэврүүт тууралтаар илэрдэг
 - С. Тухайн вирусын халдварын эмнэлдзүйн анхдагч хэлбэр нь салхин цэцэг
 - Д. Тухайн вирусын халдварын дахилтат хэлбэр нь бүсэлхий яр
 - Е. Дээрх бүх хариулт зөв
- /398./ Халдвар хордлогын шокийн үеийн эмчилгээнд гепариныг хийх үе аль нь вэ?
- А. Гипокоагуляци
 - В. Гиперкоагуляци
 - С. Цитолиз
 - Д. Афибриногенеми
 - Е. Холестаз
- /399./ Халдвар хордлогын шокийн үед илэрдэг нэгэн өвөрмөц шинж болох Гведалийн шинжийг тодорхойлно уу?
- А. Хамар уруулын гурвалжин хөхрөх шинж
 - В. Арьсан дээр дарахад цайх шинж
 - С. Арьсан дарахад улайх шинж
 - Д. Хөлийн үзүүр цайрч хөхрөх шинж
 - Е. . Арьс эрээнтэх шинж
- /400./ Балнад өвчний халдварын эх уурхай аль нь болдоггүй вэ?.
- А. Богино хугацаанд нян ялгаруулагч
 - В. Архаг нян хадгалагч
 - С. Балнадаар өвчлөөд эдгэрч буй хүн
 - Д. Өвчний ид үедээ байгаа өвчтөн
 - Е. Өвчтэй адгуусан амьтад
- /401./ Балнад өвчний халдвар дамжих замыг сонгоно уу?
- А. Агаар дуслаар
 - В. Бэлгийн зам
 - С. Ихсээр
 - Д. Ахуйн хавьтлаар
 - Е. Цусаар
- /402./ Балнад өвчний эмгэг жамын өөрчлөлт зонхилон хаана гарах вэ?
- А. Шулуун гэдэс
 - В. S хэлбэрийн гэдэс
 - С. Мухар гэдэс
 - Д. Нарийн гэдэс
 - Е. Хөндлөн гэдэс
- /403./ Балнад өвчний үед аль эрхтэн зонхилон гэмтдэг вэ?
- А. Нойр булчирхай
 - В. Наран сүлжээ
 - С. Нугас
 - Д. Уртавтар тархи
 - Е. Нарийн гэдэсний тунгалгийн аппарат

- /404./ Балнад өвчний үед морфологийн ямар элемент гарах вэ?
- A. Липома
 - B. Гранулема
 - C. Туберкулома
 - D. Фиброзит
 - E. Целлулит
- /405./ Балнад өвчний үед арьсанд тууралт гарах хугацааг тэмдэглэнэ үү?
- A. Өвчний 2-7 хоногт
 - B. Өвчний 8-10 хоногт
 - C. Өвчний 14-20 дахь хоногт
 - D. Өвчний 21-с дээш хоногт
 - E. Өвчний эдгэрэх үед
- /406./ Балнад өвчний нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг сонго
- A. 1-7 хоног
 - B. 10-14 хоног
 - C. 1-2 сар
 - D. 3-4 сар
 - E. 5-6 сар
- /407./ Балнад өвчний үед эмгэг өөрчлөлт хэдэн үе шатыг дамжин явагддаг вэ?
- A. 2
 - B. 3
 - C. 4
 - D. 5
 - E. 8
- /408./ Урвах тахлын үүсгэгчийн ямар бодис усгүйжилт үүсэхэд гол үүргийг гүйцэтгэдэг вэ?
- A. Дотор хор
 - B. Гадар хор буюу холероген
 - C. Энтеротоксин
 - D. Нэвчимтгий чанарын хүчин зүйс
 - E. Лимфоцит
- /409./ Урвах тахал өвчний халдварын эх уурхай юу вэ?
- A. Өвчтэй хүн
 - B. Мэрэгчид
 - C. Ус
 - D. Гэрийн тэжээмэл амьтад
 - E. Бохир гар
- /410./ Урвах тахлын үед баасны шинж чанар ямар байх вэ?
- A. Бага хэмжээтэй, хэлбэрээ алдаагүй
 - B. Их хэмжээний хар ногоон
 - C. Цус, залхагны хольцтой
 - D. Цагаан будааны шүүс шиг
 - E. Жимсний чанамал шиг улаан
- /411./ Урвах тахлын үед өвчтөнгөөс яагаад дуу авиа гардаггүй вэ?
- A. Тэнэмэл мэдрэлийн саажилтаас
 - B. Төвөнхөд үрэвсэл үүссэнээс
 - C. Хоолойн хөвч хатсанаас
 - D. Тархи хөөж хавагнаснаас
 - E. Бульбар саа саажилтаас
- /412./ Урвах тахал өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?
- A. Sh.Flexneri
 - B. S.Typhimurium
 - C. Сонгодог ба Эль-Торын вибрион
 - D. E.Coli
 - E. Clostridium Botulinum
- /413./ Урвах тахал өвчний үед ялгардаг хор нь дараах хэсгээс бүрдэнэ
- A. Липополисахарид агуулсан дотор хор болон гадар хор

- B. Хүчтэй гадар хор буюу холероген болон дотор хор
C. Нэвчимтгий чанарын хүчин зүйл болон дотор хор
D. Липополисахарид агуулсан дотор хор, хүчтэй гадар хор буюу холероген болон нэвчимтгий чанарын хүчин зүйл
E. Clostridium Botulinum болон хүчтэй гадар хор
- /414./ Урвах тахал өвчний үед илрэх шингэн алдалтын 1-р зэргийн үед биеийн жингийн хэдэн хувийг алддаг вэ?
A. 0.5-1%
B. 1-3%
C. 3-4%
D. 4-6%
E. 6-8%
- /415./ Урвах тахал өвчний үед илрэх шингэн алдалтын 2-р зэргийн үед биеийн жингийн хэдэн хувийг алддаг вэ?
A. 4-6%
B. 6-8%
C. 7-9%
D. 8-10%
E. 10%-иас дээш
- /416./ Цочмог А гепатитийг эмнэлзүйн үе шатаар нь юу гэж ангилдаг вэ?
A. Нууц үе болон шарлалтын үе
B. Шарлалтын өмнөх болон шарлалтын үе
C. Урьдал үе болон шарлалтын үе
D. Нууц үе, шарлалтын өмнөх үе, шарлалтын үе, эдгэрэлтийн үе
E. Шарлалтын өмнөх үе, шарлалтын үе, эдгэрэлтийн үе
- /417./ Цочмог А гепатитын үед шарлалтын үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?
A. 1-7 хоног
B. 2-14 хоног
C. 2-3 долоо хоног
D. 1-2 сар
E. 1-3 сар
- /418./ Цочмог А гепатитын ид үеийн турш ямар хоол хүнс хориглох вэ?
A. Утсан, шарсан хоол хүнс
B. Буцалсан чихэртэй ус, ургамлын гаралтай өөх тос
C. Өргөст хэмх, жисний шүүс, хярам
D. Удаан шингэцтэй хонь, үхэр, гахайн өөх, утсан, шарсан, хайрсан хоол хүнс
E. 5-р ширээний хоол
- /419./ А гепатитын вирус биеэс ялгарах гол хүчин зүйлийг сонго.
A. Өтгөн
B. Шээс
C. Цэр, салсаар
D. Бөөлжис
E. Шүлс
- /420./ А гепатит бүхий өвчтөн нь өвчний аль үедээ халдвар их тараах аюултай вэ?
A. Нууц үеийн сүүлч ба шарлалтын өмнөх үед
B. Шарлалтын үед
C. Эдгэрэх үед
D. Архагших үед
E. Бүх үеийн турш
- /421./ Вируст Е гепатитын үүсгэгчийг тэмдэглэ
A. ДНХ бүхий гепаднавирус
B. РНХ бүхий пикарновирүс
C. РНХ бүхий флавиовирүс
D. РНХ бүхий калицивирүс
E. ДНХ бүхий пикарновирүс
- /422./ Цочмог Е гепатит гэдгийг батлах оношын маркерыг сонгоно уу?

- A. HBsAg
- B. Анти HBc-IgM
- C. Анти HD-IgM
- D. Анти HEV-IgM
- E. Анти HAV-IgM

/423./ Вирүст E гепатитаар ямар хүмүүс хүнд өвдөж болзошгүй вэ?

- A. Эрэгтэй хүмүүс
- B. Хүүхдүүд
- C. Залуучууд
- D. Жирэмсэн эмэгтэйчүүд
- E. Өндөр настан

/424./ Вирүст B гепатитын халдварын эх уурхайг тэмдэглэ

- A. Өвчтэй амьтад
- B. Өвчтэй хүн ба вирус хадгалагч
- C. Зөвхөн вирус хадгалагч
- D. Зөвхөн өвчтөн
- E. Бохирлогдсон зүү, тариур

/425./ Цочмог B гепатитын нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?

- A. 1-3 хоног
- B. 7-14 хоног
- C. 30-60 хоног
- D. 50-180 хоног
- E. 6 сараас дээш

/426./ Цочмог B гепатит гэдгийг батлах оношын гол маркерийг тэмдэглэнэ үү?

- A. Анти HBc-IgM
- B. Анти HA-IgM
- C. Анти HD-IgM
- D. HBsAg
- E. Анти HE-IgM

/427./ B гепатитын эдгэрэлтийг илтгэх эсрэг биеийг нэрлэнэ үү?

- A. Анти HBe
- B. Анти-HBs
- C. Анти HBc
- D. Анти-HBcIgM
- E. Анти HD

/428./ B гепатитын үүсгэгчийг тэмдэглэ

- A. PHX бүхий Флавирүс
- B. ДНХ бүхий Пикарновирүс
- C. ДНХ агуулсан гепадна вирус
- D. PHX агуулсан Калицивирүс
- E. PHX агуулсан Дельта вирус

/429./ Цочмог B гепатитын халдвар дамжих замыг сонгоно уу?

- A. Бохир гар
- B. Цус
- C. Бэлгийн зам
- D. Өтгөн мөр-ам
- E. Парентерал зам

/430./ Дельта вирүс хүний биед юуны тусламжтайгаар нэвтэрч халдварлан репликаци болох вэ?

- A. HBeAg
- B. HBsAg
- C. HBcAg
- D. HD-Ag
- E. HA-Ag

/431./ Дельта вирүсийн супер халдвар гэж аль үзэгдлийг нэрлэх вэ?

- A. B ба D вирүс хамт халдварлах

- B. В ба С вирус хамт халдварлах
 - C. HBsAg тээгчид D вирус нэмж халдварлах
 - D. С вирус тээгч В вирус нэмж халдварлах
 - E. Дельта вирус тээгчид А вирус нэмж халдварлах
- /432./ Дельта вирусийг нэрлэ.
- A. ДНХ агуулсан гепаднавирүс
 - B. РНХ агуулсан флавивирүс
 - C. РНХ агуулсан калцивирүс
 - D. РНХ агуулсан согогтой вирүс
 - E. РНХ агуулсан ортомиковирүс
- /433./ Вирүст С гепатитын халдварын эх уурхайг тэмдэглэ.
- A. Халдвартай цус плазма
 - B. Өвчтэй хүн ба вирус тээгч
 - C. Өвчтэй амьтад
 - D. Бохирлогдсон зүү, тариур
 - E. Бэлгийн зам
- /434./ Вирүст С гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийн бэлдмэл
- A. Аскорбины хүчил
 - B. Эссенциале Форте
 - C. Зовиракс
 - D. Ацикловир
 - E. Интерферон альфа
- /435./ Вирүст С гепатит гэдгийг батлах оношийн маркерийг тэмдэглэ
- A. HBsAg /+/
 - B. anti- HBc-IgM /-/
 - C. HCV RNA /+/
 - D. anti- HCV /+/
 - E. HBsAg /+/
- /436./ С гепатитийн үүсгэгчийг тэмдэглэ
- A. ДНХ агуулсан гепаднавирүс
 - B. РНХ агуулсан флавивирүс
 - C. РНХ агуулсан калцивирүс
 - D. РНХ агуулсан согогтой вирүс
 - E. РНХ агуулсан ортомиковирүс
- /437./ Цочмог С гепатитын нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?
- A. 1-3 хоног
 - B. 7-14 хоног
 - C. 30-60 хоног
 - D. 2-26 долоо хоног
 - E. 6-н сараас дээш
- /438./ С гепатит нь эмнэлзүйн дараах явцтай
- A. Эгэл ба эгэл бус
 - B. Цочмог ба архаг
 - C. Хөнгөн ба хүнд
 - D. Шарлалттай ба шарлалтгүй
 - E. Нийтлэг ба нийтлэг бус
- /439./ Симмондсийн ангилалаар гепатитын С вирүсийн генотипийн хэдэн дэд хэв (субтип) байдаг вэ?
- A. 5
 - B. 6
 - C. 9
 - D. 90
 - E. 102
- /440./ Гепатитын С вирүсийн халдварын эмнэлзүйн онцлогийг тэмдэглэ.
- A. Ихэнхдээ эмнэлзүйн хөнгөн хэлбэрээр явагддаг
 - B. Эмнэлзүйн хүнд хэлбэрээр явагдана.

- С. Эмнэлзүйн хүнд хэлбэрээр явагдаж, элэгний хатууралд хэргэдэг.
- D. Эмнэлзүйн хөнгөн хэлбэрээр явагдаж, 70-85% нь архаг хэлбэрт шилждэг
- Е. Эмнэлзүйн хүнд хэлбэрээр явагдаж, элэгний хорт хавдарт хүргэдэг.

/441./ Архаг гепатитын С вирусийн халдвартай хүмүүсийн хэдэн хувь нь 10-40 жилийн хугацаанд элэгний хатууралд шилжих магадлалтай вэ?

- A. 6-12%
- B. 8-15%
- C. 10-20%
- D. 25-35 %
- E. 30-50%

/442./ С гепатитын халдвартай өвчтөний интерферон эмчилгээний үр дүнг эмчилгээний хэд хэд дэхь долоо хоногт шинжилгээ хийж хянах вэ?

- A. 2, 4, 12 дахь долоо хоногуудад
- B. 2, 4, 24 дахь долоо хоногуудад
- C. 4, 12, 24 дахь долоо хоногуудад
- D. 4, 12, 24, 48 дахь долоо хоногуудад
- E. 4, 12, 24, 48, 72 дахь долоо хоногуудад

/443./ Гепатитын С вирусийн 1b генотип илэрсэн өвчтөнд интерферон болон рибавирины хосолсон эмчилгээг хэдий хугацаанд хийх заалттай вэ?

- A. 4 долоо хоног
- B. 8 долоо хоног
- C. 12 долоо хоног
- D. 24 долоо хоног
- E. 48 долоо хоног

/444./ Гепатитын С вирусийн халдвараас яаж урьдчилан сэргийлэх вэ?

- A. Төрсний дараа 24 цагийн дотор вакцин хийнэ
- B. 2,3,4 сартайд нь вакцин хийнэ.
- C. Өвөрмөц урьдчилан сэргийлэлт байхгүй
- D. 2,3,4 настайд нь вакцин хийнэ
- E. 8,16 насанд нь вакцин хийнэ

/445./ Балнадын үүсгэгчээс ямар хор ялгарах вэ?

- A. Экзотоксин
- B. Гемагглютинин, нейроаминдаз
- C. Эндотоксин
- D. Энтеротоксин
- E. Цитотоксин

/446./ Сальмонеллөз өвчний тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?

A. Сальмонеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг бүдүүн гэдэсний төгсгөл хэсгийг давамгайлан гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

B. Сальмонеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг ихэвчлэн ходоод, нарийн гэдэсний үрэвсэл, шингэн алдалтаар илэрдэг хүнээс хүнд дамжин халдварладаг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

C. Шигеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг бүдүүн гэдэсний төгсгөл хэсгийг давамгайлан гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

D. Шигеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг нарийн гэдэсийг сонгомлоор гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

E. Сальмонеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг ихэвчлэн ходоод, нарийн гэдэсний үрэвсэл, шингэн алдалтаар илэрдэг зооантропонозний цочмог халдварт өвчнийг хэлнэ.

/447./ Сальмонеллөз өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Sh.Flexneri
- B. S.Typhimurium
- C. Sh.Dysenteriae
- D. Coli
- E. Clostridium Botulinum

/448./ Сальмонеллөз өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн

- B. Вирус тээгч, гэрийн тэжээмэл амьтад
 - C. Нян тэгч
 - D. Өвчтэй хүн болон нян тээгчид, гэрийн тэжээмэл амьтад
 - E. Өвчтэй хүн болон вирус тээгчид
- /449./ Сальмонеллөз өвчний нууц хугацаа хэд хоног вэ?
- A. 2-3 цаг
 - B. 1-2 хоног
 - C. 2-3 хоног
 - D. 5-7 хоног
 - E. 7-10 хоног
- /450./ Сальмонеллөз өвчин ямар замаар дамжин халдварлах вэ?
- A. Парентераль зам
 - B. Өтгөн-мөр амаар
 - C. Цусаар
 - D. Эхээс урагт
 - E. Хачгинд хазуулах
- /451./ Сальмонеллөз өвчний баасны онцлогийг тэмдэглэнэ үү?
- A. Ус ихтэй, хоолны хольцтой, хөөсөрхөг, өмхий үнэртэй, ногоон өнгөтэй
 - B. Усархаг, цус залхагтай, их хэмжээтэй
 - C. Цагаан будааны шүүс шиг, ус ихтэй
 - D. Цус залхагтай, хэмжээ багатай
 - E. Ус багатай, цус залхагтай, өмхий үнэртэй
- /452./ Сальмонеллууд аль эсийн дотор үржиж чадах вэ?
- A. Энтероцит
 - B. Эритроцит
 - C. Макрофаг
 - D. Лимфоцит
 - E. Тромбоцит
- /453./ Сальмонеллууд хиам, махан бүтээгдэхүүн дотор ямар хугацаагаар амьд байж чадах вэ?
- A. 2 хоног
 - B. 3-10 хоног
 - C. 45 хоног
 - D. 180 хоног
 - E. 15-45 хоног
- /454./ Томуу өвчин ямар замаар дамжин халдварлах вэ?
- A. A. Парентераль зам
 - B. B. Парентераль зам
 - C. C. Цусаар
 - D. D. Өвчтэй хүн
 - E. E. Агаар дуслын зам
- /455./ Томуу өвчний нууц хугацааг тэмдэглэнэ үү?
- A. Хэдэн цаг
 - B. Хэдэн цагаас 1-2 өдөр
 - C. 5-7 хоног
 - D. 7-10 хоног
 - E. 11-21 хоног
- /456./ Томуу өвчний эмнэлзүй үндсэн ямар ямар хамшинжээр илэрдэг вэ?
- A. Ерөнхий хордлогын хам шинж, суулгах хам шинж
 - B. Ерөнхий хордлогын хам шинж, амьсгалын замын үрэвслийн хам шинж
 - C. Амьсгалын замын үрэвслийн хам шинж, суулгах хам шинж
 - D. Ерөнхий хордлогын хам шинж, халуурах хам шинж
 - E. Халуурах хам шинж, суулгах хам шинж
- /457./ Томуугийн үед ямар төрлийн вакцинаар урьдчилан сэргийлэх вэ?
- A. Өвөрмөц ба өвөрмөц бус
 - B. Вакцин ба иммуноглобулин

- C. Вакцин ба энгийн иммуноглобулин
- D. Үхүүлсэн ба амьд вакцин
- E. Үхүүлсэн вакцин ба иммуноглобулин

/458./ Риновирусийн халдварын тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?

A. Ерөнхий хордлогын хам шинж болон амьсгалын замын үрэвслийн хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

B. Хамрын салстын үрэвсэл давамгайлсан, ерөнхий хордлогын хам шинж багатай явагддаг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

C. Хамрын салстын үрэвсэл болон амьсгалын замын үрэвслийн хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

D. Хамрын салстын үрэвсэл болон суулгах хамшинжээр илэрдэг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

E. Амьсгалын доод замын үрэвсэл болон хамрын салстын үрэвсэл, суулгах хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ

/459./ Риновирусийн халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн
- B. Өвчтэй хүн, вирус тээгч
- C. Агаар дуслын зам
- D. Өвчтэй хүн болон нян тээгчид
- E. Хоол боловсруулах зам

/460./ Риновирусийн халдвар ямар замаар дамжин халдварлах вэ?

- A. Парентераль зам
- B. Вирус тээгч
- C. Цусаар, агаар дуслаар
- D. Өвчтэй хүн
- E. Агаар дуслын зам, хамар залгиур, нүдний салстаар

/461./ Риновирусийн халдварын эмнэлзүйн гол шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?

- A. Нус гоожих, суулгах, халуурах
- B. Халуурах, толгой өвдөх
- C. Суулгах, халуурах
- D. Халуурах, уйлагнах
- E. Нус гоожих, найтаалгах

/462./ Респиратор-Синцитиаль вирусийн халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн
- B. Өвчтэй хүн, вирус тээгч
- C. Агаар дуслын зам
- D. Өвчтэй хүн болон нян тээгчид
- E. Хоол боловсруулах зам

/463./ Респиратор-Синцитиаль вирусийн халдварын нууц хугацааг тэмдэглэнэ үү?

- A. Хэдэн цаг
- B. 2-3 хоног
- C. 4-6 хоног
- D. 5-7 хоног
- E. 7-10 хоног

/464./ Респиратор-Синцитиаль вирусийн халдварын эмнэлзүйн гол шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?

- A. Нус гоожих, халуурах
- B. Халуурах, толгой өвдөх
- C. Мөгөөрсөн хоолойн үрэвсэл
- D. Төвөнхийн үрэвсэл, Халуурах
- E. Уушги- гуурсан хоолойн хам шинж

/465./ Аденовирусийн халдварын тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?

A. Ерөнхий хордлогын хам шинж болон амьсгалын замын үрэвслийн хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

B. Хамрын салстын үрэвсэл давамгайлсан, ерөнхий хордлогын хам шинж багатай явагддаг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

С. Амьсгалын зам ба гэдэсний салст бүрхүүл, тунгалагийн эдүүдийг гэмтээж, халуурах болон бага зэргийн хордлогын хам шинжээр илэрлэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.

D. Хамрын салстын үрэвсэл болон суулгах хамшинжээр илэрдэг амьсгалын замын цочмог халдварт өвчнийг хэлнэ.

Е. Амьсгалын доод замын үрэвсэл болон хамрын салстын үрэвсэл, суулгах хам шинжээр илэрдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ

/466./ Аденовирүсийн халдвар ямар замаар дамжин халдварлах вэ?

A. А. Парентераль зам

B. В. Вирүс тээгч

C. С. Цусаар, агаар дуслaar

D. D. Өвчтэй хүн

E. E. Агаар дуслын зам, хоол боловсруулах зам

/467./ Аденовирүсийн халдварын нууц хугацааг тэмдэглэнэ үү?

A. Хэдэн цаг

B. 1-2 өдөр

C. 2-3 хоног

D. 5-6 хоног

E. 7-10 хоног

/468./ Аденовирүсийн халдварын эмнэлзүйн гол хам шинжүүдийг тэмдэглэнэ үү?

A. Суулгах хам шинж, халуурах хам шинж

B. Амьсгалын замын үрэвслийн хам шинж, нүдний салст бүрхүүлийн үрэвслийн хам шинж

C. Суулгах хам шинж, нүдний салстын үрэвслийн хам шинж

D. Халуурах хам шинж, нүдний салстын үрэвслийн хам шинж

E. Амьсгалын замын үрэвслийн хам шинж, нүдний салст бүрхүүлийн үрэвслийн хам шинж, тунгалагийн эдийн үрэвслийн хам шинж

/469./ Амьсгалын цочмог халтай хам шинжийн үеийн гол шинжийг тэмдэглэнэ үү?

A. Хамар битүүрэх

B. Амьсгал дутлын дестресс хам шинж шинж

C. Хяхнасан амьсгал

D. Толгой өвдөх

E. Хоолонд дургүй

/470./ Шувууны томуугийн хүний өвчлөл үүсгэгч вирүсийг тэмдэглэнэ үү?

A. A (H1N1)

B. A (H2N2)

C. A (H3N2)

D. A (H5N1)

E. A (H6N7)

/471./ Амьсгалын цочмог халтай хам шинжийн нууц хугацааг тэмдэглэнэ үү?

A. Хэдэн цаг

B. 1-2 өдөр

C. 2-3 хоног

D. 2-10 хоног

E. 7-14 хоног

/472./ Бруцеллез өвчний халдварын эх уурхааг тэмдэглэнэ үү?

A. Өвчтэй хүн

B. Өвчтэй мал амьтан

C. Өтөг, бууц

D. Мах, сүү

E. Арьс шир

/473./ Хүн ба амьтанд өвчин үүсгэдэг хоруу чанар нь хамгийн их бруцеллийг тэмдэглэ.

A. Br. Melitensis

B. Br. Abortus bovis

C. Br. Suis

D. Br. Ovis

E. Br. Canis

/474./ Бруцеллийн халдвар авсан болохыг илрүүлэх харшил сорил тавихад ашигладаг бодисыг тэмдэглэ.

- A. Дизеитерии
- B. Бруцеллин
- C. Антраксин
- D. Туберкулин
- E. Тулерин

/475./ Цочмог бруцеллез өвчний үед илрэхгүй шинжийг тэмдэглэ

- A. Халуурах
- B. Булчирхай цочих
- C. Ууцны үе үрэвсэх
- D. Элэг дэлүү томрох
- E. Үе мөч, ууц хуруу шархирч өвдөх

/476./ Бруцеллез өвчнийг оношлоход ашиглдаггүй аргыг сонго.

- A. Райтын урвал
- B. Хеддльсоны урвал
- C. Видалийн урвал
- D. Цус наалдуулах шууд бус урвал
- E. Фермент холбоот эсрэг биеийн урвал

/477./ Бруцеллез өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй аргыг сонго.

- A. Өвчтэй хүнийг тусгаарлах
- B. Өвчтэй малыг тусгаарлах
- C. Эрүүл малыг вакцинжуулах
- D. Халдвар авсан хүнийг вакцинжуулах
- E. Эрүүл хүнийг вакцинжуулах

/478./ Гахай хавдар өвчнийг булчирхайн томролтийн зэргээр хэд ангилах вэ?

- A. 2
- B. 3
- C. 4
- D. Хөнгөн
- E. Дунд

/479./ Гахай хавдар өвчний нууц хугацаа хэд хоног вэ?

- A. 3-7 хоног
- B. 7-10 хоног
- C. 10-14 хоног
- D. 11-23 хоног
- E. 15 хоног

/480./ Гахай хавдар өвчний үүсгэгчийг сонго

- A. Риновирус
- B. Паромиксовирус
- C. Тогавирус
- D. Нян
- E. Рубивирус

/481./ Гахай хавдрын дамжих зам юу вэ?

- A. Агаар дусал
- B. Гэмтсэн арьс салст
- C. Хоол хүнс
- D. Өтгөн мөр- ам
- E. Цус

/482./ Гахайн хавдрын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй мал
- B. Өвчтэй загас
- C. Өвчтэй хүн
- D. Вирус тээгч
- E. Нян тээгч

/483./ Халдвартай байх хугацаа гахай хавдар өвчний үед өвчин эхэлснээс хойш хэд хоног байх вэ?

- A. 3 хоног
- B. 6 хоног
- C. 7 хоног
- D. 9 хоног
- E. 15 хоног

/484./ Гахай хавдрын ид үед ямар шинж тэмдэг илрэх вэ?

- A. Мурсугийн шинж
- B. Хавдрын төв, хөхлөг сэртэн, чихний омог дээр дарахад өвчтэй байх
- C. Шүлсний булчирхай хавдана
- D. Халуурна
- E. Юм захилахад эрүүний угаар өвдөнө.

/485./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн үед хэрэглэгдэхгүй эмчилгээг заа

- A. Дулаан бүгнүүр
- B. Спиртэн бигнүүр
- C. УВЧ -гээр шарах
- D. Антибиотик
- E. Амыг буцалсан усаар зайлж байх

/486./ Сахуу өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн
- B. Өвчтэй загас
- C. Өвчтэй хүн, нян тээгч
- D. Вирус тээгч
- E. Нян тээгч

/487./ Сахуугийн үед хэрэглэгдэх өвөрмөц эмчилгээг заа

- A. Нянгийн эсрэг ийлдэс
- B. Антибиотик
- C. Иммуноглобулин
- D. Сахуугийн хорын эсрэг ийлдэс
- E. Гаммаглобулин

/488./ Сахуугийн хордлогот хэлбэрийн 1-р зэргийн үед хүзүүний хаван ямар хэмжээтэй байх вэ?

- A. Эгэм хүртэл
- B. Харахад мэдэгдэх төдий
- C. Хүзүүний дунд хүрсэн
- D. Эгэмнээс доош орсон
- E. Тэмтрэхэд мэдрэгдэнэ

/489./ Сахуу өвчин ямар замаар дамжин халдварладаг вэ?

- A. Гэмтсэн арьс салстаар
- B. Цусаар
- C. Трансмиссив зам
- D. Агаар дусал
- E. Вертикаль зам

/490./ Сахуугийн хордлогот хэлбэрийн 3-р зэргийн үед хаван ямар байх вэ?

- A. зөвхөн ам, залгиурт
- B. хүзүүний дунд хүртэл
- C. эгэм хүртэл
- D. эгэмнээс доош орсон
- E. хүзүүг тэмтрэхэд мэдрэгдэнэ

/491./ Хөөмийн сахуугийн байршмал хэлбэрийн үед өнгөрийн байршлаар нь юу гэж анилдаг вэ?

- A. Улаймал болон арал мэт хэлбэрүүд
- B. Арал болон хальс мэт хэлбэрүүд
- C. Хальс мэт хэлбэр
- D. Улаймал, арал, хальс мэт хэлбэрүүд

- Е. Улаймал болон хальс мэт хэлбэрүүд
- /492./ Төвөнхийн сахууг эмнэлзүйн шинжээр нь ямар ямар үе болгон ангилдаг вэ?
- А. Хоолой сөөх болон амьсгал бачуурлын үе
 - В. Хоолой сөөх болон бүтэлтийн үе
 - С. Амьсгал бачуурлын болон бүтэлтийн үе
 - Д. Хоолой сөөх, амьсгал бачуурал болон бүтэлтийн үе
 - Е. Амьсгал бачуурлын үе
- /493./ А гепатитын үүсгэгчийг тэмдэглэ.
- А. ДНХ бүхий гепаднавирус
 - В. РНХ бүхий пикарновирүс
 - С. РНХ бүхий флавивирүс
 - Д. РНХ бүхий калицивирүс
 - Е. ДНХ бүхий пикарновирүс
- /494./ Цочмог А гепатит гэдгийг батлах оношын маркерыг сонгоно уу?
- А. HBsAg
 - В. Анти HBc-IgM
 - С. Анти HD-IgM
 - Д. Анти HAV-IgM
 - Е. Анти HEV-IgM
- /495./ А гепатитын нууц үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?
- А. 1-3 хоног
 - В. 7-14 хоног
 - С. 10-45 хоног
 - Д. 30-180 хоног
 - Е. 180-аас олон хоног
- /496./ Цочмог А гепатитын халдвар дамжих замыг сонгоно уу?
- А. Бохир гар болон бохирлогдсон хоол хүнс
 - В. Цус
 - С. Бэлгийн зам
 - Д. Бохир гар, бохирлогдсон ус болон бохирлогдсон хоол хүнс
 - Е. Парентерал зам
- /497./ ДЭМБ-ын томъёоллоор Халдварт өвчин гэсэн тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?
- А. Тусгай үүсгэгчтэй, дамжих замтай, өөрийн эх уурхайтай, дархлал тогтдог, нууц үедээ хамгийн их халдвар тараадаг өвчин.
 - В. Шавьж болоод бусад төрлийн дамжуулагчаар амьсгалдаг агаар, уудаг ус, гишгэж явдаг газар шороогоор дамжин эсвэл шууд хавьтлаар хүн ба амьтнаас хүний бие махбодид орж үүсгэдэг өвчин.
 - С. Амьсгалдаг агаар, уудаг ус, гишгэж явдаг газар шороогоор дамжин хүн ба амьтны бие махбодид орж, тодорхой үе шатыг дамжин явагддаг дархлал тогтдог өвчин .
 - Д. Гадаад орчны тодорхой нөхцөлд, хязгаарлагдмал цаг хугацаанд үлэмж ба бичил биесийн хоорондын нарийн харилцан үйлчлэл
 - Е. Нян, вирус, шимэгч, мөөгөнцөр мэтийн эмгэгтөрүүлэгч бичил биетнээр үүсч, хүнээс хүнд шууд болоод шууд бусаар тардаг өвчнийг хэлнэ.
- /498./ Цусан суулга өвчний тодорхойлолтыг тэмдэглэнэ үү?
- А. Сальмонеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг бүдүүн гэдэсний төгсгөл хэсгийг давамгайлан гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.
 - В. Шигеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг бүдүүн гэдэсний төгсгөл хэсгийг давамгайлан гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ
 - С. Шигеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг нарийн гэдэсийг сонгомлоор гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.
 - Д. Сальмонеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг бүдүүн нарийн гэдэсний төгсгөл хэсгийг давамгайлан гэмтээдэг цочмог халдварт өвчнийг хэлнэ.
 - Е. Шигеллийн төрлийн нянгаар үүсгэгддэг хөндлөн гэдэсийг сонгомлоор гэмтээдэг цочмог халдвар өвчнийг хэлнэ.
- /499./ Цусан суулга өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?
- А. S.Enteritidis

- B. S.Typhimurium
- C. Sh. Dysenteriae
- D. E.Coli
- E. Clostridium Botulinum

/500./ Цусан суулга өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн
- B. Вирус тээгч
- C. Нян тээгч
- D. Өвчтэй хүн болон нян тээгчид
- E. Өвчтэй хүн болон вирус тээгчид

/501./ Цусан суулга өвчний нууц хугацаа хэд хоног вэ?

- A. 2-3 цаг
- B. 1-2 хоног
- C. 2-3 хоног
- D. 4-7 хоног
- E. 7-10 хоног

/502./ Цусан суулга өвчний үед эмгэг өөрчлөлт аль хэсэгт байх вэ?

- A. Нарийн гэдэсний төгсгөл хэсэгт
- B. Бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт
- C. Хөндлөн гэдэс
- D. Ходоод
- E. Бүдүүн гэдэсний төгсгөл хэсэгт

/503./ Цусан суулга өвчний баасны онцлогийг тэмдэглэнэ үү?

- A. Усархаг, өмхий үнэртэй
- B. Усархаг, язмагтай
- C. Цус залхагтай, их хэмжээтэй
- D. Цагаан будааны шүүс шиг, ус ихтэй
- E. Цус залхагтай, хэмжээ багатай

/504./ Цусан суулга өвчний эмнэлзүйн явц ямар ямар үе шатаар илэрдэг вэ?

- A. Урьдал үе, эхлэл үе, ид үе, эдгэрэх үе
- B. Урьдал үе, эхлэл үе, ид үе, эдгэрэх үе
- C. Эхлэл үе, ид үе, шинж тэмдэг буурах үе, эдгэрэх үе
- D. Эхлэл үе, ид үе, эдгэрэх үе
- E. Урьдал үе, эхлэл үе, шинж тэмдэг буурах үе, ид үе, эдгэрэх үе

/505./ Насжилттай холбоотой инсулины солилцоонд ямар өөрчлөлт илрэх вэ?

- 1. Инсулины хэмжээ ихсэнэ.
- 2. Глюкозын тэсгэл чанар буурна.
- 3. Чихрийн шимэгдэлт сайжирна.
- 4. Чихийн шижин хэвшиж 2 болох магадлал өндөр болно.
- 5. Цусны сахар багасах магадлал өндөр болно.

/506./ Насжилттай холбоотой бодисын солилцоонд ямар өөрчлөлт илрэх вэ?

- 1. Тироксины хэмжээ багасна.
- 2. Бодисын солилцоо удааширна.
- 3. Бодисын солилцоо удаашрах тул зүрхний цохилт цөөрнө, амьсгалын тоо цөөрнө, гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн удаашрах тул өтгөн хатах хандлагатай болно.
- 4. Бодисын солилцоо хурдсах тул зүрхний цохилт олшроно, амьсгалын тоо олшроно, суулгах хандлагатай болно.
- 5. Тироксины хэм жээ ихсэх болно.

/507./ Насжилттай холбоотой мэдэрлийн тогтолцоонд ямар өөрчлөлт илрэх вэ?

- 1. Тархины судас нарийсч, цусан хангамж буурч, тархины шингэний хэмжээ багассантай холбоотойтархины жин багасна.
- 2. Цох рефлексийн давтамж ихэснэ.
- 3. Ховор тохиолдолд хөхөх мэт автомат рефлекс сэргэнэ.
- 4. Брудзинскийн рефлекс эерэг болно.
- 5. Бабинскийн рефлекс эерэг болно

/508./ Насжилттай холбоотой дархлын тогтолцоонд ямар өөрчлөлт илрэх вэ?

1. T killer –ийн идэвхи ихсэх тул нян, вирусыг устгах чадвар сайжирна.
2. T killer –ийн идэвхи сулрах тул хорт хавдар үүсэх эрсдэл ихэснэ.
3. T helper –ийн идэвхи ихсэх тул тул нян, вирусыг устгах чадвар сайжирна.
4. T helper –ийн идэвхи сулрах тул нян, вирусыг устгах чадвар муудна.
5. T suppressor –ийн идэвхи ихсэх тул аутоиммун өвчинд өртөх эрсдэл буурна.

/509./ Насжилттай холбоотой биеийн хэм хэрхэн өөрчлөгддөг вэ?

1. Бодисын солилцоо хурдасдаг тул биеийн хэм 38.5 –аас дээш болдог.
2. Бодисын солилцоо удаарширдаг тул биеийн хэм буурах хандлагатай байдаг.
3. Биеийн хэм 37.5 болно.
4. Биеийн хэм 35-36 хэм болж буурдаг.
5. Дархлаа муудах тул үе үе шалтгаангүй халуурдаг.

/510./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсганд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Түүнд ямар үзлэг ба шинжилгээ хийлгэхийг зөвлөх вэ?

1. Цусанд сахар үзэх
2. Шээсний ерөнхий шинжилгээ ба сахар үзэх
3. Түрүү булчирхайг хэт авиагаар үзэх
4. Түрүү булчирхайг шулуун гэдэсний үзлэгээр хуруугаар тэмтэрч үзэх
5. ЗЦБ хийх

/511./ 75 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний ам их цангадаг, их уудаг хэрнээ цангаа гардаггүй, арьс их хуурайшдаг, өдөр их шээдэг, ба шөнө бас босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Түүнд ямар менежмент хийх вэ? Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

1. Түрүү булчирхайн томрол байх магадлалтай.
2. Чихрийн шижин байх магадлалтай .
3. Түрүү булчирхайг хэт авиагаар харах
4. Цус, шээсэнд сахар үзэх
5. Түрүү булчирхай тэмтэрч үзэх

/512./ 75 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний ам их цангадаг, их уудаг хэрнээ цангаа гардаггүй, арьс их хуурайшдаг, өдөр их шээдэг, ба шөнө бас босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Түүний цусанд сахар ихэссэн байсан. Түүнд хэрхэн туслах вэ?

1. Дотоод шүүрлийн эмчийн хяналтанд оруулна
2. Хоолны зөвлөгөө өгнө.
3. Бигуанидын бүлгийн эм уулгах
4. Простамол эсвэл Простерид уухыг зөвлөнө
5. Шөнө унтахын өмнө уух шингэний хэмжээг багасгахыг зөвлөнө.

/513./ 78 настай өвгөн халуурсан ба түүний шээс их үнэртэй, хүрэн өтгөн цай шиг өнгөтэй болсон ба ойр ойрхон шээс нь хүрч, шөнө босч шээх болсон зовиуртай. Анхан шатны эмч түүнд ямар эмчилгээ хийх вэ?

1. Уросептик эм эсвэл антибиотик хэрэглэх
2. Шингэн илүүтэй уухыг зөвлөнө, мөн ургамлын гаралтай бөөр цэвэрлэх тан уухыг зөвлөнө
3. Халуун бууруулах эм
4. Простамол уулгах
5. Тамсол уулгах

/514./ 62 настай эмэгтэй ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Өрхийн эмч түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Нас ахих тусам эмэгтэй хүний шээс задгайрах хандлагатай болдог тул ЭХЭМҮТ-ийн шээс задгайрлын кабинетэд очиж үзүүлэх ба эртхэн
2. Шингэн бага ууж байх
3. 2 цаг тутам шээж байх
4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй
5. Цистит болсон тул антибиотик, уросептик уухыг зөвлөнө.

/515./ 62 настай эмэгтэй хаврын үед харшил хүрч, хаиах, найтаах нь ихэсдэг ба ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Өрхийн эмч түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Харшлын эсрэг эм уулгах
2. Паракоденк эсвэл кодеин 6 -8 цагаар 1-3 хоног уухыг зөвлөнө
3. Давсагны хуниас булчинг чангалах дасгал зааж өгнө
4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй гэж зөвлөнө
5. Цистит болсон тул антибиотик, уросептик уухыг зөвлөнө.

/516./ 72 настай эмэгтэй ханиад туссан ба ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Тэр шээс задгайрлыг эмчлэх хагалгаанд орохыг зөвшөөрөөгүй. Өрхийн эмч түүний амьдралын чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ?

1. Ханиадыг боломжийн хэрээр хурдан эмчлэх
2. Паракоденк эсвэл кодеин 6 -8 цагаар 1-5 хоног уухыг зөвлөнө.
3. Уух шингэний хэмжээг багасгах ба шаардлагатай үедээ нэг удаагийн живх хэрэглэж байхыг зөвлөнө.
4. 2 цаг тутам шээж, давсгаа суллахыг зөвлөнө
5. Орой унтахын өмнө Амитриптиллин ууж байхыг зөвлөнө

/517./ 90 настай эмэгтэй шээхээ мартдаг ба гэнэт шээс нь хүрч, бие засах газар очиж амжилгүй өмдөндөө шээдэг болсон зовиуртай. Тэр заримдаа орондоо шээдэг. Түүний амьдралын чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ?

1. Нэг удаагийн живх өдөр бүр хэрэглэж байхыг асран халамжлагчид зөвлөнө.
2. Уух шингэний хэмжээг багасгахыг зөвлөнө
3. 2 цаг тутам шээж байхыг сануулж, шээлгэж байхыг асран халамжлагчид зөвлөнө
4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй болохыг ойлгуулна.
5. Нас ахих тусам эмэгтэй хүний шээс задгайрах хандлагатай болдог тул ЭХЭМҮТ-ийн шээс задгайрлын кабинетэд очиж үзүүлэх ба эртхэн хагалгаанд орох нь дээр болохыг зөвлөнө.

/518./ 63 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Кальц, Даминдэмийн бэлдмэл уух
2. Сүү цагаан идээ кальцаар баялаг тул илүүтэй хэрэглэх
3. Хөнгөн хэлбэрийн дасгалыг өдөр бүр тогтмол хийдэг байх
4. Унаж бэртэх эрсдэл өндөр тул ямар ч дасгал хөдөлгөөн хийж болохгүй. Ясны сийрэгжилт арилтал хэвтэрт байх.
5. Паратгормон уух.

/519./ 63 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 20% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Кальц, Даминдэмийн бэлдмэл уух.
2. Сүү цагаан идээнд суулгалт үүсдэггүй бол кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэх.
3. Тохирсон гутал, гувцас өмсөөд явган алхах мэтийн хөнгөн хэлбэрийн дасгалыг аюулгүй, хальтаргаагүй орчинд өдөр бүр тогтмол хийдэг байх эсвэл чийрэгжүүлэлтийн кабинетэд очиж үзүүлээд нөхөн сэргээх эмчийн зөвлөсний дагуу дасгалуудыг хийх.
4. Яс сийрэгжилтийг зогсоох зорилгоор Осталон Кальцтай, Даминдэмтэй хамт уух эсвэл бифосфонатын эмийн бүлгээс хэрэглэх
5. Эмэгтэй хүнд зориулсан аминдэм, эрдэс давсны бүрдмэлээс, жишээ нь, “One daily for women” хоногийн хэрэгцээ хангах тунгаар тогтмол уудаг байх.

/520./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хоног. Түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Эмийн эмчилгээг зогсоох.
2. Ердийн сүү, цагаан идээ хэрэглэхийг зогсоох.
3. Боломжтой бол лактозгүй сүү, цагаан идээ хэрэглэхийг зөвлөх.
4. Кальцийн бэлдмэлийг зогсоох.
5. Д аминдэм хэрэглэхийг зогсоох.

/521./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсанд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний хаван шөнө бууснаас шээс элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/522./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Орой болоход түүний хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний дутагдал, хаван шөнө бууснаас шээс шөнө элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/523./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хонов. Тэр ямар шалтгаантай суулгасан бэ?

- A. Кальцийн бэлдмэл уусан тул
- B. Сүү нь муудсан тул суулгасан
- C. Лактазацийн дутагдалтай тул суулгасан
- D. Дисбактериоз болсон тул
- E. Д аминдэм суулгуулдаг тул

/524./ 70 настай өвгөн өөртөө үйлчлэх чадвартай тул өөрөө өглөөний цай ундаа уудаг ба өдөр өөртөө лапшаа, будаатай шөл мэтийн хөнгөн хоол хийж иддэг. Хоолны завсраар хааяа талх, боов иддэг. Өвгөнийг хүүхдүүд нь гэртэй орхиод өглөө бүр ажилдаа явдаг. Оройн хоолыг хүүхдүүд нь хийдэг ба гэр бүлээрээ иддэг байв. Нэг өглөө өвгөн босоод өглөөний ундаа уух гэтэл ямар ч талх, боов, боорцог байсангүй. Будаа агшаах гэтэл будаа дууссан байв. Хөргөгчинд мах дууссан болохыг өвгөн анзаарч, 10 цагаас дэлгүүр онгойход дэлгүүр явж мах, будаа, талх авахаар шийдэв. Гэтэл түүнд маш бага мөнгө байсан тул тэр мах хямдхан бөөнддөг нилээд зайтай дэлгүүр явахаар шийдэв. Тэр 10 цаг болоход гэрээс гарч дэлгүүр зорьсон боловч, дэлгүүр 11 цагаас онгойв. Хүлээсээр байгаад дэлгүүрт орход махаа цавчихыг хүлээх болов. Тэр өглөөнөөс хойш юу ч идээгүй байсан тул ухаан нь орон гаран боллоо. Тэр гэртээ харих гэсэн боловч төөрчээ. Цагийн дараа өвгөн гудамжинд дэмий юм ярж, зорчигчдыг харааж, үе үе чарлаж байв. Түүнд юу тохиолдсон бэ?

- A. Тэр төөрсөн тул ууралсан.
- B. Тэр дэмийрч солиорсон.
- C. Тэр тэнэгрэл зөнөгрөлтэй байсан тул өвчин нь хөдөлсөн.
- D. Тэр өлсөж ууралсан.
- E. Түүний шизофрени хөдөлсөн.

/525./ 70 настай өвгөн өөртөө үйлчлэх чадвартай тул өөрөө өглөөний цай ундаа уудаг ба өдөр өөртөө лапшаа, будаатай шөл мэтийн хөнгөн хоол хийж иддэг. Хоолны завсраар хааяа талх, боов иддэг. Өвгөнийг хүүхдүүд нь гэртэй орхиод өглөө бүр ажилдаа явдаг. Оройн хоолыг хүүхдүүд нь хийдэг ба гэр бүлээрээ иддэг байв. Нэг өглөө өвгөн босоод өглөөний

ундаа уух гэтэл ямар ч талх, боов, боорцог байсангүй. Будаа агшаах гэтэл будаа дууссан байв. Хөргөгчинд мах дууссан болохыг өвгөн анзаарч, 10 цагаас дэлгүүр онгойход дэлгүүр явж мах, будаа, талх авахаар шийдэв. Гэтэл түүнд маш бага мөнгө байсан тул тэр мах хямдхан бөөнддөг нилээд зайтай дэлгүүр явахаар шийдэв. Тэр 10 цаг болоход гэрээс гарч дэлгүүр зорьсон боловч, дэлгүүр 11 цагаас онгойв. Хүлээсээр байгаад дэлгүүрт орход махаа цавчихыг хүлээх болов. Тэр өглөөнөөс хойш юу ч идээгүй байсан тул ухаан нь орон гаран боллоо. Тэр гэртээ харих гэсэн боловч төөрчээ. Цагийн дараа өвгөн гудамжинд авцалдаагүй, дэмий юм ярж, зорчигчдыг харааж, үе үе чарлаж байв. Тэр яагаад дэмийрсэн бэ?

- A. Тэр тэнэгрэл зөнөгрөлтэй байсан тул.
- B. Шизофренид байсан тул
- C. Өлссөн ба цусны сахар багассан тул
- D. Хордлого болсон тул.
- E. Баас хатсан тул.

/526./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдүүт боргоцой шиг ургацтай. Гүвдүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний үеэр явахад өвддөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/527./ Геронтологи гэж юуг судалдаг шинжлэх ухаан бэ?

- 1. Насжилттай холбоотой биологийн асуудлууд
- 2. Эрүүл урт удаан наслах асуудлууд
- 3. Насжилттай холбоотой сэтгэц-нийгмийн асуудлууд
- 4. Настанд тохиолдох өвчнөөс сэргийлэх, эмчлэх аргууд
- 5. Настанд тохиолдох өвчин судлал

/528./ Нас дагаж хүний судсанд ямар өөрчлөлт илэрдэг вэ?

- 1. Судсанд атеросклероз үүсдэг
- 2. Судас хатуурдаг
- 3. Судас нарийсдаг
- 4. Судас өргөсч даралт буурдаг
- 5. Судасжилт сайжирч, ухаан суудаг

/529./ Нас дагаж хүний биеийн судаснууд нарийсан, хатууран, эрхтэн тогтолцооны цусан хангамж муудсанаар ямар өөрчлөлтүүд илэрдэг вэ ?

1. Тархины цусан хангамж муудсанаар тархины жин багасана, ой санамж мууддаг, уймарч будилдаг, настанд зөнөх, тэнэгэрэх шинжүүд илэрдэг.

2. Нүдний цусан хангамж муудсанаар харааны мэдрэлд өөрчлөлт орж, хараа мууддаг, нүд хуурайших, аргах, нүдний алим багасах, зовхи унах шинжүүд илэрдэг

3. Чихний цусан хангамж буурснаар сонсголын мэдрэл суларч, сонсгол мууддаг.

4. Зүрхний цусан хангамж муудсанаар зүрхэнд склерозын процесс явагддаг, зүрхний агшилтын хүч, тоо цөөрдөг.

5. Бөөрний цусан хангамж муудсанаар бөөрний жин багасч, түүдгэнцэрийн тоо цөөрнө, бөөрний судсаар эргэлдэх цусны хэмжээ багасна, түүдгэнцэрийн ялгаруулалт муудна, шээс ховордоно

/530./ Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ хэрхэн өөрчлөгддөг вэ ? Энэ нь ямар үр дагавартай вэ ?

1. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул цус өтгөрдөг, биеийн жин багасдаг

2. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул арьс хуурайшиж, үрчийдэг.

3. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ багасдаг тул гэдэс, ходоодны шүүрэл багасч, хоол боловсруулалт мууддаг.

4. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ ихэсдэг тул даралт ихсэх хандлагатай байдаг.

5. Нас ахих тусам хүний биед агуулагдах усны хэмжээ ихэсдэг тул тархи хавагнах ба тэнэгрэл, зөнөгрөл болох хандлагатай байдаг.

/531./ Нас ахих тусам хүний яс, булчингийн тогтолцоонд ямар өөрчлөлт гардаг вэ ? Энэ нь ямар үр дагавартай вэ ?

1. Булчингийн хүч муудаж, хатингарших хандлагатай болно.

2. Ясны ус, калцийн хэмжээ багассанаас яс сийрэг, хугарамтгай болно.

3. Нурууны яс сийрэгжихээс гадна, нугаламууд нимгэрч, завсрын жийргэвч хатууран нимгэрснээр нуруу богиносон, өтлөх тусам намхан болдог.

4. Нурууны нугаламууд нимгэрч, завсрын жийргэвч хатууран нимгэрснээр хүнд ачаа даах чадваргүй болдог, жийргэвч мултрах аюултай болдог.

5. Шүдний яс сийрэгжин, үүрэмтгий, хугарамтгай болдог.

/532./ Цэвэршиж дууссан эмэгтэйд ямар шинжүүд илэрч болох вэ?

1. Сэтгэл санаа нь тогтворгүй, уур уцаартай болох, шалтгаан тодорхойгүй бухимдах, амархан гомдож, уйламтгай болох, өчүүхэн зүйлээс болж сэтгэл түгших, гутрах, нойр алдах зэрэг шинжүүд

2. Гэнэт дээшээ халуу хөөрч, нүүр нь улайж, хөлрөх

3. Сарын тэмдэг бүр мөсөн зогсох

4. Шээс задгайрах хандлагатай болох

5. Яс сийрэгжин, үе үе янгинаж өвдөх, хугарамтгай болох

/533./ Настанд яагаад сэтгэл гутрах эмгэг элбэг тохиолддог вэ?

1. Тэтгэвэрт гарсаныг нийгэмд хэрэггүй боллоо гэж үздэг.

2. Өмнө нь хийж чадаж байсан зүйлээ хийж чадахгүй дээ бухимддаг

3. Нас дагаж биед гарах өөрчлөлтүүдээс (хараа, сонсгол муудах, арьс үрчийх, хөгшрөлтийн шинжүүд илрэх) болж гутардаг

4. Үеийн найз нөхдийн дунд нас барах тохиолдол ихсэж байгааг хараад гутардаг.

5. Тэтгэвэрт гарснаар өрхийн орлого багасах, өрхийн тэргүүн, тэжээгч байхаа больсондоо гутардаг

/534./ Настанд арьсаа хөгшрүүлэхгүйн тулд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Шингэн сайн уух, шинэ жимс, ногоо сайн идэх

2. Наранд нүцгэн удаан байж болохгүй, зун өргөн саравчтай малгай өмсөх.

3. Чийгшүүлэх чанартай тос хэрэглэх, тосон иллэг хийлгэх

4. Шар усаа хатаахын тулд наранд сайн гарч байх

5. Усанд өдөр бүр орж байх

/535./ Түрүү булчирхай нь томорсон настанд ямар шинжүүд илрэх вэ?

1. Томорсон түрүү булчирхай давсгийг дарж буй тул давсаг дүүрсэн мэт санагдан, ойр ойрхон шээс хүрнэ.

2. Шөнө босж шээдэг болно.

3. Шээсний урсгал сул болно.

4. Дүлж шээдэг болно.

5. Шээсний дараа давсаг сулраагүй мэт санагдана

/536./ Нас ахих тусам сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадварт ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Зөвхөн сүүтэй цайгаар хоол хийж, өөр хоол идэхгүй болно

2. Гэдсэнд лактаза исэгийн дутагдал үүсдэг тул сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадвар буурдаг

3. Настай болох тусам зөвхөн сүү уудаг болно

4. Сүү уухад суулгадаг болно.

5. Хөгшчүүл хүүхэдтэй ижил түл сүүгээр л хооллох болно

/537./ Насанд хүрсэн эрүүл монгол хүний цусны ийлдэсний глюкозын лавламж хэмжээг заана уу?

A. 3,11 (2,21-7,10) ммоль/л

B. 5,23 (4,13-6,01) ммоль/л

C. 6,33 (3,62-7,02) ммоль/л

D. 4,29 (2,56-6,02)ммоль/л

Е. 4,00 (2,15-3,60) ммоль/л

/538./ Настан яагаад сүү цагаан эдээ хэрэглэж байх ёстой вэ?

1. Хөгшрөлтөөс сэргийлдэг тул
2. Сүү цагаан эдээ шингээхдээ настан илүү сайн тул
3. Зүрхний титэм судасны хомсдлоос сэргийлдэг тул
4. Кальцаар баялаг тул ясны сийрэгжилтээс сэргийлдэг тул
5. Тархины цусан хангамжийг сайжруулдаг тул

/539./ Нас ахих тусам хоол боловсруулах тогтолцоонд ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Шүд муутай болдог
2. Ходоод гэдэсний шүүрэл багасдаг тул хоол боловсруулах чадвар мууддаг
3. Лактаза ферментийн дутагдал үүсдэг тул сүүг боловсруулах, шингээх чадвар мууддаг
4. Лактаза ферментийн идэвхи сайжирдаг тул сүүг боловсруулах, шингээх чадвар сайжирдаг.
5. Их хэмжээний хоол идэх шаардлагатай болдог.

/540./ Хөгшрөлт гэж ямар процессыг хэлэх вэ?

1. Календарын наснаас түрүүлж насжилтын шинжүүд илрэх
2. Хүсэл, мөрөөдөл, амьдралын төлөвлөгөө, зорилго нь цөөрөх ба амьдралд хандах идэвхи нь буурах
3. Календарны наснаас түрүүлж нийгмийн идэвхи буурах
4. Календарны наснаас түрүүлж бэлгийн чалх буурах
5. Календарны наснаас түрүүлж оюун санаа муудах, тэнэгрэл, зөнөгрөл үүсэх.

/541./ Настанд эрүүл урт удаан наслах талаар өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх ёстой вэ ?

1. Тэтгэвэрт гарсандаа сэтгэл ханамжтай, тайван байх, хийсэн, бүтээснээрээ бахархаж, өөртөө итгэлтэй байх.
2. 3 цагаан хорыг (чихэр, давс, өөх) хоол хүнснээс хязгаарлах, аминдэм, эрдсээр баялаг жимс, ногоо, сүү, цагаан идээ сайн идэх ба лаазалсан, шуузалсан, даршилсан хүнс хэрэглэхгүй байхыг хичээх.
3. Биеийн тамирын дасгалыг тогтмол хийдэг байх, цэвэр агаарт явган алхадаг байх
4. Архи, тамхинаас хол байх
5. Амьдралдаа зорилготой, сэтгэл ханамжтай байх ба тогтмол сурч, нийгмийн идэвхитэй байх.

/542./ Настанд дараах аминдэмийн бүрдлээс алийг өгөх нь тохиромжтой вэ?

1. Ундавит
2. Гериавит
3. Остеовитал
4. Прегнавит
5. Гендавит

/543./ Настанг яс сийрэгжилтээс сэргийлэхийн тулд ямар аминдэмийн бүрдэл уулгах вэ?

1. Ревит
2. Ундавит
3. Прегнавит
4. Остеовитал
5. Гендавит

/544./ Настанг ганцаардал, сэтгэл гутралаас сэргийлэхийн тулд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Тэтгэвэрт гарсанаар гавъяаныхаа амралтыг эдэлж, сэтгэл хангалуун байх
2. Ач, зээ нарынхаа амьдрал, хүмүүжилд идэвхитэй оролцож байх.Тэд нартаа сайхан дурсамжуудаасаа ярьж өгөх, зурагтай альбомоо тайлбарлах, ном уншиж өгч байх.
3. Ахмадын клубт очиж шатар, даалуу, бильярд тоглодог байх, явган аялал, гүйлтийн марафонд оролцох.
4. Хүүхдүүдтэйгээ цэвэр агаарт зуслан гарч жимс, мөөг түүх, загасчлах
5. Өрхийн эмчийн сайн дурын туслагчаар ажиллаж, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход оролцох.

/545./ Нас дагаж хүний тархи, толгойд ямар өөрчлөлт илрэх вэ?

1. Үс бууралтана
2. Үс унамхай, хугарамтгай, хуурай болно, халзан болох магадлалтай

3. Тархи жижигрэнэ, тархины жин буурна
 4. Тархины атираа гүнзгий болно
 5. Ой санамж, шинэ зүйлийг сурах чадвар буурна
- /546./ Цусны ийлдэсний төмөр ихэсдэг эмгэгүүдийг заах
1. Цус задрах үйл явц /гемолиз/
 2. Гломерулонефрит /тархмал хэлбэрийн/
 3. Халдварт гепатит өвчин
 4. Уушигны гемосидероз
 5. Кортикостероид даавар их хэрэглэснээс
- /547./ Нас ахих тусам хүний бөөрөнд ямар өөрчлөлт гарах ба энэ нь ямар уршигтай вэ?
1. Бөөрний холтослог давхрага нимгэрнэ
 2. Бөөрний жин багасч, түүдгэнцэрийн тоо цөөрнө
 3. Үйл ажиллагаатай нефроны тоо 10 жил тутам 10% цөөрдөг.
 4. Түүдгэнцэрийн ялгаруулалт мууддаг тул бөөрний шүүх үйл ажиллагаа буурна
 5. Эмийг насанд хүрэгсдийн тунгаар хэрэглэх нь бөөрний ялгаруулах үйл ажиллагаа муудсантай холбоотой, эмийг биед хуримтлагдахад хүргэдэг.
- /548./ Нас ахих тусам эмэгтэйчүүдийн шээс бэлгийн замд ямар өөрчлөлт илэрдэг вэ?
1. Эмэгтэй настангийн давсагний булчин сулардагтай холбоотой ханиах, найтаах үед шээс дусагнах хандлагатай болдог.
 2. Эмэгтэй настангийн хөх хатингаршиж жижгэрдэг.
 3. Эмэгтэй хүний гадна бэлэг эрхтний өөхөн эд багасдаг.
 4. Үтрээний ялгаралт багасдаг тул үтрээ хуурайшиж, хатингаршил үүснэ.
 5. Хөхний хавдар, умайн хүзүүний хавдар үүсэх магадлал ихэсдэг.
- /549./ Нас ахих тусам эрэгтэйчүүдийн шээс, бэлгийн замд ямар өөрчлөлт илэрдэг вэ?
1. Настай эрэгтэйчүүдийн түрүү булчирхай томордог
 2. Настай эрэгтэйчүүдийн үрийн шингэний гаралт буурна
 3. Түрүү булчирхай давсаг дарж, ойр ойрхон шээс хүрэх, шөнө босч шээх, шээсний хүч сулрах шинж илрэнэ
 4. Түрүү булчирхай томорсноор шээсний сүвийг дарж, шээс дүлж гарах, шээс тасалдаж гарах, давсан дутуу сулрах мэт шинж илэрнэ
 5. Настай эрэгтэйчүүдийн бэлгийн чалх буурна, бэлэг эрхтэн хөвчрөх нь багасна
- /550./ Нас ахах тусам элэгний үйл ажиллагаанд ямар өөрчлөлт илрэх вэ?
1. Элэгний хоргүйжүүлэх үйл ажиллагаа мууддаг
 2. Элэгний хоргүйжүүлэх үйл ажиллагаа мууддаг тул архи даахаа больно, амархан согтдог эсвэл хорддог болно
 3. Элэгэнд эмийн метаболизм удааширдаг тул эмэнд хордох эрсдэл өндөр болдог ба эмийн тунг харьцангуй багаар бодож өгөх хэрэгтэй болно
 4. Элэг томорч хамраас цус гарамтгай болдог
 5. Элэгэнд эмийн метаболизм хурдасдаг тул эмийг илүү их тунгаар хэрэглэх шаардлагатай болно
- /551./ Нас ахих тусам хүний нүд ба хараанд ямар өөрчлөлт орох магадлал өндөр байдаг вэ?
1. Зовхи унжина
 2. Нүдний алим багасдаг
 3. Нүдний алим багасдаг тул нүд орчмын арьс үрчийнэ
 4. Ойрын хараа мууддаг тул ном сонин уншихад харааны шил хэрэгтэй болдог
 5. Хүүхэн хараа нарийсах, болор цайрах хандлагатай болно
- /552./ Настангийн хамар ба үнэрлэх чадварт ямар өөрчлөлт илэрдэг вэ?
1. Нас ахих тусам үнэрлэх мэдрэмж буурна
 2. Хамрын салст бүрхүүл хуурайшиж, хатингаршина
 3. Хамрын дайвар хөндийн салс хуурайшиж, гайморит үүсэх эрсдэл нэмэгдэнэ
 4. Нас ахих тусам хамрын салст бүрхүүл нэвчимхий болох тул нусанхай болно
 5. Нас ахих тусам хамрын дайвар хөндийнүүд хатингаршиж арилна
- /553./ Нас ахих тусамд чих ба сонсголд ямар өөрчлөлт илрэх магадлалтай вэ?
1. Хэнгэрэг хатуурна
 2. Сонсгол муудна
 3. Өндөр давтамжтай дуу чимээг сонсох чадвар буурна, шуугианд мэдрэг болно

4. Шивнээг сонсохдоо сайжирдаг боловч, чанга дууг сонсохгүй

5. Шөнийн сонсгол сайжирч, өдрийн сонсгол мууддаг

/554./ Насжилттай холбоотой уушгинд ба амьсгалын тогтолцоонд ямар өөрчлөлт үүсэх магадлалтай вэ?

1. Уушгины уян хатан чанар буурна

2. Амьсгалын багтаамж буурдаг

3. Ханиалгах рефлекс сулардаг

4. Судсанд хүчил төрөгчийн даралт буурна

5. Амьсгалын замын хамгаалах үйл ажиллагаа мууддаг.

/555./ Насжилттай холбоотой гарч буй зүрх судасны өөрчлөлт нь ямар өвчний эрсдлийг нэмэгдүүлдэг вэ?

1. Зүрхний шигдээс

2. Артерийн гипертензи

3. Тархинд цус харвах

4. Зүрх судасны архаг дутагдал

5. Эрхтэн тогтолцооны цусан хангамж муудах ба хатингарших, хатуурах эмгэгүүд

/556./ Насжилттай холбоотой яс булчингийн тогтолцоонд ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Насжилттай холбоотой яс сийрэгжинэ

2. Насжилттай холбоотой шүд унаж, цөөрнө

3. Үений мөгөөрсөн жийргэвч элэгдэж, нимгэрнэ.

4. Настанд “ногоон мөчрийн” хугаралт элбэг тохиолддог

5. Ясны ус нь ихэсдэг тул яс уян зөөлөн болдог.

/557./ Насжилттай холбоотой яс булчингийн тогтолцоонд гардаг өөрчлөлт нь ямар уршигтай вэ?

1. Нас ахих тусам эмгэг хугаралт үүсэх эрсдэл ихсэнэ

2. Настай хүний ташаа болон өвдөг нь зогсохдоо хазайх хандлагатай. Настай хүний алхаа гишгээ багасч, богиносно.

3. Үений жийргэвч нимгэрэх тул, хүнд ачаа даах чадвар буурна. Хүнд ачаа өргөх гэж оролдох үед нурууны жийргэвч мултрах аюултай.

4. Нурууны жийргэвч нимгэрсэнтэй холбоотой залуудаа өндөр байсан хүн нас ахих тусам намхан болох магадлалтай.

5. Бугуйны, богтосны хазайлтын зэрэг ихэснэ, нуруу бөгтөр болох магадлал ихэсдэг.

/558./ Настай хүн ямар шалтгаанаар дэмийрч болох вэ?

1. Өлсөх ба цусны сахар багасах

2. Өтгөн хатах

3. Шээс хаагдах

4. Халдвар авах

5. Хордлого болох

/559./ 66 настай эмэгтэй нилээд махлаг ба шатаар дээш өгсөх үед амьсгааддаг ба өвдөгний нүдрүү хатгуулж өвддөг болсон байв. Түүний өвдөгний өвдөлтийн шалтгааныг ялган оношлохын тулд ямар шинжилгээ хийх ёстой вэ?

1. Өвдөгний рентген шинжилгээ.

2. АСЛО, СРБ, RF

3. Ясны сийрэгжилтийг тогтоох шинжилгээ

4. Цусны ерөнхий шинжилгээ, бүлэгнэлт ба тромбоцитын хэмжээ

5. Шээсний ерөнхий шинжилгээ, шээсэнд урат, оксолат үзэх

/560./ 66 настай эмэгтэй нилээд махлаг ба шатаар дээш өгсөх үед амьсгааддаг ба өвдөгний нүдрүү хатгуулж өвддөг болсон байв. Түүний өвдөг яагаад өвддөг болсон байх магадлал илүү ихтэй вэ?

1. Өвдөг биеийн жингээ даахгүй болсон тул.

2. Өвдөгний үений жийргэвч элэгдэж, нимгэрсэн тул.

3. Өвдөгний үенд остеоартрит буюу үрэвсэл үүссэн тул.

4. Тулай өвчний улмаас.

5. Өвдөгний сүрьеэ өвчтэй тул.

/561./ Остеоартрит ямар үе шаттай явагддаг вэ?

1. Эхний шатанд үений мөгөөрс илэгдэж, нимгэрдэг.

2. Дараагийн шатанд элэгдсэн яснаас простогландин мэтийн үрэвслийн медиатор ялгарна.

3. Дараагийн шатанд үрэвслийн медиатор үений шингэнд хуримтлагдсаар үрэвсэл үүсч, үе хавагнах, өвдөх шинж үүсгэнэ.

4. Үений шингэнд шээсний хүчил хуримтлагдаж, үе хавдаж, үрэвсэж, өвдөнө.

5. Үений ясанд хүүтэн буглаа үүснэ.

/562./ Настанд ууц, нурууны остеоартрит ямар шалтгаанаар үүсдэг ба, ямар шинжээр илэрдэг вэ?

1. Хүнд жин, ачаа удаан хугацаагаар өргөх, биеийн жин их байх.

2. Бөхийж, өндийх, хүнд ачаа өргөх ажил хийдэг байх.

3. Нурууны нуглам завсрын жийргэвч мөгөөрс нь элэгдэх ба нимгэрэх.

4. Нурууны нуглам завсрын жийргэвч нимгэрсэнтэй холбоотой хөдөлгөөний явцад нугаснаас гарч буй мэдэрлийн ёзоор дарагдах, хавчигдах эрсдэл үүсэх.

5. Нурууны хөдөлгөөнтэй холбоотой хатгуулах өвдөлт үүсэх.

/563./ Ямар настан тулайгаар өвчлөх эрсдэл өндөр байдаг вэ?

1. Мах, ялангуяа дотор мах (элэг, бөөр, тархи), өндөг их иддэг.

2. Шингэн бага уудаг ба шээсээр урат, оксалат байнга гардаг.

3. Арьсан дээр цагаан батга ба тулайн борогцоонууд ургах хандлагатай.

4. Стрептококкийн архаг халдвартай.

5. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй.

/564./ Ясны сийрэгжилтээс сэргийлэх зорилгоор настай хүнд ямар хоол хүнс илүүтэй зөвлөх вэ?

1. Лактозгүй сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэх

2. Жимс, ногоо илүүтэй хэрэглэх

3. Загасны тос, оливын тос, чацарганы тос бага багаар хэрэглэх

4. Өөх тостой мах, махан бүтээгдэхүүн хэрэглэх

5. Кола, Пепси, Спрайт зэргийн хийтэй ундаа уух

/565./ Өвчтөн А. 72 настай, бөөрний архаг үрэвсэлтэй ба үе үе ампициллин, амоксациллин, цефазолин, ципрофлоксацин уудаг. Гэтэл үмхий үнэртэй, салсархаг, хөөсөрхөг, заримдаа цусан судалтай суулгаж эхэлсэн ба хэвлийгээр бага зэрэг өвдөх шинж илэрч, энэ нь 10 хоногоос удаан үргэлжилсэн. Тэр ямар шалтгаантай суулгалт вэ?

A. Дизентери буюу Клебсиеллын шалтгаантай

B. Стафилококкийн шалтгаантай

C. Clostridium difficile –ийн шалтгаантай

D. Escherichia coli шалтгаантай

E. Дисбактериозын шалтгаантай

/566./ 82 настай эмгэн насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр зөнөсөн тул заримдаа ач нараа танихгүй, элдэв юм ярьдаг. Түүнийг хүүхдүүд нь хооллохгүй бол өөрөө хоолоо идэх, халбагдах чадваргүй болсон. Шээс нь задвайрсан тул нэг удаагийн живх хэрэглэдэг. Хувцасаа өмсөх чадвар муудсан, товчны нүхээ олдоггүй тул хүүхдүүд нь хувцасладаг. Түүний шээс өтгөн хүрэн өнгөтэй, өмхий үнэртэй байсан ба шээсний тестерт нитрат ихтэй гарсан байна. Бусад үзүүлэлтүүд хэвийн байв. Тэр ямар өвчтэй байх өндөр магадлалтай вэ?

A. Хатгалгаа

B. Үжил

C. Бөөр, шээсний замын халдвар

D. Хоолны хордлого

E. В вирусын гепатит

/567./ 83 настай эмэгтэй насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Түүнийг хэвтрийн цооролтоос урьдчилан сэргийлэхийн тулд C аминдэмийг хоногт ямар тунгаар уулгах ёстой вэ?

A. 50 мг

B. 100 мг

C. 200 мг

D. 500 мг

E. 1000 мг

/568./ Геронтологи гэж юуг судалдаг шинжлэх ухаан бэ?

1. Насжилттай холбоотой биологийн асуудлууд
2. Эрүүл урт удаан наслах асуудлууд
3. Насжилттай холбоотой сэтгэц-нийгмийн асуудлууд
4. Настанд тохиолдох өвчнөөс сэргийлэх, эмчлэх аргууд
5. Настанд тохиолдох өвчин судлал

/569./ Түрүү булчирхай нь томорсон настанд өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Түрүү булчирхай томорсон шалтгааныг тогтооно (үрэвсэл, хавдар, томролт?)
2. Түрүү булчирхайн томролтыг үнэлэх олон улсын асуумжийн аргыг ашиглана.
3. Хэрэв 10 оноо хүрэхгүй бол уролог эмчид үзүүлж зөвлөгөө авна, хэрэв 10 –аас дээш оноотой бол яаралтай шинжилгээ хийлгэж хагалгаанд орох эсэхийг шийдвэрлэнэ.
4. Бэлгийн харьцаанд орохгүй байхыг зөвлөнө.
5. Давсганд байнгын катетер тавина.

/570./ Ханиах, найтаах, цочих, чанга инээх болгонд доошоо шээс нь дусагнаад байгаа настай эмэгтэйд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Хоногт уух шингэний хэмжээг багасгах
2. 2 цаг тутам шээж, давсгаа сулалж байх.
3. Хярзангийн булчин чангалах дасгалыг байнга хийж байх
4. Хоол, нойрны дэглэмийг сахиж, турж эцэхгүй байх
5. А, Е, В аминдэмийн комплекс курсээр уух

